



*МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН*  
**2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН**

*2025 ОНЫ 07 ДУГААР САРЫН 09-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ*

# **ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ**

**НЭГДСЭН ХУРАЛДААН**



## **ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС**

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

**НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
**2025 оны 07 дугаар сарын 09-ний өдөр, Лхагва гараг**

|                                                                                                                                                                                                                                                                                                            |                |
|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------|
| <b>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</b>                                                                                                                                                                                                                                                                     | 1-2            |
| <b>Хуралдааны товч тэмдэглэл:</b>                                                                                                                                                                                                                                                                          | 3-41           |
| <b>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</b>                                                                                                                                                                                                                                                                   | 42-125         |
| <hr/>                                                                                                                                                                                                                                                                                                      |                |
| <b>1.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин, О.Цогтгэрэл, А.Ариунзаяа, Б.Бат-Эрдэнэ, Х.Булгантуяа нарын гишүүд өргөн мэдүүлсэн, нэгтгэсэн төсөл, эцсийн хэлэлцүүлэг/</b> | 43-52          |
| <b>2.Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай</b>                                                                                                                                                                                                                       | 52-55          |
| <b>3.“Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.07.07-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</b>                                                                                                                                    | 55-67          |
| <b>4.Харьяатын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг нарын 9 гишүүн 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</b>                                                                                     | 68-69<br>84    |
| <b>5.Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.07.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</b>                                                                                                                                                 | 69-70          |
| <b>6.Хот байгуулалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан 2025.05.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</b>                                                                 | 70-72<br>84    |
| <b>7.Зарим Байнгын хорооны даргыг сонгох тухай</b>                                                                                                                                                                                                                                                         | 72-76<br>85-86 |
| <b>8.Монгол Улсын Их Хурлын зарим дэд хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай</b>                                                                                                                                                                                                                     | 76-81<br>86-89 |

|                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                              |         |
|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------|
|                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                              | 81-84   |
| <b>9.“Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл</b>                                                                                                                                                                                                                                                                                                                        | 89-90   |
| <b>/Засгийн газар 2025.07.07-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</b>                                                                                                                                                                                                                                                                                                                                                 | 94-96   |
|                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                              | 109-110 |
| <b>10.Хуулийн төсөл эцэслэн батлах</b>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                       | 90-94   |
| <b>11.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2025.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, дөрөв дэх хэлэлцүүлэг/</b> | 96-109  |
| <b>12.Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай/</b>                                                                                                                                                                                                                                                       | 110-111 |
| <b>13.Зарим Байнгын байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай</b>                                                                                                                                                                                                                                                                                                                                                  | 111-112 |
| <b>14.Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар батлах тухай/</b>                                                                                                                                                                                                                                                         | 112-114 |
| <b>15.Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай/</b>                                                                                                                                                                                                                                                                                                 | 115-116 |
| <b>16.Баталсан хуулийн эцсийн найруулгыг танилцуулах</b>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                     | 116-120 |
| <b>17.Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы хаалтын ажиллагаа</b>                                                                                                                                                                                                                                                                                                                                           | 121-125 |

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы  
07 дугаар сарын 09-ний өдөр /Лхагва гараг/-ийн  
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дэд дарга Х.Булгантуяа ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 69 гишүүн ирж, 54.8 хувийн ирцтэйгээр хуралдаан 08 цаг 07 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Ж.Ганбаатар, Л.Мөнхбаясгалан, Б.Мөнхсоёл, Р.Сэддорж, Д.Үүрийнтуяа, Д.Энхтүвшин;

Чөлөөтэй: Т.Аубакир, Б.Батцэцэг, Б.Бейсен, Л.Оюун-Эрдэнэ;

Эмнэлгийн чөлөөтэй: Н.Алтанхуяг, Э.Бат-Амгалан, С.Лүндэг, З.Мэндсайхан, Б.Чойжилсүрэн, Р.Эрдэнэбүрэн;

Тасалсан: С.Ганбаатар, Б.Энхбаяр, Ж.Энхбаяр;

Хоцорсон: О.Алтангэрэл-19 минут, Ч.Анар-1 цаг 28 минут, Ц.Баатархүү-1 цаг 28 минут, М.Бадамсүрэн-25 минут, Ж.Батсуурь-13 минут, Н.Батсүмбэрэл-06 минут, Х.Баттулга-3 цаг 52 минут, П.Батчимэг-10 минут, Э.Батшугар-10 минут, Х.Болормаа-01 минут, Э.Болормаа-25 минут, Ш.Бямбасүрэн-1 цаг 28 минут, С.Бямбацогт- 51 минут, Ж.Галбадрах-02 минут, Г.Ганбаатар-06 минут, Д.Ганбат-37 минут, П.Ганзориг-1 цаг 28 минут, Л.Гантөмөр-2 цаг 59 минут, Ц.Даваасүрэн-15 минут, Т.Доржханд-24 минут, Б.Жаргалан-1 цаг 28 минут, Д.Жаргалсайхан-41 минут, С.Замира-36 минут, Ж.Золжаргал-02 минут, Ц.Мөнхбат-22 минут, Ц.Мөнхтуяа-11 минут, П.Наранбаяр-15 минут, М.Нарантуяа-Нара-02 минут, О.Номинчимэг-21 минут, Э.Одбаяр-53 минут, С.Одонтуяа-1 цаг 33 минут, Б.Пунсалмаа-51 минут, О.Саранчулуун-05 минут, Н.Учрал-34 минут, Г.Хосбаяр-05 минут, Б.Хэрлэн-09 минут.

**Нэг.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд** /Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин, О.Цогтгэрэл, А.Ариунзаяа, Б.Бат-Эрдэнэ, Х.Булгантуяа нарын гишүүд өргөн мэдүүлсэн, нэгтгэсэн төсөл, **эцсийн хэлэлцүүлэг**/

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар танилцуулав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Бум-Очирын тавьсан асуултад Ёс зүй, дэгийн байнгын хорооны дарга Б.Баярбаатар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Бум-Очир, Б.Пүрэвдорж, Б.Баярбаатар нар үг хэлэв.

*Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

**1.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төслийн талаар:**

**Х.Булгантуяа:** Нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийн 7 дахь заалт буюу 27 дугаар зүйлийн 27.5 дахь хэсгийн 27.5.1-27.5.7, 27.5.12, 27.5.14, 27.5.15 дахь заалтыг төслийн 1 дүгээр зүйлийн 8 дахь заалт болгон шилжүүлж, 3 дугаар зүйлийн 7 дахь заалтын 27.5.8-27.5.11 дэх заалт, 27.5.13 дахь заалтыг, мөн зүйлийн 27.5 дахь хэсгийг хасаж, төслийн 4 дүгээр зүйлийн ““32” гэж,” гэсний дараа “27 дугаар зүйлийн 27.5.1 дэх заалтын “тагнуул болон гүйцэтгэх” гэснийг “тагнуулын болон цэргийн тагнуулын байгууллагын гүйцэтгэх” гэж,” гэж, мөн зүйлийн ““23.9-23.12” гэж,” гэсний дараа “27 дугаар зүйлийн 27.5.1 дэх заалтын дугаарыг “27.5.10” гэж, 27.5.2, 27.5.3 дахь заалтын дугаарыг “27.5.8, 27.5.9” гэж, 27.5.4, 27.5.5 дахь заалтын дугаарыг “27.5.11, 27.5.13” гэж,” гэж нэмж, төсөлд доор дурдсан агуулгатай 8 дугаар зүйл нэмэх:

**“8 дугаар зүйл.**Энэ хуулийн 1 дүгээр зүйлийн 8 дахь заалтын 27 дугаар зүйлийн 27.5.12 дахь заалтыг, 3 дугаар зүйлийн 6 дахь заалт буюу 27 дугаар зүйлийн 27.3.6 дахь заалтын “Хууль сахиулах ажиллагааны тусгай хяналтын,” гэснийг, 4 дүгээр зүйлийн 27 дугаар зүйлийн 27.5.1 дэх заалтад орсон өөрчлөлтийг 2026 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

|             |    |
|-------------|----|
| Зөвшөөрсөн: | 65 |
| Татгалзсан: | 20 |
| Бүгд:       | 85 |

76.5 хувийн саналаар дэмжигдлээ.

**2.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төслийн талаар:**

**Х.Булгантуяа:** 1.Нэгтгэсэн төслийн 4 дүгээр зүйлийн “70 дугаар зүйлийн” гэсний өмнө “64 дүгээр зүйлийн 64.2 дахь хэсгийн “Тухайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн” гэснийг “Ерөнхий сайд” гэж, 69 дүгээр зүйлийн 69.2 дахь хэсгийн “хоёр” гэснийг “гурав” гэж,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 69  
 Татгалзсан: 16  
 Бүгд: 85  
 81.2 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Нэгтгэсэн төсөлд доор дурдсан агуулгатай 5 дугаар зүйл нэмж, 5, 6, 7 дугаар зүйлийн дугаарлалтыг өөрчлөх:

**“5 дугаар зүйл.**Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.9 дэх хэсгийн “энэ хуулийн 71.13-т заасан дүгнэлтийн хамт” гэснийг хассугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71  
 Татгалзсан: 14  
 Бүгд: 85  
 83.5 хувийн саналаар дэмжигдлээ.

**3.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төслийн талаар:**

**Х.Булгантуяа:** 1.Нэгтгэсэн төслийн 2 дугаар зүйлийн "тухай хуулийн" гэсний дараа “21 дүгээр зүйлийн 21.3.1 дэх заалтын “нэг дэх” гэснийг “нэг, хоёр дахь” гэж, 21.3.2 дахь заалтын “хоёр” гэснийг “гурав” гэж” гэж, мөн зүйлийн “24 дүгээр зүйлийн” гэсний өмнө “23 дугаар зүйлийн гарчгийн, 23.1 дэх хэсгийн “нэг дэх” гэснийг “нэг, хоёр дахь” гэж, мөн зүйлийн 23.3 дахь хэсгийн “нэг дэх” гэснийг “хоёр дахь” гэж, 24 дүгээр зүйлийн гарчгийн, мөн зүйлийн 24.1 дэх хэсгийн “Хоёр” гэснийг “Гурав” гэж,” гэж, мөн зүйлийн ““Тамгын газрын” гэсний өмнө “, 25 дугаар зүйлийн 25.3 дахь хэсгийн” гэж нэмж, мөн зүйлийн “Энэ хуулийн 22.1.2, 22.1.3-т заасан асуудлаар” гэснийг, мөн зүйлийн “энэ хуулийн 22.1-д заасан асуудлаар” гэснийг, төслийн 3 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 72  
 Татгалзсан: 14  
 Бүгд: 86  
 83.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Нэгтгэсэн төслийн 2 дугаар зүйлийн “тухай хуулийн” гэсний дараа “14 дүгээр зүйлийн 14.1.2 дахь заалтын “Ерөнхий сайдын сар бүрийн” гэснийг “Улсын Их Хурлын асуулгын хүрээнд хийх” гэж,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 72  
 Татгалзсан: 14  
 Бүгд: 86  
 83.7 хувийн саналаар дэмжигдлээ.

**4.Цагдаагийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

**Х.Булгантуяа:** Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2026 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71  
Татгалзсан: 15  
Бүгд: 86  
82.6 хувийн саналаар дэмжигдлээ.

**5.Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

**Х.Булгантуяа:** Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2026 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 73  
Татгалзсан: 13  
Бүгд: 86  
84.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 08 цаг 31 минутад хэлэлцэж дуусав.*

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2-т заасны дагуу хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулав.*

**Х.Булгантуяа:** 1.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 76  
Татгалзсан: 13  
Бүгд: 89  
85.4 хувиар буюу Улсын Их Хурлын нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

**Хамт өргөн мэдүүлсэн:**

**Х.Булгантуяа:** 2.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 77  
Татгалзсан: 12  
Бүгд: 89

86.5 хувиар буюу Улсын Их Хурлын нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

**Х.Булгантуяа:** 3.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 77  
Татгалзсан: 12  
Бүгд: 89

86.5 хувиар буюу Улсын Их Хурлын нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

**Х.Булгантуяа:** 4.Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 73  
Татгалзсан: 16  
Бүгд: 89

82.0 хувиар буюу Улсын Их Хурлын нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

**Х.Булгантуяа:** 5.Цагдаагийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 74  
Татгалзсан: 15  
Бүгд: 89

83.1 хувиар буюу Улсын Их Хурлын нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

**Х.Булгантуяа:** 6.Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 75  
Татгалзсан: 14  
Бүгд: 89

84.3 хувиар буюу Улсын Их Хурлын нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

**Х.Булгантуяа:** 7.Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 74  
Татгалзсан: 15  
Бүгд: 89

83.1 хувиар буюу Улсын Их Хурлын нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.



**Х.Булгантуяа:** 8.Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 72

Татгалзсан: 18

Бүгд: 90

80.0 хувиар буюу Улсын Их Хурлын нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

**Х.Булгантуяа:** 9.Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 75

Татгалзсан: 15

Бүгд: 90

83.3 хувиар буюу Улсын Их Хурлын нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

### ***Баталсан хуулийн эцсийн найруулгыг танилцуулах***

Улсын Их Хурлын дэд дарга Х.Булгантуяа дараах хуулиудын эцсийн найруулгыг танилцуулав. Үүнд:

1.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./08:36/

### ***Хамт өргөн мэдүүлсэн:***

2.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./08:36/

3.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./08:36/

4.Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./08:37/

5.Цагдаагийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./08:37/

6.Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./08:37/

7.Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./08:37/

8.Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./08:37/

9.Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./08:37/

*Уг асуудлыг 08 цаг 37 минутад хэлэлцэж дуусав.*

***Хоёр.Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай***

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ц.Баянмөнх, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул нар байлцав.

Улсын Их Хурлын дэд дарга Х.Булгантуяа “Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” Улсын Их Хурлын *тогтоолын төслийг танилцуулав.*

*Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.*

**Х.Булгантуяа:** “Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 59

Татгалзсан: 33

Бүгд: 92

64.1 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын дэд дарга Х.Булгантуяа “Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./08:48/

*Уг асуудлыг 08 цаг 48 минутад хэлэлцэж дуусав.*

**Гурав.** *“Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.07.07-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/*

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар, Нийслэлийн санхүү, эдийн засаг, хөгжлийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх төсөл, хөтөлбөрийн зохицуулагч Л.Хосбаяр, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга М.Үнэнбат, Нэгдсэн төслийн удирдлагын газрын захирал Э.Түвшинжаргал, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, мөн газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх А.Болортуяа, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Сангийн сайд Б.Жавхлан, төслийг хэлэлцэх эсэх талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Д.Пүрэвдаваа, Г.Уянгахишиг, Ц.Мөнхбат, Да.Цогтбаатар, Б.Пүрэвдорж нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхбат үг хэлэв.

*Улсын Их Хурлын дэд дарга Б.Пүрэвдорж 09 цаг 05 минутаас 09 цаг 35 минутад хуралдааныг даргалав.*

**Б.Пүрэвдорж:** Байнгын хорооны саналаар “Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 61

Татгалзсан: 36

Бүгд: 97

62.9 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пунсалмаа, Ж.Галбадрах нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 97 гишүүнээс 63 гишүүн дэмжиж, 64.9 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

“Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 09 цаг 34 минутад хэлэлцэж дуусав.*

*Үдээс өмнөх хуралдаан 1 цаг 27 минут үргэлжилж, 09 цаг 35 минутад завсарлав.*

*Үдээс хойших хуралдаан 13 цаг 35 минутад эхлэв.*

*Улсын Их Хурлын дэд дарга Б.Пүрэвдорж 13 цаг 35 минутаас 13 цаг 59 минутад хуралдааныг даргалав.*

***Дөрөв.Харьяатын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг нарын 9 гишүүн 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/***

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Л.Батмөнх, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны референт Л.Хурцбилэг нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт асууж, үг хэлээгүй болно.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./13:40/*

***Тав.Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.07.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Ж.Дэлгэрсайхан, Р.Ринчинбазар, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, мөн газрын Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур,

Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Г.Алтанцэцэг, Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалан танилцуулав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт асууж, үг хэлээгүй болно.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 13 цаг 44 минутад хэлэлцэж дуусав.*

***Зургаа.Хот байгуулалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан 2025.05.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/***

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ц.Баянмөнх, Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргалын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц хариулж, тайлбар хийв.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./13:50/*

### ***Долоо.Зарим Байнгын хорооны даргыг сонгох тухай***

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Б.Нандингэрэл, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын ажлын албаны ахлах зөвлөх Х.Энэбиш нар байлцав.

Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудлаар Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбат, Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Л.Энхнасан, Өргөдлийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Ганмаа нар тус тус танилцуулав.

*Улсын Их Хурлын дэд дарга Х.Булгантуяа 13 цаг 59 минутаас 17 цаг 53 минутад хуралдааныг даргалав.*

Байнгын хороодын санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт асууж, үг хэлээгүй болно.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./14:02/*

***Найм.Монгол Улсын Их Хурлын зарим дэд хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай***

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул нар байлцав.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг, Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг, Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ч.Номин, Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал, Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд нар тус тус танилцуулав.

Байнгын хороодын санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт асууж, үг хэлээгүй болно.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./14:13/*

***Ес. “Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.07.07-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар, Нийслэлийн санхүү, эдийн засаг, хөгжлийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх төсөл, хөтөлбөрийн зохицуулагч

Л.Хосбаяр, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга М.Үнэнбат, Нэгдсэн төслийн удирдлагын газрын захирал Э.Түвшинжаргал, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх А.Болортуяа, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшингийн тавьсан асуултад Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга нар хариулж, тайлбар хийв.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./14:27/*

***Харьяатын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг нарын 9 гишүүн 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн/-ийн анхны хэлэлцүүлгийг санал хураалтаар үргэлжлүүлэн хэлэлцэв.***

**Х.Булгантуяа:** Байнгын хорооноос гаргасан, Харьяатын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

|             |     |
|-------------|-----|
| Зөвшөөрсөн: | 61  |
| Татгалзсан: | 43  |
| Бүгд:       | 104 |

58.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Харьяатын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 14 цаг 29 минутад хэлэлцэж дуусав.*

***Хот байгуулалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан 2025.05.02-ны өдөр өргөн мэдүүлсэн/-ийн анхны хэлэлцүүлгийг санал хураалтаар үргэлжлүүлэн хэлэлцэв.***

**Х.Булгантуяа:** Байнгын хорооноос гаргасан, Хот байгуулалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 62

Татгалзсан: 42

Бүгд: 104

59.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Хот байгуулалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 14 цаг 32 минутад хэлэлцэж дуусав*

**Зарим Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудлыг санал хураалтаар үргэлжлүүлэн хэлэлцэв.**

**Х.Булгантуяа:** 1.Байнгын хорооны саналаар Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны даргаар Ганзоригийн Тэмүүлэнг улируулан сонгохыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 67

Татгалзсан: 37

Бүгд: 104

64.4 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Байнгын хорооны саналаар Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Бадрахын Найдалааг сонгохыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 60

Татгалзсан: 44

Бүгд: 104

57.7 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Байнгын хорооны саналаар Өргөдлийн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Одсүрэнгийн Номинчимэгийг сонгохыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 63

Татгалзсан: 41

Бүгд: 104

60.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Байнгын хорооны даргыг улируулан сонгох тухай” Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцож, Улсын Их Хурлын тогтоолыг танилцуулав.



Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Зарим Байнгын хорооны даргыг сонгох тухай” Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцож, Улсын Их Хурлын тогтоолыг танилцуулав.

Улсын Их Хурлын дэд дарга Х.Булгантуяа “Байнгын хорооны даргыг улируулан сонгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./14:41/

Улсын Их Хурлын дэд дарга Х.Булгантуяа “Зарим Байнгын хорооны даргыг сонгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./14:41/

Уг асуудлыг 14 цаг 41 минутад хэлэлцэж дуусав.

**Монгол Улсын Их Хурлын зарим дэд хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай асуудлыг санал хураалтаар үргэлжлүүлэн хэлэлцэв.**

**Х.Булгантуяа:** “Монгол Улсын Их Хурлын зарим дэд хорооны бүрэлдэхүүний тухай Улсын Их Хурлын тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 70

Татгалзсан: 34

Бүгд: 104

67.3 хувийн саналаар Улсын Их Хурлын тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын дэд дарга Х.Булгантуяа “Монгол Улсын Их Хурлын зарим дэд хорооны бүрэлдэхүүний тухай Улсын Их Хурлын тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./14:46/

Уг асуудлыг 14 цаг 46 минутад хэлэлцэж дуусав.

**“Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.07.07-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжлэл/**

“Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай” “Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлэг асуудлаар Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл 30 минутын завсарлага авах тухай мэдэгдэж, Улсын Их Хурлын дэд дарга Х.Булгантуяа 30 минутын завсарлага өгөв./14:49/

**Арав.Хуулийн төсөл эцэслэн батлах**

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Г.Алтанцэцэг, Л.Батмөнх, Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам нар байлцав.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2-т заасны дагуу хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулав.*

**Х.Булгантуяа:** 1.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 73

Татгалзсан: 31

Бүгд: 104

70.2 хувиар буюу Улсын Их Хурлын нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

***Хамт өргөн мэдүүлсэн:***

2.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 29

Татгалзсан: 75

Бүгд: 104

27.9 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар дэмжигдсэнгүй.

Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй тул Улсын Их Хурлын дэд дарга Х.Булгантуяа “Хуулийн төсөл буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцож, Улсын Их Хурлын *тогтоолыг танилцуулав./14:55/*

3.Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 64

Татгалзсан: 40

Бүгд: 104

61.5 хувиар буюу Улсын Их Хурлын нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

4.“Алт-3 аяныг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53

Татгалзсан: 51

Бүгд: 104

51.0 хувиар буюу Улсын Их Хурлын нийт гишүүний олонхын саналаар тогтоол батлагдлаа.

5.Харьяатын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 68

Татгалзсан: 36

Бүгд: 104

65.4 хувиар буюу Улсын Их Хурлын нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

***Хамт өргөн мэдүүлсэн:***

6.Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 67

Татгалзсан: 37

Бүгд: 104

64.4 хувиар буюу Улсын Их Хурлын нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

7.Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 72

Татгалзсан: 32

Бүгд: 104

69.2 хувиар буюу Улсын Их Хурлын нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

8.Хот байгуулалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 67

Татгалзсан: 37

Бүгд: 104

64.4 хувиар буюу Улсын Их Хурлын нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

***Хамт өргөн мэдүүлсэн:***

9.Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 73

Татгалзсан: 31

Бүгд: 104

70.2 хувиар буюу Улсын Их Хурлын нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

10.Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 70  
Татгалзсан: 34  
Бүгд: 104

67.3 хувиар буюу Улсын Их Хурлын нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

11.Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71  
Татгалзсан: 33  
Бүгд: 104

68.3 хувиар буюу Улсын Их Хурлын нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

12.Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 61  
Татгалзсан: 43  
Бүгд: 104

58.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Х.Булгантуяа:** Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 67  
Татгалзсан: 37  
Бүгд: 104

64.4 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Х.Булгантуяа:** Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 71  
Татгалзсан: 33  
Бүгд: 104

68.3 хувиар буюу Улсын Их Хурлын нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

**Хамт өргөн мэдүүлсэн:**

13.Банкны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 70

Татгалзсан: 34

Бүгд: 104

67.3 хувиар буюу Улсын Их Хурлын нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

14.Агаарын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 69

Татгалзсан: 35

Бүгд: 104

66.3 хувиар буюу Улсын Их Хурлын нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

15.Усны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 72

Татгалзсан: 32

Бүгд: 104

69.2 хувиар буюу Улсын Их Хурлын нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

16.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71

Татгалзсан: 33

Бүгд: 104

68.3 хувиар буюу Улсын Их Хурлын нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

17.Автотээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 69

Татгалзсан: 35

Бүгд: 104

66.3 хувиар буюу Улсын Их Хурлын нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

18.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 70

Татгалзсан: 34

Бүгд: 104

67.3 хувиар буюу Улсын Их Хурлын нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

19.Жолоочийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 70  
Татгалзсан: 34  
Бүгд: 104

67.3 хувиар буюу Улсын Их Хурлын нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

20.Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71  
Татгалзсан: 33  
Бүгд: 104

68.3 хувиар буюу Улсын Их Хурлын нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

21.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 73  
Татгалзсан: 31  
Бүгд: 104

70.2 хувиар буюу Улсын Их Хурлын нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

22.Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71  
Татгалзсан: 33  
Бүгд: 104

68.3 хувиар буюу Улсын Их Хурлын нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

*Уг асуудлыг 15 цаг 06 минутад хэлэлцэж дуусав.*

*Чуулганы нэгдсэн хуралдаан 15 цаг 06 минутаас 17 цаг 06 минутад завсарлав.*

*“Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай “Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлэг асуудлаар Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл намын бүлгээс авсан завсарлага дууссаныг мэдэгдэж, үг хэлэв./17:11/*

**Арван нэг.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2025.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, дөрөв дэх хэлэлцүүлэг/**

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх А.Болортуяа, Ё.Энхсайхан, Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, Хяналт шалгалтын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн референт Д.Гэрэлт-Од нар байлцав.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.1, 10 дугаар 10.2, 10.5-д заасны дагуу Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зүйл, заалт бүрээр уншиж, зүйл тус бүрээр санал хураалт явуулав.*

**Х.Булгантуяа:**

### **МОНГОЛ УЛСЫН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн дараах зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**1/3 дугаар зүйл:**

**“3 дугаар зүйл.** Монгол Улсын төсөвт 2025 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа болон бусад байгууллага доор дурдсан хэмжээтэй орлогыг төвлөрүүлнэ:

25.Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./18:21/

26.“Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэл, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./18:22/

27.“Төрийн үйлчилгээнд процессын дахин инженерчлэл хийх ажлыг эрчимжүүлэх талаар чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./18:22/



28.“Зээлийн хүүг бууруулах хүрээнд авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./18:22/

29.“Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./18:22/

30.“Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./18:22/

31.“Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./18:23/

*Уг асуудлыг 18 цаг 23 минутад хэлэлцэж дуусав.*

***Арван долоо.Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы хаалтын ажиллагаа***

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Г.Анар-Эрдэнэ, А.Болортуяа, Д.Нямбаяр, Ж.Түвшинжаргал, Ё.Энхсайхан, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, Менежментийн газрын дарга Т.Нармандах, Парламентын сурталчилгааны хэлтсийн дарга Ж.Эрдэнэбаяр нар байлцав.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганыг хааж үг хэлэв.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгаланг үг хэлж дууссаны дараа Монгол Улсын Төрийн дууллыг “Их хуралдай” танхимд эгшиглүүлэхэд хуралдаанд оролцогсод суудлаасаа босож хүндэтгэл үзүүлэв.

*Уг асуудлыг 18 цаг 34 минутад хэлэлцэж дуусав.*

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 17 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, Хуралдаан зохион байгуулах хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

*Хуралдаан 4 цаг 27 минут үргэлжилж, 126 гишүүнээс 107 гишүүн хүрэлцэн ирж, 85.9 хувийн ирцтэйгээр 18 цаг 34 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

ЕРӨНХИЙ НАРИЙН

БИЧГИЙН ДАРГА

Б.БААСАНДОРЖ

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ

ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**

**2025 оны 07 дугаар сарын 09-ний өдөр, Лхагва гараг  
Төрийн ордон “Их хуралдай” танхим  
10 цаг 05 минут**

### **НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

---

**Х.Булгантуяа:** Улсын Их Хурлын гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгаж энэ өдрийн хуралдааны ирц 126-аас 69. 54.8 хувийн ирцтэйгээр өнөөдрийн хуралдааныг нээе.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Өнөөдрийн хуралдаанаар дараах 17 асуудлыг хэлэлцэнэ.

Нэгдүгээрт, Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгдсэн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Хоёрт, Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай асуудлыг хэлэлцэнэ.

Гуравт, “Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Дөрөвд, Харьяатын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Тавд, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Зургаад, Хот байгуулалтын тухай хуулийн хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Долоод, “Зарим Байнгын хорооны даргыг сонгох тухай” асуудлыг хэлэлцэж,

Наймд, “Монгол Улсын Их Хурлын зарим дэд хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” асуудлыг хэлэлцэж,

Ес. “Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Аравд, Хуулийн төслүүдийг эцэслэн батална.

Арван нэгд, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай

хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн дөрөв дэх хэлэлцүүлгийг хийнэ.

Арван хоёрт, “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах зарам арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Арван гуравд, “Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Арван дөрөвд, “Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Арван тавд, “Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Арван зургаад, Баталсан хууль, тогтоолын эцсийн найруулгыг сонсоно.

Арван долоод, Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы хаалт явагдана.

**Ингээд эхний асуудалдаа оръё. Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгдсэн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулъя.**

Төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ёс зүй, дэгийн байнгын хорооны дарга Баярмагнайн Баярбаатар танилцуулна. Индэрт урьж байна.

**Б.Баярбаатар:** Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин, О.Цогтгэрэл, А.Ариунзаяа, Б.Бат-Эрдэнэ, Х.Булгантуяа нарын гишүүдээс Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2025 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаараа хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн болно.

Байнгын хороо Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийг баримтлан явуулсан болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2.2.1-д зааснаар хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулахаар өгсөн чиглэлийн дагуу 1 санал, 42.2.2-т заасан анхны хэлэлцүүлгээр дэмжигдсэн болон хуулийн төслийн зүйл, хэсэг, заалт өөр хоорондоо, эсхүл бусад хуультай

зөрчилдсөн талаар хууль зүйн дүгнэлтийг Хууль зүйн байнгын хорооны 2025 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн дэмжсэнтэй холбогдуулан 6 санал, нийт 7 зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулж, Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг хуулийн төсөлд нэмж тусган төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дараалал, бүтцийн шинжтэй засварыг хийж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төслүүд, Байнгын хорооны танилцуулга, зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны танилцуулга болон зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг хэлэлцэн шийдвэрлэж, хуулийн төслүүдийг эцэслэн баталж өгөхийг та бүхнээсээ хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**Х.Булгантуяа:** Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилсан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна. 3 гишүүний нэр ирсэн байна.

Улсын Их Хурлын гишүүн Дуламын Бум-Очир.

**Д.Бум-Очир:** Гишүүддээ өглөөний мэнд хүргэе. Энэ хуулийн төслийн 20.30 дээрх заалт дээрээс асуулт асуух гэсэн юм. Энэ нэгдсэн хуралдаанд худал мэдээлэл ирүүлэх тухай, худал, буруу, ташаа мэдээлэл танилцуулах тухай асуудал байгаа. Тэгэхдээ энэ дээр зөвхөн нэгдсэн хуралдаанд гээд заачихсан байгаа. Байнгын хорооны хуралдаануудыг энд оруулах боломж байгаагүй юм уу? Хуулийнхаа үзэл баримтлалаас арай өөр гэж үзсэн юм уу? Өөрөөр хэлбэл, эндээс харах юм бол нэгдсэн хуралдаан дээр худал мэдээлэл ирүүлэхгүй байх тухай болчхоод Байнгын хорооны хуралдаан дээр худал мэдүүлэг, мэдээлэл ирүүлж болох ч юм шиг ийм хийдэл гэх үү, завсар гэх үү юм үлдчихээд байх юм. Энийг зохицуулах боломж байгаагүй юм уу, эс үгүй бол тусад нь өөр хуулийн төслөөр зохицуулах гэж байгаа юм уу? Бодвол энийг анзаарсан болов уу гэж бодох юм. Энэ дээр товчхон хариулт авах гэсэн юм.

**Х.Булгантуяа:** Байнгын хорооны дарга Баярбаатар дарга асуултад хариулъя.

**Б.Баярбаатар:** Бум-Очир гишүүний асуултад хариулъя. Ажлын хэсгийн түвшинд энийг бас нэлээдгүй өндөр түвшинд ярьсан юм. Яг худал мэдээлэл гэж, илт нуун дарагдуулах гээд 2 зүйл дээр ярилцаад тэгээд Байнгын хорооны хуралдаан дээр хэт энэ худал мэдээлэл гэдэг дор ямар нэгэн байдлаар бусдыг өөр зорилгоор ашиглах, эс үгүй бол хэлмэгдүүлэх гэсэн ийм зүйлүүд бас гарах эрсдэлийг тооцсон учраас нэгдсэн хуралдаан дээр ямар нэгэн байдлаар худал мэдээлэл Байнгын хороон дээр тодорхой түвшинд ялангуяа төсөвтэй холбоотой

тоо, статистик зүйлүүд ярьж байгаад бэлдэж өгсөн мэдээллийн дагуу буруу тоо ярихыг үгүйсгэхгүй. Энийгээ дараа нь нэгдсэн хуралдаан дээр засаж орж ирэх ийм боломжийг нь үлдээсэн нь дээр.

Санамсаргүйгээр асуудал танилцуулаад асуулт, хариулт явуулж байгаа үед бас тодорхой түвшинд ганц тоо алдаад хэлчихсэн тохиолдолд тэрийг худал мэдээлэл гэж үзээд ингээд бас хариуцлага тооцох хэмжээний асуудал руу хөтөлчих вий дээ гэдэг ийм болгоомжлолыг ажлын хэсэг дээр бас ярьсан учраас бас Байнгын хороон дээр ер нь тодорхой мэтгэлцээнүүд зүйлүүд нэлээдгүй явагддаг учраас энэ агуулгаар нь оруулж ирсэн байж байгаа.

**Х.Булгантуяа:** Бум-Очир гишүүн нэмж тодруулъя.

**Д.Бум-Очир:** Ойлголоо. Гэхдээ энэ дээр ийм жаахан зөрүү л гарчих гээд байна л даа. Нэгд тэр санамсартай, санамсаргүй гэдгийг яаж тогтоох юм бэ? Энэ чинь ард нь нэг хүний хариуцлага яригдах гээд байгаа юм. Уг нь мэдээж санаа нь зөв. Гэхдээ сая бас Баярбаатар гишүүн хариулж байна Байнгын хорооны дарга санамсартай, санамсаргүй гэдгээ яаж тогтоох юм бэ? Энэ чинь ард нь нэг хүний хариуцлагын тухай асуудал яригдана. Тэгэхээр албаар юм уу, санамсартай гэдгээ нэгд тодруулах тийм арга, зарчим байх юм уу нэгдүгээрт?

Хоёрдугаарт яг одоо байгаагаар Байнгын хороон дээр худал мэдээлэл өгч болно, чуулган дээр худал мэдээлэл өгч болохгүй гэдэг л ийм л ялгаа гарчих гээд байх шиг санагддаг юм. Уг нь аль аль нь л энэ Их Хурлын тухай хуультайгаа холбоотой, аль аль нь л Их Хурлын үйл ажиллагаа юм шиг л санагдах юм даа.

**Х.Булгантуяа:** Үг хэллээ Бум-Очир гишүүн.

Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдорж.

**Б.Пүрэвдорж:** Гишүүдийнхээ энэ өглөөний амгаланг айлтгая. Тэгэхээр энэ хуулийн дагуу бас тодорхой хэмжээгээр түр хороо байгуулах, түр хорооныхоо даргалах эрхийг сөрөг хүчиндээ өгч болохоор ийм хуулийн зохицуулалт орж ирж байгаа. Урьд нь 7 удаа түр хороо байгуулагдсан боловч харамсалтай нь ямар ч үр дүнгүй араас нь нэхдэггүй. Өөрөөр хэлбэл, эрх баригч нар өөрсдийнхөө булхайтай үйл явдлыг шалгасан учраас тэрний дараа хариуцлага тооцогддоггүй ийм л түр хороонууд явсан. Ганц нэг нь л гайгүй болсон байх. Бусад нь өөрсдийнхөө хийсэн янз янзын асуудлыг, булхайг дарах зориулалттай л хийгдсэн гэж ойлгодог.

Тэгэхээр энэ түр хороо байгуулах, түүнийхээ даргалах энэ эрхийг сөрөг хүчин авснаар энэ төрийн өмчийн компаниуд дээр үе шаттайгаар түр хороо байгуулж бараг л энэ манай сөрөг хүчний гишүүд бүгдээрээ шахуу энэ төрийн өмчийн компаниуд дээр түр хороо байгуулж шалгалт хийнэ. Өнгөрсөн хугацаанд энэ төрийн өмчийн компаниуд ямар ч үр дүнгүй ажилладаг, хэн нэгэн Их Хурлын гишүүн, дарга нар, сайд нарын хүн нь очиж тэр компанийг өөрийнхөө хувийн компаниас адгийн байдлаар идэж уудаг ийм л байгууллага болгож хувирсан. Ихэнх компаниуд бүгд, төрийн өмчийн компаниуд бүгдээрээ тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулж, ямарваа нэгэн чөлөөт зах зээлгүйгээр тэр нь бизнесийг давуу эрхээр хийдэг.

Гэвч давуу эрхтэй энэ компаниуд дөнгөж 5-хан хувийн ашигтай ихэнх нь ажилладаг. Ашигтай ажиллалаа гэхэд. Ихэнх нь ашиггүй ажилладаг. Ийм л 100 гаруй компанийн бараг 70-аад нь, 80-аад нь, 70-аад нь ашиггүй ажиллаж байгаа. Тийм учраас энэ компаниудын үйл ажиллагааг сайжруулах энэ зорилгоор энэ түр хороонууд дээр илүү сайн ажиллана. Өнгөрсөн хугацааных бүх бичиг баримтыг нь бүгдийг нь шалгана. Хувийн компанитай харьцуулахад 3, 4 дахин илүү хүмүүсийг ажиллуулдаг. Тэр хүмүүстэйгээ ажилласан ажилтнуудтай гэрээ хийдэг. Тэр нь Монгол Улсын өнцөг булан бүрд зүгээр тэнд өөрсдийнхөө хувийн бизнес ч юм уу, ажлаа хийгээд явж байдаг. Гэтэл төрийн өмчийн компани дээр гэрээ байгуулчихсан тэндээ ямар ч ажил хийгээгүй мөртөө цалин аваад явж байдаг ийм л тогтолцоог өнгөрсөн хугацаанд сонгуульд ажилласан хүн болгоноо ажилтай болгох энэ зорилгоор хийсэн.

Тийм учраас энэ түр хороог байгуулах энэ эрхийг авснаар энэ дарга нарын савнаас төрийн өмчийн компаниудыг салгах, дээрээс нь энэ төрийн өмчийн компаниудыг хувьчлах, олон нийтийн болгох энэ ажлуудыг хийх ийм дэс дараатай ажлуудыг энэ түр хороо байгуулах энэ Цогтгэрэлийн санаачилсан энэ хуулийн дагуу хийх болно гэдгээ хэлье. Ер нь түр хороо байгуулагдах учраас эртхэн шиг савраа салгаарай гэж та бүхэнд бас зөвлөө.

**Х.Булгантуяа:** Пүрэвдорж гишүүн үг хэллээ. Улсын Их Хурлын гишүүн Баярмагнайн Баярбаатар.

**Б.Баярбаатар:** Улсын Их Хурлын гишүүддээ өглөөний мэндийг хүргэе. Монгол Улсын 9 дэх парламент үйл ажиллагаагаа эхлээд даруй 1 жилийн хугацаа өнгөрлөө. Миний бие Ёс зүй, дэгийн байнгын хороог бас 1 жилийн хугацаанд удирдаад өнөөдөр энэ Их Хурлын тухай хууль батлагдсанаар ингээд Байнгын хорооны даргын ажлаа шилжүүлж байгаа. Их Хурлын энэ индэр дээрээс өнгөрсөн 1 жилийн хугацаанд Байнгын хороонд бас хамтарч ажилласан Байнгын хорооныхоо гишүүддээ талархал илэрхийлье.

Мөн Байнгын хорооны ажлын алба, ахлах зөвлөх, референтүүддээ энэ хурлыг зохион байгуулахад үр дүнтэй ажилласан Тамгын газрын удирдлага, ажилтнууд, техникийн ажилтнууддаа бас өнгөрсөн 1 жилийн хугацаанд хамтран ажилласанд бас талархал илэрхийлэх нь зөв гэж бодож байна.

Дараагийн асуудал өнгөрсөн 1 жилийн хугацаанд манай Байнгын хороо төрийн албан хаагчийн ёс зүйн асуудал дээр нэлээдгүй төвлөрч ажилласан. 7 бүсэд бүсийн чуулга уулзалтыг хийсэн. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль гээд анхдагч хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллахын төлөө, соён гэгээрүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллахын төлөө нэлээдгүй бодлого гаргаж ажилласан байж байгаа. Өнөөдөр Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүнээр ахлуулаад бас энэ Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн үнэлгээ хийж, нэмэлт, өөрчлөлт боловсруулж, Их Хуралд оруулах ийм ажлын хэсгийг байгуулаад ажиллаж байгаа. Цаашид Төрийн байгуулалтын Байнгын хорооны харьяанд Ёс зүйн дэд хороо болоод ингээд чиг үүргээрээ өөрчлөгдөөд ажиллаж байгаа.

Тэгэхээр энэ хуулийн төслүүдийг үргэлжлүүлэн сайжруулж, амилуулж, соён гэгээрүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлж, энэ 220 гаран мянган төрийн албан хаагчдаараа дамжуулан нийгмийн ёс суртахууныг төлөвшүүлэхэд энэ хорооны гол



үйл ажиллагаа оршино. Нийгэм ойлгохдоо Улсын Их Хурлын гишүүдийн ирцийг бүртгээд хуралдаа суусан, суугаагүйгээр нь цагийг нь бүртгэж хариуцлага тооцдог Байнгын хороо гэж ойлгодог бол эсрэгээрээ бас ёс суртахуун, соён гэгээрүүлэх чиглэл дээр нэлээдгүй томоохон бодлогыг хэрэгжүүлж ажилладаг ийм Байнгын хороо шүү гэдгийг бас та бүхэндээ хэлье. Өнгөрсөн 1 жилийн хугацаанд хамтран ажилласан Байнгын хорооны гишүүд, нийт удирдлага, албан албан хаагчдадаа дахин талархал илэрхийлье. Баярлалаа та бүхэнд.

**Х.Булгантуяа:** Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураана. Зарчмын зөрүүтэй 7 санал байна. Гишүүд санал хураалтад бэлтгэе.

Зарчмын зөрүүтэй саналыг дэмжсэн. Зарчмын зөрүүтэй 7 санал байгаа. Санал хураалтыг явуулъя.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2.1-д зааснаар хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулахаар өгсөн чиглэлийн дагуу хураасан санал.

1.Нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийн 7 дахь заалт буюу 27 дугаар зүйлийн 27.5 дахь хэсгийн 27.5.1-27.5.7, 27.5.12, 27.5.14, 27.5.15 дахь заалтыг төслийн 1 дүгээр зүйлийн 8 дахь заалт болгон шилжүүлж, 3 дугаар зүйлийн 7 дахь заалтын 27.5.8-27.5.11 дэх заалт, 27.5.13 дахь заалтыг, мөн зүйлийн 27.5 дахь хэсгийг хасаж, төслийн 4 дүгээр зүйлийн ““32” гэж,” гэсний дараа “27 дугаар зүйлийн 27.5.1 дэх заалтын “тагнуул болон гүйцэтгэх” гэснийг “тагнуулын болон цэргийн тагнуулын байгууллагын гүйцэтгэх” гэж,” гэж, мөн зүйлийн ““23.9-23.12” гэж,” гэсний дараа “27 дугаар зүйлийн 27.5.1 дэх заалтын дугаарыг “27.5.10” гэж, 27.5.2, 27.5.3 дахь заалтын дугаарыг “27.5.8, 27.5.9” гэж, 27.5.4, 27.5.5 дахь заалтын дугаарыг “27.5.11, 27.5.13” гэж,” гэж нэмж, төсөлд доор дурдсан агуулгатай 8 дугаар зүйл нэмэх:

**“8 дугаар зүйл.**Энэ хуулийн 1 дүгээр зүйлийн 8 дахь заалтын 27 дугаар зүйлийн 27.5.12 дахь заалтыг, 3 дугаар зүйлийн 6 дахь заалт буюу 27 дугаар зүйлийн 27.3.6 дахь заалтын “Хууль сахиулах ажиллагааны тусгай хяналтын,” гэснийг, 4 дүгээр зүйлийн 27 дугаар зүйлийн 27.5.1 дэх заалтад орсон өөрчлөлтийг 2026 оны 05 дугаар сарын 01- ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө. Санал гаргасан Төрийн байгуулалтын байнгын хороо. Санал хураалт.

Санал 76.5 хувиар дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2.2-т заасны дагуу хураасан санал.



1.Нэгтгэсэн төслийн 4 дүгээр зүйлийн “70 дугаар зүйлийн” гэсний өмнө “64 дүгээр зүйлийн 64.2 дахь хэсгийн “Тухайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн” гэснийг “Ерөнхий сайд” гэж, 69 дүгээр зүйлийн 69.2 дахь хэсгийн “хоёр” гэснийг “гурав” гэж,” гэж нэмэх. Санал гаргасан Төрийн байгуулалтын байнгын хороо. Санал хураалт.

Санал 81.2 хувиар дэмжигдлээ.

2.Нэгтгэсэн төсөлд доор дурдсан агуулгатай 5 дугаар зүйл нэмж, 5, 6, 7 дугаар зүйлийн дугаарлалтыг өөрчлөх:

**5 дугаар зүйл.**Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.9 дэх хэсгийн “энэ хуулийн 71.13-т заасан дүгнэлтийн хамт” гэснийг хассугай.”. Санал гаргасан Төрийн байгуулалтын байнгын хороо. Санал хураалт.

Санал 83.5 хувиар дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2.2-т заасны дагуу хураасан санал.

1.Нэгтгэсэн төслийн 2 дугаар зүйлийн "тухай хуулийн" гэсний дараа “21 дүгээр зүйлийн 21.3.1 дэх заалтын “нэг дэх” гэснийг “нэг, хоёр дахь” гэж, 21.3.2 дахь заалтын “хоёр” гэснийг “гурав” гэж” гэж, мөн зүйлийн “24 дүгээр зүйлийн” гэсний өмнө “23 дугаар зүйлийн гарчгийн, 23.1 дэх хэсгийн “нэг дэх” гэснийг “нэг, хоёр дахь” гэж, мөн зүйлийн 23.3 дахь хэсгийн “нэг дэх” гэснийг “хоёр дахь” гэж, 24 дүгээр зүйлийн гарчгийн, мөн зүйлийн 24.1 дэх хэсгийн “Хоёр” гэснийг Гурав” гэж,” гэж, мөн зүйлийн ““Тамгын газрын” гэсний өмнө “, 25 дугаар зүйлийн 25.3 дахь хэсгийн” гэж нэмж, мөн зүйлийн “Энэ хуулийн 22.1.2, 22.1.3-т заасан асуудлаар” гэснийг, мөн зүйлийн “энэ хуулийн 22.1-д заасан асуудлаар” гэснийг, төслийн 3 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан Төрийн байгуулалтын байнгын хороо. Санал хураалт.

Санал 83.7 хувиар дэмжигдлээ.

2.Нэгтгэсэн төслийн 2 дугаар зүйлийн “тухай хуулийн” гэсний дараа “14 дүгээр зүйлийн 14.1.2 дахь заалтын “Ерөнхий сайдын сар бүрийн” гэснийг “Улсын Их Хурлын асуулгын хүрээнд хийх” гэж,” гэж нэмэх. Санал гаргасан Төрийн байгуулалтын байнгын хороо. Санал хураалт.

Санал 83.7 хувиар дэмжигдлээ.

Цагдаагийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2.2-т заасны дагуу хураасан санал.

1.Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2026 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”. Санал гаргасан Төрийн байгуулалтын байнгын хороо. Санал хураалт.

Санал 82.6 хувиар дэмжигдлээ.

Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2.2-т заасны дагуу хураасан санал^

1.Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2026 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”. Санал гаргасан Төрийн байгуулалтын байнгын хороо. Санал хураалт.

Санал 84.9 хувиар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Одоо Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг нэгтгэсэн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах санал хураалт явуулна.

Эцэслэн батлуулах хуулийн төслүүдийн хувилбарыг Төрийн байгуулалтын байнгын хороо бэлтгэн гишүүдэд тараасан байгаа. Гишүүд санал хураалтад бэлтгэе.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2-т нэгдсэн хуралдаанд хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулах бөгөөд Улсын Их Хурлын нийт гишүүний олонх дэмжсэн бол хууль эцэслэн баталсанд тооцно гэж заасан. Санал хураалт.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Санал 85.4 хувиар дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

77 гишүүн дэмжлээ.

3.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

77 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

4.Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

73 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

5.Цагдаагийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

74 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

75 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

74 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

72 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

9.Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

75 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

Хуулийн төслүүдийг баталлаа. Улсын Их Хурлын гишүүдэд талархал илэрхийлье.

Одоо баталсан хуулийн эцсийн найруулгыг сонсгоно.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байгаа байна уу?

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Дагалдан гарсан

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Цагдаагийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

08.37 цаг

**Дараагийн асуудалдаа оръё. “Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” асуудлыг хэлэлцье.**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22.1.3-д Улсын Их Хурлын дарга энэ хуулийн 22.1.1, 22.1.2-т заасны дагуу ирүүлсэн саналыг нэгтгэн нам, эвслийн бүлэгтэй зөвшилцөж, Байнгын хорооны бүрэлдэхүүний талаарх саналаа нэгдсэн хуралдаанд танилцуулах гэж заасны дагуу “Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг та бүхэнд уншиж танилцуулъя.

Одоо “Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг та бүгдэд уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь заалт, 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.4 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

1.Монгол Улсын Их Хурлын Байнгын хороодыг дараах бүрэлдэхүүнээр байгуулсугай.

1.Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо.

1.Чинбатын Анар, 2.Очирбатын Амгаланбаатар, Энхтайваны Бат-Амгалан, Нацагдоржийн Батсүмбэрэл, Дуламын Бум-Очир, Энхбатын Болормаа, Дашдондогийн Ганбат, Лувсаннъямын Гантөмөр, Хажекберийн Жангабыл, Батбаярын Жаргалан, Сүрэнжавын Лүндэг, Цагаанхүүгийн Мөнхбат, Нанзадын Наранбаатар, Пүрэвсүрэнгийн Наранбаяр, Нямтайширын Номтойбаяр, Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ, Ганбатын Очирбат, Буяагийн Тулга, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин, Ганзоригийн Тэмүүлэн, Ганбатын Хосбаяр, Дамдины Цогтбаатар, Өлзийхүүгийн Шижир, Баттөмөрийн Энхбаяр, Жадамбын Энхбаяр, Дашцэрэнгийн Энхтүвшин, Лутаагийн Энхнасан, Сүхбаатарын Эрдэнэболд, Равжихын Эрдэнэбүрэн гэсэн бүрэлдэхүүнтэй.

2.Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо.

1.Наранцэцэгийн Алтаншагай, Сайнбуянгийн Амарсайхан, Очирбатын Амгаланбаатар, Жигжидийн Батжаргал, Пүрэвийн Батчимэг, Бат-Өлзийн Бат-Эрдэнэ, Буланы Бейсен, Гомбын Ганбаатар, Сайнхүүгийн Ганбаатар, Мөнгөнцогийн Ганхүлэг, Гонгорын Дамдинням, Дамдинсүрэнгийн Жаргалсайхан, Сонгобайгийн Замира, Жаргалсайханы Золжаргал, Цагаанхүүгийн Идэрбат,

Сүрэнжавын Лүндэг, Мэндбаярын Мандхай, Цагаанхүүгийн Мөнхбат, Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан, Тогтмолын Мөнхсайхан, Баатаржавын Мөнхсоёл, Загджавын Мэндсайхан, Нанзадын Наранбаатар, Салдангийн Одонтуяа, Ухнаагийн Отгонбаяр, Ренчинбямбын Сэддорж, Цэвэгдоржийн Туваан, Агваанлуvsангийн Ундраа, Жигжидсүрэнгийн Чинбүрэн гэсэн 29 хүний бүрэлдэхүүн.

Өргөдлийн байнгын хороо.

Далайн Батбаяр, Жамбын Батсуурь, Халтмаагийн Баттулга, Батмөнхийн Батцэцэг, Бат-Өлзийн Бат-Эрдэнэ, Даваасамбуугийн Ганмаа, Хассуурийн Ганхуяг, Жанчивын Галбадрах, Хажекберийн Жангабыл, Сонгобайгийн Замира, Жаргалсайханы Золжаргал, Ганзоригийн Лувсанжамц, Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан, Пүрэвбаатарын Мөнхтулга, Цэндсүрэнгийн Мөнхтуяа, Одсүрэнгийн Номинчимэг, Бадамдоржийн Пунсалмаа, Дүгэрийн Рэгдэл, Мягмардашийн Сарнай, Саруулсайханы Цэнгүүн, Чинбатын Ундрaм, Сүхбаатарын Эрдэнэбат, Равжихын Эрдэнэбүрэн, Сайнхүүгийн Ганбаатар гэсэн 24 хүний бүрэлдэхүүнтэй.

Төрийн байгуулалтын байнгын хороо.

Оюунсайханы Алтангэрэл, Дашзэгвийн Амарбаясгалан, Аюушийн Ариунзаяа, Батын Батбаатар, Мягмарсүрэнгийн Бадамсүрэн, Баярмагнайн Баярбаатар, Жудгийн Баярмаа, Энхбатын Болормаа, Сандагийн Бямбацогт, Амгаланбаатарын Ганбаатар, Лувсаннaмын Гантөмөр, Цэрэнпилийн Даваасүрэн, Тогмидын Доржханд, Жадамбын Бат-Эрдэнэ, Сархaдын Зулпхар, Цагаанхүүгийн Идэрбат, Лхагвын Мөнхбаатар, Чулуунбилэгийн Лодойсамбуу, Чинбатын Номин, Нямтайширын Номтойбаяр, Эрдэнэбилэгийн Одбаяр, Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ, Бөхчулууны Пүрэвдорж, Цэндийн Сандаг-Очир, Отгоны Саранчулуун, Цэвэгдоржийн Туваан, Гончигдоржийн Уянгахишиг, Бадарчийн Хэрлэн, Одонгийн Цогтгэрэл, Өлзийхүүгийн Шижир, Лувсанцэрэнгийн Энх-Амгалан, Доржзовдын Энхтуяа гэсэн 32 хүний бүрэлдэхүүнтэй.

Төсвийн байнгын хороо.

Жуковын Алдаржавхлан, Норовын Алтанхуяг, Тилеуханы Аубакир, Далайн Батбаяр, Ринчиндоржийн Батболд, Жигжидийн Батжаргал, Жамбын Батсуурь, Жадамбын Баясгалан, Хөххүүгийн Болормаа, Хүрэлбаатарын Булгантуяа, Гомбын Ганбаатар, Жамбалын Ганбаатар, Пүрэвжавын Ганзориг, Хассуурийн Ганхуяг, Цэрэнпилийн Даваасүрэн, Пүрэвжавын Сайнзориг, Дамдинсүрэнгийн Жаргалсайхан, Батжаргалын Заяабал, Баатаржавын Мөнхсоёл, Пүрэвбаатарын Мөнхтулга, Загджавын Мэндсайхан, Чинбатын Номин, Даваахүүгийн Пүрэвдаваа, Ганзоригийн Тэмүүлэн, Банзрагчийн Түвшин, Доржсүрэнгийн Үүрийнтуяа, Даваагийн Цогтбаатар, Баттогтохын Чойжилсүрэн, Дашцэрэнгийн Энхтүвшин гэсэн 29 хүний бүрэлдэхүүнтэй.

Хуул зүйн байнгын хороо.

Оюунсайханы Алтангэрэл, Норовын Алтанхуяг, Хүрэлбаатарын Баасанжаргал, Халтмаагийн Баттулга, Энхбаярын Батшугар, Баярмагнайн

Баярбаатар, Жудгийн Баярмаа, Дашдондогийн Ганбат, Борхүүгийн Дэлгэрсайхан, Мөнхтөрийн Нарантуяа-Нара, Одсүрэнгийн Номинчимэг, Салдангийн Одонтуяа, Ухнаагийн Отгонбаяр, Даваахүүгийн Пүрэвдаваа, Бөхчулууны Пүрэвдорж, Пүрэвжавын Сайнзориг, Цэндийн Сандаг-Очир, Лхагвасүрэнгийн Соронзонболд, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин, Ням-Осорын Учрал, Гончигдоржийн Уянгахишиг, Даваагийн Цогтбаатар, Дамдины Цогтбаатар, Баттөмөрийн Энхбаяр, Сүхбаатарын Эрдэнэболд гэсэн 25 хүний бүрэлдэхүүнтэй.

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо.

Наранцэцэгийн Алтаншагай, Аюушийн Ариунзаяа, Хүрэлбаатарын Баасанжаргал, Цэндийн Баатархүү, Отгоншарын Батнайрамдал, Жадамбаагийн Баясгалан, Буланы Бейсен, Хөххүүгийн Болормаа, Дуламын Бум-Очир, Шинэбаярын Бямбасүрэн, Жанчивын Галбадрах, Амгаланбаатарын Ганбаатар, Даваасамбуугийн Ганмаа, Мөнгөнцогийн Ганхүлэг, Сархадын Зулпхар, Тогтмолын Мөнхсайхан, Цэндсүрэнгийн Мөнхтуяа, Бадрахын Найдалаа, Мөнхтөрийн Нарантуяа-Нара, Дүгэрийн Рэгдэл, Отгоны Саранчулуун, Мягмардашийн Сарнай, Банзрагчийн Түвшин, Болдын Уянга, Ганбатын Хосбаяр, Бадарчийн Хэрлэн, Доржзовдын Энхтуяа, Мөнхчулууны Энхцэцэг, Сүхбаатарын Эрдэнэбат, Лутаагийн Энхнасан гэсэн 30 хүний бүрэлдэхүүнтэй.

Эдийн засгийн байнгын хороо.

Жуковын Алдаржавхлан, Чинбаатарын Анар, Цэндийн Баатархүү, Мягмарсүрэнгийн Бадамсүрэн, Ринчиндоржийн Батболд, Отгоншарын Батнайрамдал, Нацагдоржийн Батсүмбэрэл, Пүрэвийн Батчимэг, Жадамбын Бат-Эрдэнэ, Хүрэлбаатарын Булгантуяа, Шинэбаярын Бямбасүрэн, Жамбалын Ганбаатар, Пүрэвжавын Ганзориг, Болдын Жавхлан, Батбаярын Жаргалан, Батжаргалын Заяабал, Чулуунбилэгийн Лодойсамбуу, Ганзоригийн Лувсанжамц, Мэндбаярын Мандхай, Эрдэнэбилэгийн Одбаяр, Ганбатын Очирбат, Бадамдоржийн Пунсалмаа, Лхагвасүрэнгийн Соронзонболд, Ренчинбямбын Сэддорж, Буяагийн Тулга, Агваанлуvsангийн Ундраа, Болдын Уянга, Бадрахын Найдалаа, Одонгийн Цогтгэрэл, Мөнхчулууны Энхцэцэг, Саруулсайханы Цэнгүүн гэсэн 32 хүний бүрэлдэхүүнтэй.

Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй гэсэн байна.

Одоо “Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэх шинэчлэн батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтад бэлтгэе.

Эдийн засгийн байнгын хороо 31 хүний бүрэлдэхүүнтэй юм байна шүү. Гишүүд санал хураалтад бэлтгэе. Санал хураалт.

64.1 хувиар санал дэмжигдлээ.

Тогтоолын төслийг эцэслэн баталлаа.

Тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?



Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Дараагийн асуудалдаа оръё.

08.48 цаг

**“Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.**

Хууль санаачлагчийн илтгэлийг Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Сандагийн Бямбацогт танилцуулна. Индэрт урьж байна. Жавхлан сайд танилцуулах уу? Хууль санаачлагчийн илтгэлийг Засгийн газрын гишүүн, Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулна. Индэрт урьж байна.

**Б.Жавхлан:** Эрхэм Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Засгийн газрын өрийн удирдлагын 2023-25 оны стратегийн баримт бичгийн 5 дугаар зорилтод эдийн засаг болон нийгмийн үр өгөөж өндөртэй төслийг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хангагдсан, Шинэ сэргэлтийн бодлогод нийцсэн төслүүдийн санхүүжилтийн эх үүсвэрт Засгийн газрын өрийн баталгааг гаргах замаар дэмжлэг үзүүлнэ гэж заасан байдаг.

Үүний дагуу Шинэ сэргэлтийн бодлогод тусгагдсан шинэ тойрог зам буюу 1 дүгээр тойрог зам төслийг санхүүжүүлэх зорилгоор Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар, ОНӨААТҮГ-ын 2025 онд авах 260.3 сая ам.долларын зээллэгийн 85 хувьд Засгийн газрын өрийн баталгаа гаргуулах хүсэлтийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас ирүүлсэн.

Сангийн яам Засгийн газрын өрийн баталгаа гаргах асуудлыг судлан Өрийн удирдлагын засгийн тухай хуульд заасны дагуу Улсын Их Хурлын тогтоолын төсөл болон холбогдох эрсдэлийн үнэлгээг боловсруулан Үндэсний аудитын газраас хөндлөнгийн аудит хийж, дүгнэлт гаргасан болно.

Баталгаа гаргуулж болон төслийн хувьд Өрийн удирдлагын тухай хуульд заасан шалгууруудын бүрэн хангаж байгаа боловч эрсдэлийн үнэлгээнд төслийн санхүүжилтийн эх үүсвэр эцэслэн батлагдаагүй, төслийн орлогыг тооцоолохдоо хөдөлгөөний зарчмыг өөдрөгөөр төсөөлсөн байх магадлалтай л тул эрсдэлийн түвшнийг дундаж гэж үнэлжээ.

1 дүгээр тойрог зам төсөл нь Шинэ сэргэлтийн бодлого Засгийн газрын 2024-28 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан бөгөөд тус төсөл хэрэгжсэнээр Улаанбаатар хотын гол гудамжнуудын түгжрэл дунджаар 20 хувиар буурч, замын хөдөлгөөний дундаж хурд 23.3 хувиар өсөх ач холбогдолтой юм.

Түүнчлэн төслийг санхүүжүүлэхэд шаардагдах зээлдэгч Засгийн газрын өрийн баталгаа гаргах хэмжээ нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан Засгийн газрын өрийн тусгай шаардлага болон 2025 онд Засгийн газрын гаргах өрийн баталгааны дээд хязгаарт багтаж байгаа болно.



“Засгийн газрын өрийн баталгаа гаргах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл болон Сангийн яамны эрсдэлийн үнэлгээ, санал, дүгнэлт, Үндэсний аудитын газрын аудитын дүгнэлттэй танилцаж, тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Х.Булгантуяа:** Төслийн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Төсвийн байнгын хорооны дарга Хассуурийн Ганхуяг танилцуулна. Төсвийн байнгын хорооны даргыг индэрт урьж байна.

**Х.Ганхуяг:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 7 дугаар сарын 7-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Төсвийн байнгын хороо 2025 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Төсөл санаачлагч Нийслэлийн хөрөнгө оруулалтын газарт 2025 оны төсвийн жилд багтаан Засгийн газрын өрийн батлах арга зөвшөөрөл олгосноор замын хөдөлгөөний түгжрэл, алдаж байгаа цаг хугацаанаас үүдэлтэй нийгэм, эдийн засаг, байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгана гэж үзэж, “Засгийн газрын өрийн баталгаа гаргах, зөвшөөрөл олгох тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулсан байна.

Байнгын хорооны хуралдаанаараа тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь “Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурал Хурлын эрхэм гишүүд ээ,

“Засгийн газрын өрийн батлах гаргах зөвшөөрөл олгох тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцсэн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсэж байна.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**Х.Булгантуяа:** Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Хишгээгийн Нямбаатар Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Солонгын Тулга Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, Луулайн Хосбаяр Нийслэлийн санхүү, эдийн засаг, хөгжлийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх төсөл, хөтөлбөрийн зохицуулагч, Маамбын Үнэнбат Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга, Эрдэнийн Түвшинжаргал Нэгдсэн төслийн удирдлагын газрын захирал,

Батсайханы Одбаяр Нийслэлийн Замын хөгжлийн газрын дарга, Лувсандоржийн Гантогтох Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга гэсэн ажлын хэсгийн бүрэлдэхүүнтэй байна.

Одоо Улсын Их Хурлын гишүүд хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилсан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууж, хариулт авъя.

Нийтдээ 6 гишүүн нэрээ ирүүлсэн байна. Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдорж байхгүй байна. Одонгийн Цогтгэрэл байхгүй байна. Улсын Их Хурлын гишүүн Пүрэвжавын Сайнзориг.

**П.Сайнзориг:** Тогтоолын төслийг дэмжиж байна. Өнөөдөр бас Улаанбаатар хотод бас амьдарч байгаа хүмүүсийн гол нерв, цаг завьг барж байгаа зүйл бол энэ өөрөө түгжрэл гэдэг зүйл байгаа. Сүүлийн 10 жилд автомашины тоо 80 хувиар өсөж байхад авто замын бүтээн байгуулалт явагдаж байгаа хэр нь л энэ түгжрэлийг бас бүрэн шийдэж чадахгүй ингээд явж байна. Тэгээд өнөөдөр энэ Улаанбаатар хот дахь авто замын дундаж хурд 7км/ц-тай байна уу даа 7-10км цагийн хооронд л байгаа байх. Тэгэхээр ер нь энийг бууруулчихгүй яаж энэ хөдөлгөөний эрчмийг нэмэгдүүлэх вэ гэдэг асуудал маш чухал байгаа.

Дээрээс нь энэ Улаанбаатар хотод энэ авто замын түгжрэл дээр алдагдсан боломж гэдэг нэг юм бас байдаг. Тэгэхээр энэ алдагдсан боломжийн өртөг ер нь түгжрэлээс үүсэж хэд байгаа вэ? Энэ яг судалгаанууд байна уу? Энийг бас олон нийтэд хэлээч. Энэ зам баригдсанаар энэ алдагдсан боломжид буюу энэ түгжрэлээс үүсэх сөрөг үр дагаврыг шийдэхэд бас ямар нөлөө үзүүлж байгаа вэ? Энийг бас хэлээч.

Хоёрдугаарт энэ Улаанбаатар хотод нэг томоохон зүйл байгаа. Аюултай ачаа, бараа Улаанбаатар хотын яг тэг дундуур гарч байгаа. Зүүнээсээ баруун баруунаасаа зүүн Алтанбулаг-Замын-Үүд, Замын-Үүд-Алтанбулаг ч гэдэг юм уу энэ бүх энэ транзит ачаанууд дандаа Улаанбаатарыг тэг дундуур нь дайр өнгөрч байгаа. Тэгэхээр энэ асуудал дээр энэ тойрог зам болон Туулын хурдны зам бас ямар нөлөө үзүүлэхээр байгаа вэ?

Тэгээд ер нь энэ авто замын бас асуудлыг хэрэглэгч нь төлөх зарчим руу оруулж байгаа гэж ойлгож байгаа. Тэгэхээр энэ авто замын бүтээн байгуулалтыг хэдий хугацаанд хийж дуусгах вэ? Ер нь үнэ өртгөө хэрхэн яаж нөхнө гэсэн ийм тооцоо судалгаа байгаа вэ? Эцэст нь хэлэхэд энэ Улаанбаатарт амьдарч байгаа хүмүүс гэр бүлдээ чанартай цаг гаргаж чадахгүй байгаа энэ түгжрэлээс шалтгаалаад. Энэ чанартай цаг гаргах гэдэг бол гэр бүлийн уур амьсгал, энэ эрүүл мэнд, нийгмийн стресс, магадгүй бизнесийн агуулгаас нь харсан ч гэсэн бензин тосоос хэмнэх, цаг нараа хэмнэх гээд маш олон зүйлүүд байгаа.

Тэгэхээр энэ ер нь Улаанбаатарчууд буюу энэ 2 сая иргэдийн амьдрал биш энэ Улаанбаатараас бараа материалаа татаж байгаа, бараа материалаа дайран өнгөрүүлж байгаа тээвэрчдийн бүхий л асуудал байж байгаа юм. Тэгэхээр яг 3 асуултад л хариулж өгөөч. Ер нь түгжрэлээс үүсэж байгаа алдагдсан боломж хэд

байгаа вэ? Энэ дээр ямар нөлөө үзүүлэх вэ? Аюултай ачаа, барааны тээвэрлэлт дээр энэ зам ямар чухал ач холбогдолтой байгаа вэ? Үнэ өртгөө ер нь хэрхэн нөхнө гэсэн ийм тооцоо судалгаа байгаа вэ гэдэг зүйлийг хариулж өгөөч.

**Х.Булгантуяа:** Ажлын хэсэг 4 номерын микрофоноос хариулъя.

**Х.Нямбаатар:** Сайнзориг гишүүний асуултад хариулъя. 1 дүгээр тойрог замын нийт урт 24.7км. Үүнээс гүүрэн байгууламж 9 орчим километр, туннелээр 2км явна. Авто зам нь 14.8км, 3 метрийг үржих нь 2-ын харьцаатай явган хүний зам, дугуйн зам 2.5-ыг үржих нь 2, ногоон байгууламж 2.5мм гэсэн ийм нийтдээ байгууламжуудыг барьж байгуулахаар төлөвлөж байгаа.

Бидний ТЭЗҮ-ээр ойролцоогоор Улаанбаатар хотод өдөрт дунджаар 580 орчим мянган тээврийн хэрэгсэл хөдөлгөөнд орж байгаа. Тэгвэл тэдгээр машины 30 орчим хувь нь энэ тойрог хурдны замаар дайран өнгөрнө гэдэг тооцоо бодож, уг төслийн өртгийг 10 жилийн дотор төлнө гэсэн. Өөрөөр хэлбэл, өдөрт дунджаар 180 мянга орчим машин тээврийн хэрэгсэл энэ тойрог болон Туулын хурдны зам дээр гарч үйлчлүүлнэ гэсэн ийм тооцоо бодож байгаа. Тэгээд 1 өдөрт гарч зорчиход хязгааргүйгээр хэдэн ч удаа орж гарсан 5000 төгрөгийн тарифтай байхаар тооцож үзэхэд 10 жилийн дотор уг төсөл өртгөө нөхнө гэсэн тооцоо байгаа.

Сайнзориг гишүүний асуултад маш товчхон хариулахад өнөөдөр Улаанбаатар хотод сарын дундаж цалин 2.2 сая төгрөг байгаа. Ингэвэл Улаанбаатар хотод 1 цагийн дундаж цалин 13 мянган төгрөг. Түгжрэлд өртөж байгаа энэ түгжрэлийн нөлөөлөлд орж байгаа өртгийг сарын дундаж, өдрийн цагийн дундаж цалингийн 50 хувиар буюу 6500 төгрөгөөр үржүүлдэг. Хүн 1 жилд дунджаар 30 хоног буюу түгжрэлд 1 сарыг зарцуулж байна гэдэг ийм өртөг тооцоо гардаг. Өдөрт дунджаар 3 сая зорчилт хөдөлгөөн хийгдэж байгаа.

Ингэхээр Лондон ч гэдэг юм уу, Найроби, Бангкок, Станбул зэрэг хотуудад нийгэм, соёл, эдийн засгийн хувьд өөр өөр хотуудад өдрийн цагийн цалингийн 50 хувьд үндэслэж түгжрэлийн өртгийг гаргадаг. Тэгэхээр Монгол Улсын Нийслэл Улаанбаатар хотод амьдарч байгаа хүмүүс жилд дунджаар 30 хоногийг түгжрэлд зарцуулж байгаа гэж үзвэл үүнийг 6500 төгрөгөөр үржүүлэхээр түгжрэлийн өртөг маш өндөр гарч байгаа гэдгийг хэлье.

Эцэст нь тэр аюултай ачааг бид нар Туулын зам болон энэ тойрог замаар Улаанбаатар хотоос баруунаас зүүн тийш, хойноос урагш гаргах ийм зохицуулалтыг хийж явахаар төлөвлөсөн гэдгийг хэлье. Би хариулж дууслаа.

**Х.Булгантуяа:** 4 номерын микрофон дээр нэмж минут өгье. Микрофон нь асчихсан байна шүү.

**Х.Нямбаатар:** Би сая Булгантуяа дарга би хариулчихсан юм. Яах вэ энэ ингээд хурдны зам ашиглалтад ороод тээвэр ашиглалтын зардал буурснаас бид нар 704 сая доллар хэмнэнэ. Бид жилд дунджаар 30 хоногийг түгжрэлд зарцуулж байгаа. Дэлхийн хотууд дундаж хэсгээр түгжрэлийн өртөг, зардлыг яаж тооцдог вэ гэвэл тухайн хотын цагийн ажлын хөлсний 50 хувиар түгжрэлийн зардлыг тооцож үздэг. Тэгэхээр бид нар Улаанбаатар хотын өдрийн цагийн хөлс 13 мянган төгрөг

байгаа бол 6500 төгрөгийг нийтдээ жилд 30 хоногоор үржүүлэхээр бид нар тийм хэмжээний алдагдлыг.../минут дуусав./

**Х.Булгантуяа:** Улсын Их Хурлын гишүүн Даваахүүгийн Пүрэвдаваа.

**Д.Пүрэвдаваа:** Өглөөний мэнд хүргэе. 3 асуулт байна. Эхнийх нь Сангийн сайдаас асууя. 2025 оны төсвийн тухай хуульд Засгийн газрын шинээр гаргах өрийн баталгааны дээд хэмжээг 3.5 их наядаар тогтоосон байгаа. 260.3 сая доллар буюу ойролцоогоор 910 орчим тэрбум төгрөгийн баталгаа гаргаж өгөх гэж байна. Тэгэхээр зэрэг өнөөдөр оны хагас өнгөрч байна. 3.5 их наяд төгрөгийг 900-г нь хасаад үзэх юм бол үлдсэн 2.6 их наядыг ямар хэлбэрээр төлөвлөж байгаа вэ? Энэ 900 тэрбум төгрөгийн энэ эрсдэлийг тооцсон уу? Хэрвээ орон нутгийн компани төслийг санхүүжүүлэх боломжгүй болж, эсвэл хойшлуулах нөхцөл байдал үүсвэл төсөв дээр ирэх дарамтын тооцооллуудыг гаргасан уу гэж асуумаар байна.

Хотын даргаас асуух зүйл байна. Засгийн газрын баталгаа гаргах төсөл нь Өрийн удирдлагын тухай хуульд заасан шаардлага, нөхцөлийг бүрэн хангаж чадаж байна уу? Ялангуяа тэр 6.4.1 төсөл өөрөө санхүүжих төсөл арга хэмжээ, нийгэмд үр өгөөжтэй, эдийн засгийн хувьд үр ашигтай байх ёстой гэж байгаа юм. Тэгэхээр энэ үр өгөөж, эдийн засгийн бөгөөд санхүүгийн тал дээр тоон үзүүлэлтээр нийгэмд ялангуяа энэ нийслэлийн иргэдэд танин мэдүүлэх арга хэмжээ судалгаа хийсэн байгаа юу гэж асууя.

**Х.Булгантуяа:** 4 номерын микрофоноос хариулъя ажлын хэсэг.

**С.Тулга:** Сайн байна уу? Гишүүний асуултад хариулъя. Сангийн яам Санхүүгийн бодлогын газрын дарга Тулга. Одоо энэ баталгаа авч байгаа дүн маань эхний транж буюу 260 сая-ын 85 хувь дээр нь баталгаа авч байгаа. Ингэхлээр 220 сая доллар дээр баталгаа авч байгаа. 25 онд Их Хурлаас зөвшөөрсөн нийт баталгаа гаргах хэмжээ маань өөрөө 1 тэрбум орчим ам.доллар буюу 3.5 их наяд төгрөг байгаа. Сангийн яамнаас баталгааг баталгааны хүсэлт гаргасан компани хуулийн шаардлагаа хангаад ирэх юм бол баталгаа өгдөг байгаа. Одоогийн байдлаар яг хуулийн шаардлага хангаад ингээд баталгаа авч байгаа анхны тохиолдол нь болохлоороо нийслэлийн тойрог зам төсөл байгаа.

Төслийн хувьд Сангийн яам энийг дундаж эрсдэлтэй гэж үнэлсэн. Энийг яаж үнэлсэн бэ гэхлээр эхлээд өрийн удирдлагын хуульд тавигдсан шаардлагуудыг бүрэн хангаж байна уу гэдэг дээр хяналт тавьж байгаа. Энэ дээр бүрэн хангаж байгаа. Төсөл нь өөрөө үр ашигтай байх уу, өөрийгөө авсан зээлээ эргэн төлж чадах уу гэдэг дээр бас хангаж байгаа. Энэ болохлоор 16 жилийн хугацаатай 3 хувийн хүүтэй “Чайна Экзим” банкнаас зээл авна гэсэн энэ хүлээлттэй байгаа. Ингээд төсөл нь өөрийнхөө өртгийг 10-12 жилийн хугацаанд төлөөд дуусчихна. Тэгэхлээр 16 жил дотроо төлөөд дуусчих юм байна лээ.

Орлогын хувьд 2028 оноос хойш шууд зам ашиглалтад ороод орлого нь орж эхэлнэ. 28 онд нийт орлогын хэмжээг 380 тэрбум гэж тооцож байгаа. Яг энэ зам ашигласны төлбөр гээд одоо авч байгаа энэ автомашин болгоноос авч байгаа татвараас 46 тэрбум, яг энэ замын хураамжаасаа болохлоор 334 тэрбум гээд ингээд 1 машинаас 5000 төгрөг гэсэн энэ тооцоогоор авч байгаа.

Хоёр дахь тавигдаж байгаа шаардлага нь баталгаа авагч, баталгаа гаргуулагч тал дээрээ тавигдаж байгаа шаардлага байгаа. Энэ Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар нь хугацаа хэтэрсэн өргүй, 3 жил дараалж ашигтай ажилласан нийт эргэлтийн хөрөнгө нь 712 тэрбум төгрөгт байгаа, байгууллагын өрийн харьцааны үзүүлэлт эрсдэл маш бага 10 хувиас доогуур гэж үзсэн байгаа.

Яагаад дундаж эрсдэлтэй гэж үзсэн бэ гэхээр яах вэ тойрог замаар нийт замын хөдөлгөөнд оролцож байгаа машины 30 хувиар оролцоно гэдэг нь арай өөдрөг төсөөлөл байгаа учраас Сангийн яамнаас энийг дундаж эрсдэлтэй гэж үнэлсэн байгаа. Тэрнээс яг төсөл энэ баталгаагаа авагч тал дээр эрсдэл бага байгаа.

**Б.Пүрэвдорж:** Их Хурлын гишүүдийнхээ энэ өглөөний амгаланг айлтгая.

Монголын өнцөг булан бүрд аймаг, сумдын наадам эхэлж байгаа тэгээд орон даяараа сайхан наадахын ерөөлийг өргөн дэвшүүлье.

Одоо Гончигдоржийн Уянгахишиг. Индрийн 4 дүгээр номер Улаанбаатар хотын захирагч бөгөөд Нийслэлийн Засаг дарга Нямбаатар хариулна.

**Х.Нямбаатар:** Би гишүүний асуултад хариулъя. Энэ мэдээж хэрэг Банкэбл/bankable/, ЗЭЗҮ боловсруулах ажлыг бид нар олон улсын нээлттэй тендерээр зохион байгуулсан. Манай энэ ТЭЗҮ-ийг боловсруулах ажлыг “Чайна констракшн”, түүний түншлэгчээр БНХАУ-ын ШУА-ийн Хүрээлэн буй орчны газар хоёр хамтарч энэ Банкэбл ТЭЗҮ-г боловсруулсан. Банкэбл ЗЭЗҮ боловсруулагдаж байгаа учраас нийгэм, эдийн засаг, бусад үр нөлөөллийн судалгаануудыг бүрэн хангалттай хийлгэж дууссан гэдгийг танд нэгдүгээрт хэлье.

Хоёрдугаарт Сангийн яам Үндэсний аудитын байгууллага бид нар хэт өөдрөг төсөөллөөр буюу энэ Туул болон тойрог хурдны зам дээр нийт хөдөлгөөнд оролцож байгаа машин бүрийн 30 орчим хувь нь өдөртөө зорчино гэдэг ийм тооцооллоор өндөр их өөдрөг төсөөлөлтэй байна гэдэг байдлаар дүгнэлт гаргасан байгаа. Бид нар өдөр болгон зорчиж байгаа автомашин.../минут дуусав./

**Б.Пүрэвдорж:** Тодруулъя Пүрэвдаваа гишүүн.

**Д.Пүрэвдаваа:** Сангийн яам 3.5 их наяд төгрөг төлөвлөсөн бол хэдэн хувийн ашиглалттай байгаа юм бэ? Мэдээж энэ төсөл нийгэмд үр өгөөжтэй гэж харагдаж байгаа нь ойлгомжтой. Түгжрэлийг 20 хувь болгоно гэж байгаа юм. 900 орчим тэрбум төгрөг болж байгаа юм. Үлдсэн тэр 2 их наяд төгрөгийг юунд зарцуулахаар төлөвлөж байгаа юм бэ, зарцуулчихсан юм уу гэдэг дээр тодорхой хариулт өгсөнгүй. Тэгээд нийгмийн үр өгөөжийг олон нийтэд таниулж чадсан уу гэдгийг хотын дарга тодорхой хариулмаар байна.

**Б.Пүрэвдорж:** Индрийн 4 дүгээр номер. Эхлээд эхлээд Сангийн сайд Болдын Жавхлан хариулъя.

**Б.Жавхлан:** Пүрэвдаваа гишүүний асуултад нэмэлт мэдээлэл өгье. Тийм ээ энэ жил 3.5 их наядын баталгаа гаргах ийм төсвийн орон зай батлагдсан байдаг. Үүнийг бид энэ томоохон төслүүд, ялангуяа мега төслүүд дээрээ хадгалж ингэж



орсон байгаа. Үүнээс амжилттай бөгөөд Их Хурлын босго давахаар хэмжээнд бэлтгэгдэж бэлтгэл хангаж ирсэн төсөл маань энэ юм байгаа юм. 900-гаад тэрбум төгрөг. Яг 230 сая чинь 85 хувь нь гэхээр арай 900 хүрэхгүй байгаа шүү.

Тэгэхээр үлдэж байгаа 2.6 их наяд дээр бид төсөл хүлээж байна судлагдаж байгаа төслүүд байна. 1 төгрөгийн ч баталгаа гаргасан байсан заавал Улсын Их Хурал дээр орж ирнэ. Улсын Их Хурал босго гаргаж, энд та бүхэн зөвшөөрөл өгнө гэсэн үг. Тийм учраас намар болтол ямар төслүүд дахиж судлагдах нь вэ бид хүлээж байна. Судалж байгаа ажлууд бас байгаа. Бэлтгэл ажил бүрэн хангагдаагүй байгаа учраас энд дэлгэрэнгүй мэдээлээд шаардлага хангахгүй. Тэгэхдээ ийм байгаа шүү Пүрэвдаваа гишүүнээ.../минут дуусав./

**Б.Пүрэвдорж:** Нэмж хариулъя.

**Б.Жавхлан:** Тийм, тэгэхээр баталгаа маань ер нь баталгаа гаргачхаад эрсдэлд ороод дуудагдах үед Засгийн газрын өрөн дээр бичигддэг тэр дуудагдсан хэмжээгээрээ. Тэрнээс биш баталгаагаа гаргаад тэр хэмжээгээр Засгийн газрын өрөн дээр бичигдэнэ гэсэн ойлголт байхгүй. Тийм, дуудагдах үед Засгийн газрын өрөн дээр бичигдэнэ.

**Б.Пүрэвдорж:** Индрийн 4 дүгээр номер хотын захирагч.

**Х.Нямбаатар:** Би Пүрэвдаваа гишүүний асуултад товчхон хариулчихъя. Энэ төсөл хэрэгжсэнээрээ түгжрэл, хэрвээ бид нар 180 мянган машинаар тойрог зам дээр зорчилт хийж байгаа тохиолдолд түгжрэл бараг 24 орчим хувиар буурна. Энэнээс машины тоо нэмэгдэхийн хэрээр түгжрэлийн хувь хэмжээ дагаж буурна гэсэн төв ба гол замууд дээр үзүүлэх ачаалал, дуу чимээний бохирдол 26 хувиар буурна, тоос шорооны бохирдол 240 дахин буурна, чийгшил 10 дахин нэмэгдэнэ, агаарын чийгшил 10 дахин нэмэгдэнэ, хөрсний элэгдэл 40.2 хувиар буурна, хог хаягдлын зөөвөрлөлт 6.7 дахин нэмэгдэнэ, ногоон байгууламжийн хувь хэмжээ 16.6 хувиар нэмэгдэнэ. Саяын миний хэлсэн нөгөө түгжрэлийн өртөг 704 сая доллароор жилдээ хэмнэгдэнэ. Энд тэр түгжрэлд зарцуулсан цаг хугацаанаас гадна, түгжрэлд зарцуулж байгаа шат.../минут дуусав./

**Б.Пүрэвдорж:** Одоо Гончигдоржийн Уянгахишиг гишүүн асуулт асууна.

**Г.Уянгахишиг:** Яг тодорхой 3 асуулт асууя. Сая Пүрэвдаваа гишүүний асуусан асуултаас яг үргэлжлүүлээд ер нь бол яг энэ санхүүжилтийг газраас авах юм байна гэж ойлголоо. Тэгэхээр 780.8 сая ам.долларын зээлээр ер нь бол энэ зам бүхэлдээ энэ төсөл хэрэгжих юм байна гэж ойлголоо. Тэгэхээр эхний жил буюу 25 онд 260.3 сая ам.долларын зээлийн баталгаа гаргаж байгаа юм байна.

Тэгэхээр 26, 27 онд үлдсэн зээл дээр бас зээлийн баталгаа гаргана гэж ойлгож байна. Тэгвэл яг энэ гэрээ маань нэгдсэн байдлаар хийгдэж байгаа гэж ойлгож байгаа зөв үү? Эх үүсвэрийн шийдэгдэж байгаа гэсэн үг. Энэ дээр буцаад эргэн төлөлтөө бол замын тарифаас буюу өдрийн 5000 төгрөгөөр тооцоод тооцоолсон байна. Тэгэхээр энэ дээр бас нөгөө ханшийн зөрүүгийн тооцооллоо яаж оруулсан байгаа вэ гэдэг 1 асуулт байна. Өөрөөр хэлбэл энэ чинь ам.долларын зээллэг байгаа тээ?

Хоёрдугаарт болохоороо яг энэ зээлийн гэрээтэй холбоотойгоор замын гүйцэтгэгч байгууллага дээр онцгой нөхцөл үүсэж байгаа юу буюу замын гүйцэтгэгчээ хэрхэн сонгох юм? Энэ дээр онцгой зарчим гэрээн дээр тусгагдаж орж ирж байгаа юу гэдэг хоёрдугаар асуулт.

Гуравдугаар асуулт бол энэ ажил 3 жилийн хугацаанд үргэлжилнэ. Тэгэхээр энэ 3 жилийн хугацаанд барилгын ажил буюу замын ажил явагдахад одоогийн байгаа замын урсац, замын хөдөлгөөнд хэр нөлөө үзүүлэх вэ? Саатал хэр учрах вэ? Өөрөөр хэлбэл, бид нар яг ингээд замын хөдөлгөөн чинь өөрөө угаасаа түгжрэлтэй явж байгаа. Тэгэнгүүт яг энэ замын хөдөлгөөнийг хаах гэдэг юм уу яг ямар замууд хаагдаж явах юм, жил жилээрээ ямар төлөвлөгөөтэй явж байгаа юм гэдэг тал дээр бас мэдээлэл өгөх боломж байна уу гээд яг ийм 3 үндсэн асуулт.

**Б.Пүрэвдорж:** Индрийн 4 дүгээр номер хотын дарга.

**Х.Нямбаатар:** Худалдан авах ажиллагааг бид нар зохион байгуулахдаа 3 багц болгоно.

1 дүгээр багцыг ТЭЦ 4-ийн уулзвараас туннелийн эхлэл цэг хүртэл 8.6км энэ дотроо 9 гүүрэн байгууламжтай.

2 дугаар багцыг туннелийн эхлэл цэгээс, БЗД-ийн төгсгөл цэгээс БЗД-ийн 21 дүгээр хороо хүртэл 6.9км, гүүрний тоо 4 ширхэг, туннел 1 ширхэг. Нийт урт, туннелийн урт 2.8 гэсэн ийм багцтай.

3 дугаар багцыг БЗД-ийн 21 дүгээр хорооноос эхлэн Дүнжингарав, улмаар Туулын хурдны зам гэсэн 9.3км гэсэн ийм байдлаар бид нар 8 дугаар сарын 1 гэхэд тендерээ зарлахаар төлөвлөж байна 3 багц болгоод. Тендерийн үндсэн зарлах үндсэн шалгуур үзүүлэлт FIDIC-ийн зарчмаар EPC+F буюу санхүүжилтээ өөрөө банкнаас гүйцэтгэгч нь өөрөө олж санхүүжүүлж барих нөхцөлтэйгөөр тендерээ зарлаж байгаа. Өнөөдрийн гаргаж байгаа Засгийн газрын баталгаа нь тэр F-ийнх нь өөрийнх нь баталгаа болгож бид нар жил жилээр нь транчилж санхүүжилтийн баталгааг нь Их Хурлаас зөвшөөрөл авч гүйцэтгэлтэй нь уялдуулж явахаар ингэж төлөвлөж байгаа.

Өөрөөр хэлбэл, энэ санхүүжилт нь цэвэр гаднын дэд бүтцийн хөрөнгө оруулалтад санхүүжилт хийдэг банкнуудаас гүйцэтгэгч нь өөрөө санхүүжилтээ олж ирэх нөхцөлтэйгөөр явж байгаа гэдгийг хэлье.

Ханшийн эрсдэл инфляцыг хэрхэн тооцсон бэ гэхээр бид өдөрт зорчилтын хязгаар тавилгүйгээр тухайн тойрог болон Туулын хурдны зам кольца дээр гарч ирсэн машин хэдэн ч удаа гарч болно. Зөвхөн гарсан өдрийнх нь өртөг нь 5000 төгрөг байна. Энийг инфляцтай уялдуулаад 2000, ашиглалтад орсон цагаас хойш жилд 1000 төгрөгөөр нэмэгдүүлэх замаар 5 жилийн хугацаанд энэ тарифыг тооцъё. Ингээд эргэн төлөлтөө аль аль замынхаа эргэн төлөлтийг бид нар 10 жилийн хугацаанд эргэн төлөлтөө энэ тооллоосоо олно гэсэн ийм тооцооллоор бид нар хийж байгаа гэдгийг та бүхэнд хэлье.

**Б.Пүрэвдорж:** Одоо Цагаанхүүгийн Мөнхбат гишүүн асуулт асууна.

**Ц.Мөнхбат:** Манай энэ бас яах вэ өмнөх гишүүд нэлээн асуучихлаа. Тэгээд энэ бид нарын авах гээд байгаа энэ Засгийн газрын өрийн баталгааны хүрээнд авах гээд байгаа энэ зүйл маань нэгдүгээрт Засгийн газар өөрөө авах ёстой байсан энэ өрөөс хасагдах юм шиг байна тээ? Нийтдээ 260 орчим сая доллар гэж ингэж ойлголоо. Тэгээд энэ нь зээл юм уу, тухайн тэр тендерт ороод гүйцэтгэгчээр шалгаруулах гэж байгаа компаниудын концесс болох юм уу? Энийг тодруулаад асуучихъя.

Хоёрдугаарт нь энэ бид нарын хэрвээ зээл юм энэ зээл ямар хүүтэй авч байгаа юм? Энэ нь бид нарт эргээд ямар хамааралтай вэ гэдэг талаас нь бас дэлгэрүүлж хэлж, ярьж өгөөч.

Гуравдугаарт нь гаднын компани мэдээж энэ тендерт орно. Энэ гэрээний гүйцэтгэгч болж таарна. Тэр маань энэ Монголын үндэсний аж ахуйн нэгжүүдээс туслан гүйцэтгэгчээр байдаг юм уу, тэд нарыг оролцуулах ийм боломж, бололцоонууд бий юү? Эсвэл дан гаднынхаа ажиллах хүчийг оруулж ирээд ингээд энэ үндсэн ажлаа гүйцэтгэх юм уу гэдэг ийм 3 асуулт эхлээд асууя даа.

**Б.Пүрэвдорж:** Нийслэлийн Засаг дарга Нямбаатар хариулна.

**Х.Нямбаатар:** Энэ Мөнхбат гишүүний асуултад хариулахад энэ нэгдүгээрт концесс биш, хоёрдугаарт бид энэ зээлийн хүүг нээлттэй олон улсын тендер сонгон шалгаруулалтаар гүйцэтгэгч компани нь орж ирэхдээ өөрөө аль банкаар санхүүжүүлэх, хэдэн хувийн хүүтэй, хэдэн жилийн хугацаатай санхүүжүүлэх байдлаар уралдаант шалгаруулалт хийгдэнэ. Дэд бүтцийн төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлдэг. банкнуудтай тухайн гүйцэтгэгч компани нь өөрөө зээлийн хүү, хувь хэмжээгээ тохирч тэр нь нээлттэй сонгон шалгаруулалтаар өрсөлдөнө. Энэ нэгдүгээрт шууд өр гэж болохгүй. Бид нар энэ ТЭЗҮ-ээрээ 10 жилийн дотор төлнө гэдэг. Гүйцэтгэж дууссанаас хойш 10 жилийн дотор төлнө гэдэг ЗЭЗҮ хийгдсэн. Хэрвээ бид нар төлж чадахгүй тохиолдолд Засгийн газар баталгаа гаргасныхаа дагуу эргэн төлөлт дээр хариуцлага хүлээнэ л гэдэг ийм нөхцөлтэй явж байгаа юм.

Хоёрдугаарт, дотоодын аж ахуйн нэгжүүдийн оролцоог жишээлбэл 8 сарын 1-нээс Туулын хурдны замын бүтээн байгуулалтын ажил эхэлж, техник тоног төхөөрөмж татах гэрээ хэлцэл дуусах ажил эхлэх гэж байгаа юм. Энэ дээр бид нар ямар шаардлагууд тавьж байгаа вэ гэвэл гол түүхий эд орц болох цементийг болж өгвөл дотоодоос 100 хувиа авах, түгээмэл тархацтайг 100 хувь авах, дотоодын аж ахуйн нэгжүүдийн туслан гүйцэтгэлийн хувь хэмжээг 20-оос доошгүй хувь байх гэдэг шаардлагуудыг тавьж байгаа юм. Энэ өөрөө 1 дүгээр зэрэглэлийн зам учраас, мэдээж хэрэг нэлээд технологи шаардах учраас томоохон дэлхийн нэр хүндтэй компаниуд энд өрсөлдөх нь ойлгомжтой байх. Түрүүн бас Уянгахишиг гишүүн асууж байсан. Энэ замуудыг хэр их хааж, хэр их стресс нерв үүсгэх вэ гэдэг л асуудал ярьж байгаа юм.

Тэгэхээр Туулын зам дээр ч тэр, тойрог хурдны зам дээр ч тэр бид болж өгвөл гол замуудтай огтлолцож байгаа хэсгүүд дээр нөгөө баганан гүүрэн байгууламжуудыг бэлэн хийцлийг барилгын ажлын талбай дээр хийснийхээ дараа авчирч угсрах замаар гүйцэтгэж явна. Ихэвчлэн голын хөвөө дагаж явна. Эсхүл нөгөө усны байгууламжийн дагуу явах учраас гол ба үндсэн замууд дээр аль болох



ачаалал өгөхгүйгээр үндсэн хөдөлгөөний урсгал эрчмийг бууруулахгүй явах зорилго дагуулж байгаа.

Дээр нь манай ТЭЗҮ-д 1 дурдагдсан гол хүчин зүйл нь юу байгаа вэ гэвэл гүүрэн дээгүүр гүүр гарахаар байгаа. Жишээлэхэд Туулын хурдны зам Туул дээр тавигдсан 5 гүүрэн дээгүүр гүүр явахаар байгаа. Энэ тохиолдолд ТЭЗҮ-д юу гэж бичигдсэн бэ гэвэл доогуур гүүрэн доогуур зам явж байгаа тохиолдолд дээгүүр нь баригдаж байгаа гүүр хийгдэх ажил ерөөсөө тасралтгүй явагдана. Доогуур нь зорчилт хөдөлгөөн явагдах ийм технологиудыг ашиглах.

Дээр нь энэ голын урсцыг өөрчлөхгүйгээр тухайн гол дотор гүүрэн байгууламжуудынхаа суурийг хийх энэ тэр гээд энэ хамгийн сүүлийн үеийн технологиудыг дэвшүүлж байгаа гэдгийг бас хэлье.

**Б.Пүрэвдорж:** Цагаанхүүгийн Мөнхбат гишүүн нэмж тодруулъя.

**Ц.Мөнхбат:** Мэдээж нийслэлд хийгдэж байгаа энэ Туулын хурдны зам ч бай, тойрог зам ч бай энэ том төслүүдийг явуулахыг 100 хувь дэмжиж байгаа.

Гэхдээ бид нар энэ том төслүүд хийж байгаагийнхаа хажуугаар дотоодын аж ахуйн нэгжүүд энэ үндэсний үйлдвэрлэгч нараа дэмжих бодлого зайлшгүй давхар явж байх ёстой шүү гэдгийг зориуд хэлмээр байна.

Хоёрдугаарт нь дээр. Бид нар энэ төслүүдийг явуулахтай холбогдуулаад энэ Байгаль орчны яамнаас тэр байгаль орчны нарийвчилсан үнэлгээ энэ тэр гаргуулах, тэгээд энэ Усны тухай хууль гээд зарим нэг хуулиудад бас өөрчлөлт оруулаад ингээд явсан. Тэгээд энэ хүрээндээ энэ мэргэжлийн яамнуудын оролцоог хангах, энэ үйл ажиллагаагаа уялдуулах тал дээр бас нэлээн сайн хяналт тавьж ажиллах шаардлагатай юм шиг санагдсан. Тэгээд энэ төслийг дэмжиж байна.

**Б.Пүрэвдорж:** Үг хэллээ. 2 гишүүн, 1 гишүүн асуулт асуугаад 1 гишүүн үг хэлсний дараагаар санал хураалт явагдана. Энэ санал хураалт явагдсаны дараа Төсвийн байнгын хороогоор яаралтай энэ асуудлыг анхны хэлэлцүүлгийг нь хийх ёстой. Тийм учраас гишүүд ирцээ бүрдүүлэхийг хүсэж байна.

Даваагийн Цогтбаатар гишүүн асуулт асууя.

**Да.Цогтбаатар:** Баярлалаа. Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Зээлийн асуудал ч энэ 25 онд зээл авна гэж байсан бол яагаад ингэж цагийг нь тулгаж орж ирсэн бэ? Өмнө нь бид нар энэ ажлаа хийнэ 14 мега төсөл энэ тэр гэж явж байхад энэ асуудлуудыг өмнө нь оруулж ирж танилцуулж болоогүй юу гэж асуулт байна. Тэгээд одоо 918.6 сая доллароор зам барина гэж байгаа. Тэгтэл энэ 2024 онд аудитаас Засгийн газрын санхүүгийн тайланд хийсэн шинжилгээгээр бол төсөвт өртөг өсөөд байдаг юмнууд байнга бичигдэж явж байгаа. Энэ цаашид өсөхгүй гэсэн баталгаа байх уу гэж байгаа юм.

Тэгээд энэ “Эрдэнэс Тавантолгой”-гоос төслийн 15 орчим хувийн санхүүжилтийг гаргуулахаар юм байна. Гэтэл Эрдэнэс Тавантолгой чинь “Эрдэнэс Тавантолгой” гээд энэ дээр биччихсэн байна лээ. “Эрдэнэс Тавантолгой” чинь бол

өөрөө нээлттэй олон нийтийн компани. Монголын бүх хүн хувьцаагаа эзэмшиж байгаа.

Тэгтэл энэ хүмүүсээс ямар нэгэн зөвшөөрөл авсан юм уу, энэ компанийнх нь төлбөрийн чадварт тийм их хэмжээний 140, 50 сая доллароор нь өгөөд байх мөнгө 25, 26 оных нь тэр төсөв дээр байх уу гэдгийг бас тодруулмаар байна. Уг нь энэ чинь зээлийн шийдвэр гаргахад хүртэл бүх материал тодорхой болоод ирчихсэн байхад банк зээл олгох шийдвэрээ гаргадаг. Гэтэл энэ “Эрдэнэс Тавантолгой” ч юм уу, “Эрдэнэс Монгол”-той холбоотой тэр 15 хувийг бид нар ингээд шийдвэрлэчихсэн гэсэн бичиг, зөвшөөрөл гэдэг юм уу ирсэн юм байгаа юу?

Сүүлд нь болохоор энэ Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар 2024 оны санхүүгийн хийсэн аудитын тайлангаар 12.7 тэрбумын зөрчилтэй байгаа. Энэ дээр зориулалт бусаар үр ашиггүй зарцуулсан 3.2 тэрбум, анхан шатын баримтын бүрдэлгүй 1.9 тэрбум, Тендерийн хууль зөрчсөн 7.6 тэрбум гээд. Тэгээд бид нар маш их хэмжээний 920 орчим сая долларын асуудал ярьж байтал дахиад энэ хариуцлагагүй байдал үргэлжлэх үү, энэ дээр яаж хариуцлага тооцож, хяналттай ажиллаж чадах вэ гэдэг ийм 4 асуулт дээр хариулт авъя.

**Б.Пүрэвдорж:** Индрийн 4 дүгээр номер. Нийслэлийн Засаг дарга Нямбаатар, Хишигээгийн Нямбаатар.

**Х.Нямбаатар:** Би эхлээд “Эрдэнэс Монгол”-той холбоотой асуудал энэ танилцуулга дээр алдаатай очсон байна. “Эрдэнэс Тавантолгой” гэдэг компанитай нийслэл огт энэ төрлийн зам дээр харилцаа үүсгээгүй. “Эрдэнэс Монгол” компани Монгол Улсын Их Хурлаас батлагдсан Аж ахуйн нэгжийн орлогын албан татварынхаа 1 хувийг нийгмийн төсөл, хөтөлбөрүүдэд зарцуулах энэ хүрээндээ 15 хувь дээр нь санхүүжилт гаргая. Эргээд нийслэл Улаанбаатар хот эргээд тооллоороо энэ 15 хувийг гаргасан төлбөрийг нь бүтээн байгуулалт дууссанаас хойш тодорхой графикийн дагуу “Эрдэнэс Монгол”-ын аж ахуйн нэгжийн орлогын албан татварын чөлөөлөгдөж байгаа 1 хувийг нь буцааж “Эрдэнэс Монгол”-д төлье гэдэг ийм нөхцөлөөр Монгол Улсын Засгийн газрын тогтоол гарсан гэдгийг нэгдүгээрт хэлье.

Хоёрдугаарт, Цогтбаатар гишүүний асуусан энэ та нар ямар хожуу оруулж ирдэг юм бэ гээд ярьж байна. Энэ тойрог хурдны зам байгуулах шийдвэрийг бид нар 2024 оны 11 дүгээр сард Нийслэлийн Засаг даргын 2024-28 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг батлахдаа энэ төслийг эрэмбийн хоёрдугаарт оруулсан байгаа. Ингээд энэ гарсан шийдвэрийн дагуу бид нар ажлын даалгавар боловсруулж, олон улсын нээлттэй тендер зарлаад, гүйцэтгэгчээ шалгаруулаад, одоо олон улсад стандарт мөрдөгддөг концепт, дизайн бүхий ТЭЗҮ-ийг бараг хамгийн хурднаар боловсруулаад өнгөрсөн 7 хоногт Зам, тээврийн яамны Хөгжлийн төвөөр оруулж эцэслэн батлуулсан. Энэ бол бид хурдын хувьд хамгийн дээд зэргийн хурдаараа л явж байгаа л ийм л төсөл гэж хэлж болно.

Ер нь нийслэл дээр сая Жавхлан сайд хэлж байна ер нь ийм банкны шаардлагад хангасан концепт дизайн бүхий бараг 10 орчим төслүүд байгаа. Бид нар эндээ хамгийн чухлыг, хамгийн богино хугацаанд түгжрэлийг бууруулах эдийн засгийн үр өгөөж зэргийг харгалзан үзэж тойрог хурдны замыг 1 дүгээр эрэмбэдээ оруулж ирж ингээд та бүхэнд танилцуулж байна гэдгийг хэлье.

**Б.Пүрэвдорж:** Тэгэхээр би хамгийн түрүүнд асуулттай байсан хойшлуулчихсан байгаа. Тэгэхээр нийслэлийн энэ яасан гэнэ? Дуусаагүй байгаа. Даваагийн Цогтбаатар гишүүн нэмж тодруулъя. Хишгээгийн Нямбаатар дарга индрийн 4 дүгээр номер.

**Х.Нямбаатар:** Би Цогтбаатар гишүүний тэр Хөрөнгө оруулалтын газартай холбоотой хариулт өгье. Өрийн удирдлагын тухай хуульд Засгийн газрын баталгаа гаргах аж ахуйн нэгжид тавигддаг 1 шалгуур байдаг. Энэ нь сүүлийн 3 жил дараалан ашигтай ажилласан байх гэдэг шалгуур байгаа. Нийслэл Улаанбаатар хот 100 гаруй төсөл юутай, байгууллага энэ Нийслэлийн Засаг даргын доор аудитын хяналт шалгалт доор ордог. Эдгээр байгууллагуудаас зөрчил гарсан саяын таны дурдаж байгаа тэр 17 орчим тэрбум төгрөгийн зөрчлийн гол үндсэн зөрчил нь юутай холбоотой гарсан бэ гэхээр Хан-Уул дүүрэгт баригдсан 2 барилга байгууламж дээр урьдчилгаа төлбөрийн олгохдоо 30 хувиас илүү хэмжээгээр урьдчилгаа төлбөрийг олгосон гэдэг ийм зөрчил гаргасан. Энэ гаргасан зөрчлийг тухай бүрд нь бид нар арилгаад ингээд явж байгаа. Үлдсэн 100-гаад.../минут дуусав./

**Б.Пүрэвдорж:** Тэгэхээр, одоо болно оо. Тэгэхээр би асуултаа асууя. Тэгэхээр энэ Засгийн газрын өрийн баталгаа гаргах энэ асуудлыг дэмжиж байгаа. Яагаад гэвэл энэ түгжрэл бол Монголчуудын цаг хугацаа, эд хөрөнгө, санаа сэтгэл, эрүүл мэндийг хохироодог ийм асуудалтай зүйл. Тийм учраас энэ төслийг дэмжиж энэ түгжрэлийг бууруулах тал дээр арга хэмжээ авч байгаа. Үүнийг нь илүү хурдан шуурхай явуулах энэ ажлыг хийх ёстой.

Өөрөөр хэлбэл, өрийн баталгаа гаргана гэдэг одоохондоо Засгийн газрын өр болохгүй. Харин энэ төсөл хэрэгжихгүй удаашрах аль эсвэл дампуурах тохиолдол энэ өр бол энэ баталгаа бол Засгийн газрын өр болж хувирна. Тэгэхээр энэ Жавхлан сайд сайдаас 1 асуулт асууя. Яг одоо ашигтай, 3 жилийн туршид ашигтай ажиллаж байгаа аймгууд өөрсдөө бонд гаргах ийм хууль, эрх зүйн нээгдсэн байгаа. Тэгэхээр энэ бонд гаргах аймгуудын яг шаардлагыг нь хангаж байгаа аймгууд ямар ямар аймгууд байдаг юм бэ? Энэ дээр өр нь бонд гаргах тохиолдолд илүү үр дүнтэй төслүүдэд хэрэгжүүлэхэд Засгийн газар дэмжиж ажиллах уу? Энэ дээр бас тодорхой хариулт өгөөч.

**Б.Жавхлан:** Пүрэвдорж гишүүний асуултад хариулъя. Энэ хуулийг анхнаас нь л Засгийн газар дэмжсэн юм. Тийм. Тэгэхдээ одоо хэдүүлээ хэрэгжилт дээрээ маш болгоомжтой, эрсдэлээ маш сайн тооцоолж байж хийх хэрэгтэй. Хууль гаргаад авах нь нэг хэрэг. Яах вэ аймгуудаас одоо идэвхтэй судлагдаж байгаа нь бол Өмнөговь аймаг дээр бид яг Сангийн яам орон нутагтай хамтраад ажлын хэсэг гаргаад ингээд ажиллаж байгаа. Яах вэ аймгуудын хэмжээнд ямар хэмжээний бонд гаргахаасаа л болно.

Дээр нь тухайн бондыг гаргаад юунд зарцуулах вэ гэдгээс хамаг юм шалтгаална. Бонд бол ингээд үсрээд л 5-10 жилийн хугацаанд шүү дээ. Тийм учраас ийм богино хугацаанд үр өгөөжөө өгөөд эргээд аймаг өөрөө орлогоороо энийгээ нөхөөд явах, төсөв дээр ямар эрсдэл авчрахгүйгээр явах энэ эрсдэлийн судалгаа, тооцоолол өөрөө маш чухал.

Тийм учраас аймгууд маань энэ дээр бас хүний нөөцийн хувьд арай бэлэн биш байна. Тийм учраас эхний ээлжид яг Сангийн яамны зүгээс мэргэжлийн баг гаргаад эхнээсээ аймгуудтай ингээд тулж ажиллаад явж байна. Удахгүй Өмнөговь аймаг дээр анхны орон нутгийн бонд гаргах ийм асуудал Улсын Их Хурлаар орж ирнэ. Тийм. Тэгэхээр энэ нөхцөл байдал аймаг бүр дээр өөр өөр байгаа. Мэдээж улсын төсөвт орлого төвлөрүүлдэг, зарлагаасаа давсан орлоготой ийм аймгууд дээр л эхний боломж нь байгаа. Бид 6 аймаг их олон жил ингэж явж ирсэн. Сүүлийн жилүүдэд Төв аймаг нэмэгдэх гээд орж ирж байсан боловч энэ цахилгаан, дулааны тариф нэмэгдсэнтэй холбоотойгоор төсвийн байгууллагууд дээр суурь зардлууд нэмэгдэж байгаа. Эргээд аймгууд маань энэ зардал өссөнтэй холбоотойгоор орлого, зарлага нь бас нэлээн хэдэн аймаг давах болж ирж байгаа. Өөрөөр хэлбэл, шууд бонд гаргах хэмжээний орлоготой аймгууд тэр хэмжээгээр цөөрч байгаа гэсэн үг шүү. Тийм, тэгэхээр ер нь бол эхний ээлжид ямар ч байсан Өмнөговь аймаг дээр бэлдэж байгаа.

**Б.Пүрэвдорж:** Баярлалаа. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Үг хэлэх гишүүд нэр өгөөгүй байгаа. Үг хэлэх гишүүн байхгүй учраас үг хаалаа.

Одоо Байнгын хорооны саналаар “Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулна.

Гишүүд санал хураалтдаа бэлтгэе.

Эхлээд ирцийн санал хураалт явуулаадахъя. Хүрээгүй байна уу тээ? Ирц арай хүрээгүй байна. Их Хурлын ажлын алба, туслахууд гишүүдээ дуудаарай танхимдаа. Хотын захиргааныхан бас энэ ирцдээ анхаараарай. Энэ сайд нар байхгүй байна шүү. Жавхлан сайдаас бусад нь ерөөсөө энэ хуралд орж ирэхгүй байна шүү. Ирцийн санал хураалт явуулъя.

Үгүй энэ саяынх ирцийн санал хураалт.

“Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана.

97 гишүүнээс 61 гишүүн санал өгч, 62.9 хувиар дэмжигдлээ.

Бадамдоржийн Пунсалмаа гишүүн дэмжсэнээр протоколд тэмдэглүүлж байна. Галбадрах гишүүн дэмжсэнээр.

“Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг гишүүдийн олонх дэмжсэн тул төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүллээ.

Одоо чуулган түр завсарлаж байна. Байнгын хороод хуралдаж, гишүүдийгээ баталгаажуулах, Байнгын хорооны даргыг томилох энэ ажил яаралтай хийе. Хурлыг жич зарлана.

09:35 цаг

**Лхагва гараг 09 Долоодугаар сар 2025**

**Төрийн ордон “Их хуралдай” танхим 13 цаг 35 минут**

**Б.Пүрэвдорж:** Хурлаа эхэлье. 2025 оны 7 дугаар 9 сарын 9-ний үдээс хойших нэгдсэн чуулган эхэлж байна.

Монголынхоо ард түмний энэ өдрийн амар амгаланг айлтгая. Монгол орон даяар аймаг, сумдын наадам эхэлж байгаа. Бүгдээрээ сайхан наадахын ерөөлийг өргөө. Монгол төрийн наадам 11-ндээ эхэлнэ. Монгол орон даяараа дэнж хотойтол сайхан наадахын ерөөлийг өргөн дэвшүүлье.

Ингээд дараагийн асуудал буюу хэлэлцэх асуудал 4.

**Харьяатын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл, Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг нарын 9 гишүүн 2025 оны 6 сарын 19-ний өдөр өргөн мэдүүлсэн анхны хэлэлцүүлэг.**

Асуулт, хариулт 60 минут юм байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Харьяаллын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Төслүүдийн анхны хэлэлцүүлэгт хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Даваагийн Цогтбаатар танилцуулна. Индэрт урья.

**Да.Цогтбаатар:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг нараас 2025 оны 6 дугаар сарын 19-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Харьяатын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг 2025 оны 7 дугаар сарын 2-ны өдөр Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Хууль зүйн байнгын хороо 2025 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн хуралдаанаараа хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан бөгөөд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсэгт заасны дагуу хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн талаар зарчмын зөрүүтэй саналын томьёолол гараагүй тул Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.24 дэх хэсэгт заасны дагуу хуулийн

төслийн анхны хэлэлцүүлгээс эцсийн эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Харьяатын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Б.Пүрэвдорж:** Ажлын хэсэг хууль санаачлагч нар өөрсдөө юм байна.

Одоо Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна.

3-уулаа байхгүй байна. Эрдэнэболд, Шижир, Алтангэрэл нар асуух асуулттай гишүүд алга байна.

Гишүүд асуулт асуух хүн байсангүй.

Байнгын хорооны санал хураалтыг нэгтгэж явуулна. Санал хураалтыг хойшлуулъя.

13.40 цаг

**Хэлэлцэх асуудал 5.Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл Засгийн газар 2025 оны 7 сарын 3-ны өдөр өргөн мэдүүлсэн эцсийн хэлэлцүүлэг.**

Асуулт, хариулт 60 минутаар дараагийн.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Жадамбаагийн Баясгалан танилцуулна. Индэрт урья.

**Ж.Баясгалан:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 7 дугаар сарын 4-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар явуулж, эцсийн хэлэлцүүлэгт бэлдүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн.

Төсвийн байнгын хороо 2025 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг Монгол Улсын Их



Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу явууллаа.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг хуулийн төсөлд нэмж тусган төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр үг, хэллэг, бүтцийн шинжтэй засварыг хийж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон Байнгын хорооны танилцуулгыг та бүхэндээ хүргэсэн байгаа болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах энэ хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн хуулийн төслийг эцэслэн баталж өгнө үү.

Анхаарал тавьсан та бүхэнд баярлалаа.

**Б.Пүрэвдорж:** Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Баясгалан гишүүндээ баярлалаа.

Жамсрандоржийн Дэлгэрсайхан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Равсалын Ренчинбазар Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Ганболдын Золбоо Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга. Зарим ажлын хэсгийн гишүүдийн нэрс энд ирээгүй байна.

Ингээд Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирсэн нэрсийн дагуу асуулт асууна.

Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Тэмүүлэн асуулт асууна.

Алга байна.

Гишүүд асуулт байхгүй тул дууслаа.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Төсвийн байнгын хороонд шилжүүлээ.

13.44 цаг

**Хэлэлцэх асуудал 6.Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна.**

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Лувсанжамц танилцуулна. Индэрт урья.

**Г.Лувсанжамц:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлангаас 2025 оны 5 дугаар сарын 2-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хот байгуулалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг 2025 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Эдийн засгийн байнгын хорооны 2025 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн 8 дугаар тогтоолоор хуулийн төслийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдааны хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн миний бие ахалж, гишүүдээр Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн, Р.Батболд, О.Батнайрамдал, Ч.Лодойсамбуу, П.Сайнзориг, А.Ундраа нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан.

Эдийн засгийн байнгын хороо 2025 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасныг баримтлан явуулж дараах санал, дүгнэлтийг гарган та бүхэнд танилцуулж байна.

Ажлын хэсэг 2025 оны 7 дугаар сарын 7-ны өдөр хуралдсан бөгөөд хууль санаачлагчийн өргөн мэдүүлсэн хуулийн төслийг дэмжиж, анхны хэлэлцүүлгийг эцсийн хэлэлцүүлэгтэй хамтатган явуулах горимын санал гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 61.1 хувийн саналаар дэмжлээ.

Хууль санаачлагч Хот байгуулалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д нэмэлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Хот байгуулалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д нэмэлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг буцаан татах тухай албан бичгийг ирүүлснийг Улсын Их Хурлын 2025 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулж, уг хуулийн төслийг буцаан татсанд тооцсон.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хот байгуулалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Б.Пүрэвдорж:** Одоо Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилсан ирсэн нэрсийн дагуу асуулт асууна.

Баасанжаргал, Улсын Их Хурлын гишүүн Баасанжаргал асуулт асууна.



**Х.Баасанжаргал:** Хэн хариулах билээ? Алдаржавхлан гишүүн байгаа билүү? Лука. Асуулт. Миний асуулт маш тодорхой. Одоо ингээд цаашид байгуулагдах, шинээр байгуулагдах хотхон, хот төлөвлөлт дээр нийтийн үйлчилгээний байгууллага буюу боловсрол, эрүүл мэндийн байгууллагыг хэрхэн байгуулахаар төлөвлөж байгаа вэ? Ялангуяа төр, хувийн хэвшлийн түншлэл гэж сүүлийн үед Боловсролын яамнаас их яригдаад байгаа. Тэгэхээр энэ хэлбэр хэрхэн тусаж хүрээ хязгаар нь ямар байгаа вэ гэдэг талаар асуулт.

**Б.Пүрэвдорж:** Хариултыг Ганзоригийн Лувсанжамц гишүүн хариулна.

**Г.Лувсанжамц:** Баасанжаргал гишүүндээ баярлалаа. Энэ хуулийн төслөөр оруулж ирж байгаа 12.6.4 дээр боловсролын байгууллага болон цэцэрлэгийн байгууллагыг ямар хүртээмжтэй байдлаар төлөвлөх вэ гэдэг заалт орж ирсэн. Энэ маань уг нь барилгын норм ба дүрмийн 25.01.20 дээр байдаг уг нь стандарт. Гэвч харамсалтай нь бид нар өнөөдрийг хүртэл яг энэ стандартынхаа дагуу сургууль, цэцэрлэгүүдийг байршуулах, төлөвлөх ажлыг ерөөсөө хийж эхэлж байгаагүй, хэрэгжүүлж байгаагүй. Тэгээд энэ зүйлийг хуулийн хэмжээнд нь хуульд нь тусгаж өгөөд цаашдаа энэ тоогоо баримтлаад явъя гэж байгаа.

Энэ ямар тоо вэ гэхлээр нэгдүгээрт нь 250 хүртэлх өрх тутамд 1-ээс доошгүй цэцэрлэг, 1000 хүртэлх өрх тутамд 1-ээс доошгүй төрийн өмчит сургуулийг төлөвлөж тооцно гэж байгаа юм.

Хоёрдугаарт, бас хэрэгжүүлэх тал дээр энэ хуулийн төсөл дээр оруулсан авууштай заалт байгаа. Энэ бол орон нутгийн засаг захиргаанууд хот төлөвлөлтийн бичиг баримтыг баталж, хэрэгжүүлэхдээ энэ стандартыг барьсан эсэхийгээ эргээд тайлагнадаг байх ёстой гэсэн тийм заалтууд тусаж өгч байгаа болохлоор цаашдаа энэ хууль батлагдсанаар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө дээр энэ тоонууд, стандартууд хүртээмжүүд баригдаад явна гэсэн тийм төлөвлөгөөтэй байгаа.

**Б.Пүрэвдорж:** Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүний асуултад хариуллаа.

Одсүрэнгийн Номинчимэг гишүүн асуулт асуухаа болилоо гэнэ. Дамдинсүрэнгийн Жаргалсайхан гишүүн? Түр хойшлуулаад, Банзрагчийн Түвшин гишүүн. Энэ ирцээ сайжруулна шүү нөхдүүд. Энэ хуулийн хэлэлцүүлгүүд чанартай явах ёстой. Гишүүд асуулт асууж, олон түмэнд энэ хуулийн учир, ач холбогдлын талаар мэдээллүүдийг бүрэн дүүрэн өгөх ёстой.

Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Санал хураалтыг энэ нэгтгэж явуулна. Санал хураалтыг хойшлуулъя.

13.50 цаг

**Хэлэлцэх асуудал 7. “Зарим Байнгын хорооны даргыг сонгох тухай” асуудлыг хэлэлцье.**

Аюулгүй байдал гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Нацагдоржийн Батсүмбэрэл танилцуулна.

Батсүмбэрэлийн оронд 1 хүн танилцуул даа Байнгын хорооных нь. Санал, дүгнэлт бэлэн болсон юм уу? Гишүүн нь хэн байна? Очирбат гишүүн танилцуулчих. Танилцуулга хийх гишүүдийг чуулганы танхимд бэлэн байлгаарай.

**Г.Очирбат:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалт, 25 дугаар зүйлийн 25.7 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудлыг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2025 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцээд дараах санал, дүгнэлтийг танилцуулж байна.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Ж.Бат-Эрдэнэ Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7 дахь хэсэг Байнгын хорооны даргыг сонгохдоо Улсын Их Хуралд сонгогдон ажилласан хугацаа, туршлагыг нь харгалзан тухайн Байнгын хорооны гишүүдээс сонгох бөгөөд түүнийг улираан сонгож болно гэж заасны дагуу Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны даргад Монгол Улсын Их Хуралд сонгогдон ажилласан туршлага, төрийн ажлын мэдлэг, ур чадварыг нь харгалзан Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Тэмүүлэнг улираан нэр дэвшүүлсэн болно.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны даргад Монгол Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Тэмүүлэнг улираан нэр дэвшүүлснийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудлыг хэлэлцсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсан та бүхэнд баярлалаа.

**Б.Пүрэвдорж:** Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Лутаагийн Энхнасан танилцуулна. Индэрт урья.

**Л.Энхнасан:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалт, 25 дугаар зүйлийн 25.7 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудлыг Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо 2025 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцэж дараах санал, дүгнэлтийг та бүхэнд танилцуулж байна.

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурал дахь ХҮН намын зөвлөлөөс нэр дэвшигчийг төрийн ажлын мэдлэг, ур чадвар харгалзан Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны даргад Улсын Их Хурлын гишүүн Бадрах овогтой Найдалааг нэр дэвшүүлж хэлэлцүүлээ.

Найдалаа нь 1975 онд төрсөн. Эхнэр 3 хүүхдийн хамт амьдардаг. 1993 онд нийслэлийн 23 дугаар сургуульд бүрэн бүрэн дунд боловсрол эзэмшиж, 1997 онд СЭЗДС-ийг Бизнесийн удирдлагын бакалавр, 2004 онд Япон Улсын Кобе их сургуулийн Эдийн засгийн ухааны магистр, Хөгжлийн эдийн засагч мэргэжлээр төгссөн.

1997 оноос 2000 он хүртэл СЭЗДС-д эдийн засгийн онолын багш, 2004 оноос 2008 онд “Анод” болон “Хаан” банкны Эрсдэлийн удирдлагын газрын захирал, эдийн засагч, 2008, 2011 онд Эм Си Эс группийн “Юнител” ХХК-ийн газрын захирал, 2011-2020 онд Монголын эдийн засгийн форумын гүйцэтгэх захирал, Тогтвортой ногоон санхүүжилтийн хөгжлийн холбооны гүйцэтгэх захирал, 2016 оноос 2024 он хүртэл ХҮН намын дарга, Удирдах зөвлөлийн гишүүн, 2024 оноос Монгол Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдон ажиллаж байна.

Байнгын хорооны хуралдааны үеэр нэр дэвшигчээс асуулт асууж, хариулт аваагүй болно.

Хүний хөгжлийн, нийгмийн бодлогын байнгын хорооны даргад Улсын Их Хурлын гишүүн Бадрахын Найдалааг нэр дэвшүүлснийг хуралдаанд оролцох гишүүдийн олонх буюу 94.7 хувийн саналаар дэмжигдсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудлыг хэлэлцсэн талаарх Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**Б.Пүрэвдорж:** Лутаагийн Энхнасан гишүүнд баярлалаа.

Өргөдлийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Даваасамбуугийн Ганмаа танилцуулна. Индэрт урья.

**Д.Ганмаа:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалт, 25 дугаар зүйлийн 25.7 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн Байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх тухай асуудлыг Өргөдлийн байнгын хороо 2025 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцээд дараах санал, дүгнэлтийг танилцуулж байна.

Өргөдлийн байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дэд дарга А.Ариунзаяа тус Байнгын хорооны даргад хууль, эрх зүйн мэдлэг, боловсрол, ур чадвар болон ажлын туршлагыг харгалзан Улсын Их Хурлын гишүүн Одсүрэнгийн Номинчимэгийг нэр дэвшүүлсэн болно.

Одсүрэнгийн Номинчимэг нь 1998 онд Нийслэлийн ерөнхий боловсролын 2 дугаар сургууль, 2001 онд МУИС-ийн харьяа Монгол-Туркийн хамтарсан Байгалийн ухааны төрөлжсөн дунд сургууль, 2004 онд Токиогийн Гадаад хэлний их сургууль, 2008 онд Токиогийн их сургуулийг тус тус төгссөн. Эрх зүйч мэргэжилтэй. 2010 онд Харьцуулсан эрх зүйгээр магистрын зэргийг Токиогийн их сургуульд, 2015 онд Хууль зүйн магистрын зэргийг Колумбын Хуулийн сургуульд тус тус хамгаалж амжилттай төгссөн.

Тэрээр 2010-аас 11 онд “Мицубушик” корпорацийн Улаанбаатарын салбарын хууль, эрх зүйн ашигт малтмалын төсөл хариуцсан ажилтан, 2011-2017 онд Хоган Ловеллс Монголиа-д ахлах хуульч, 2017, 2019 онд өмгөөллийн “Авинекс Партнерс” ХХН-ийг хамтран үүсгэн байгуулж, гишүүнээр, 2019-2021 онд өмгөөллийн “Номин энд Адвокатс” ХХН-ийг үүсгэн байгуулж, гүйцэтгэх захирлаар, 2021 оноос 2022 онд Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга, 2022-2023 онд Монгол Улсын Их Хурлын даргын Хууль зүйн бодлогын зөвлөх, 2023-2024 онд Нийслэлийн Засаг даргын орлогч, 2024 оноос Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдон ажиллаж байна.

Байнгын хорооны хуралдааны үед нэр дэвшигчээс Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь Улсын Их Хурлын иргэдийн өргөдөл, гомдол хүлээн авах цахим платформд тухайн асуудлаар 100 мянган иргэнээс дээш иргэн гомдол ирүүлсэн бол Улсын Их Хурал уг асуудлыг авч хэлэлцэхээр тусгасан боловч зарим асуудлыг орхигдуулан үзэмжээр шийдвэрлэж байгаа асуудлыг судалж, холбогдох журмыг өргөдөл, гомдол ирж байгаа боловч асуудлыг шийдвэрлэхгүй, аймаг, сум, баг гэх мэт засаг захиргаа нэгж болгоноор дамжуулан шилжүүлж, уг асуудлыг шийдвэрлэхгүй иргэнийг чирэгдүүлдэг асуудлыг судалж, тодорхой шийдлүүдийг гарган ажиллах талаар асуулт асуусан болно.

Түүнчлэн Байнгын хорооны хуралдааны үеэр нэр дэвшигчийг дэмжиж Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц олон улсын байгууллагад ажиллаж байсан туршлагатай нэр дэвшигчийг дэмжиж байгаагаа илэрхийлээд хүний эрхийн мэдрэмжтэйгээр иргэдийн өргөдлийг шийдвэрлэх тогтолцоог бий болгоход хамтран ажиллаж дэмжих талаар, Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат тус байгууллагын хороо нь төр, иргэнийг холбох гол гүүр гэдгийг онцлон тэмдэглээд, иргэдийн өргөдөл гаргаад байгаа шалтгаан, нөхцөл, мөн чанарыг судалж, дүн шинжилгээ хийх. Мөн өргөдөл, гомдлын статистикт үндэслэн аль салбар, яамдад хамааралтай асуудлаас иргэдээс хамгийн их тоогоор өргөдөл, гомдол ирж байгааг судлан нөхцөл байдлыг тодорхойлох, газар дээр нь судалж танилцах зэргээр идэвхтэй ажиллаж дэмжих талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргал нэр дэвшигчийг дэмжиж буйгаа илэрхийлэн төрийн хууль тогтоох байгууллагуудын иргэдийн сонсох гол гүүр гэдгийг дурдан цахимаар ирж буй өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журмыг илүү нарийвчлах процессыг тодорхой болгох.

Тухайлбал, тухайн асуудлаар ирүүлсэн иргэдийн гомдол, өргөдөл тодорхой хувьд хүрмэгц холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх гэх мэтээр илүү нарийвчлах шаардлагатай байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Галбадрах боловсролын салбарын талаар мэдээлэл сайтай нэр дэвшигч дэвшиж буй дэмжиж байгаагаа илэрхийлэн судлаач, эрдэмтдээс ирүүлсэн саналууд нь бодлогын түвшинд шууд хүрэлцэхүйц чухал ач холбогдолтой тул зөвхөн ажлын хэсэгт бус Байнгын хороонд танилцуулах шаардлагатай учир уг боломжийг нээлттэй болгох, эрх зүйн орчныг боловсронгуй болгоход санаачилгатай ажиллах талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Рэгдэл Улсын Их Хурал чухал Байнгын хороод дахин байгуулагдаж буйд талархаж байгаагаа илэрхийлээд Улсын Их Хуралд ирсэн өргөдөл, гомдлыг судлан дүн шинжилгээ хийж, холбогдох Байнгын хороонд асуудлыг тавьж, иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх механизмд илүү тодорхой болж байгааг дурдан нэр дэвшигчийг дэмжин үг хэллээ.

Өргөдлийн байнгын хорооны даргад Улсын Их Хурлын гишүүн Одсүрэнгийн Номинчимэг нэр дэвшүүлснийг хэлэлцэж санал хураахад Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн 100 хувийн саналаар дэмжсэн болно.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх тухай асуудлыг хэлэлцэх талаар Өргөдлийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Байнгын хорооны хуралдааны даргалагч Д.Рэгдэл.

**Х.Булгантуяа:** Нэр дэвшигчдээс дэвшигчээс асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье.

Байхгүй байна.

Одоо Байнгын хороодын санал, дүгнэлтээрээ санал хураалтыг нэгдсэн журмаар хамтдаа явуулъя.

Дараагийн асуудал санал хураалт. Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны даргаар энэ Байнгын хорооны дарга нарыг дараачийнхад нь шууд нэгдсэн журмаар явуулъя гэсэн тээ. Тэгвэл дараагийн асуудалдаа орёё.

14.02 цаг

**Монгол Улсын Их Хурлын зарим дэд хорооны бүрэлдэхүүний тухай Улсын Их Хурлын тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудал хэлэлцэж эхэлье.**

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Мөнгөнцогийн Ганхүлэг танилцуулна. Индэрт урьж байна.

**М.Ганхүлэг:** Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 27 дугаар зүйл Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн Агаар, орчны бохирдлын болон Хүнс, хөдөө аж ахуйн дэд хорооны бүрэлдэхүүний тухай асуудлыг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн Байнгын хороо 2025 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн хуралдаанаар хэлэлцээд дараах санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулж байна.

Агаар, орчны бохирдлын дэд хороог Улсын Их Хурлын гишүүн Наранцэцэгийн Алтаншагай, Бат-Өлзийн Бат-Эрдэнэ, Ухнаагийн Отгонбаяр, Нанзадын Наранбаатар, Сонгобайгийн Замира, Агваанлуvsангийн Ундраа, Жаргалсайханы Золжаргал, Салдангийн Одонтуяа, Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан, Жигжидсүрэнгийн Чинбүрэн нарын, Хүнс, хөдөө аж ахуйн дэд хороог Улсын Их Хурлын гишүүн Мэндбаярын Мандхай, Жигжидийн Батжаргал, Пүрэвийн Батчимэг, Цагаанхүүгийн Идэрбат, Тогтмолын Мөнхсайхан, Загджавын Мэндсайхан, Сүрэнжавын Лүндэг, Баатаржавын Мөнхсоёл, Цэвэгдоржийн Туваан, Дамдинсүрэнгийн Жаргалсайхан, Цагаанхүүгийн Мөнхбат нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулахыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Агаар, орчны бохирдлын болон Хүнс, хөдөө аж ахуйн дэд хорооны бүрэлдэхүүний тухай асуудлыг хэлэлцсэн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Х.Булгантуяа:** Одоо Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Аюушийн Ариунзаяа танилцуулна. Индэрт урьж байна.

**А.Ариунзаяа:** Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 27 дугаар зүйл, Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 22 дугаар зүйлд заасныг тус тус үндэслэн Бүсчилсэн хөгжлийн болон Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүний тухай асуудлыг Төрийн байгуулалтын байнгын хороо 2025 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Бүсчилсэн хөгжлийн дэд хорооны бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн Мягмарсүрэнгийн Бадамсүрэн, Жадамбын Бат-Эрдэнэ, Энхбатын Болормаа, Нямтайширын Номтойбаяр, Бөхчулууны Пүрэвдорж, Цэндийн Сандаг-Очир, Цэвэгдоржийн Туваан, Гончигдоржийн Уянгахишиг, Цагаанхүүгийн Идэрбат нарын, Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнд Оюунсайханы Алтангэрэл, Аюушийн Ариунзаяа, Баярмагнайн Баярбаатар, Чинбатын Номин, Чулуунбилэгийн



Лодойсамбуу, Отгоны Саранчулуун, Бадарчийн Хэрлэн, Өлзийхүүгийн Шижир, Доржзовдын Энхтуяа нарын нэрийг дэвшүүлснийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Бүсчилсэн хөгжлийн болон Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүний тухай асуудлыг хэлэлцсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, Монгол Улсын Их Хурлын дэд хорооны бүрэлдэхүүний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталж өгөхийг та бүхнээсээ хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Х.Булгантуяа:** Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Мөнгөнцогийн Ганхүлэг танилцуулна. Индэрт урьж байна.

**М.Ганхүлэг:** Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэг, 27.3.3 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн хуулийн 22 дугаар зүйлийн 22.3 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн Боловсрол, шинжлэх ухааны болон Соёл, спорт, залуучуудын дэд хорооны бүрэлдэхүүний талаарх асуудлыг Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо 2025 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцээд дараах санал, дүгнэлтийг та бүхэнд танилцуулж байна.

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дэд дарга Ариунзаяа дэд хороодын бүрэлдэхүүний талаар танилцуулга хийсэн болно.

Байнгын хорооны хуралдааны үед Улсын Их Хурлын гишүүн Бум-Очир гишүүд 2 дэд хороонд орж ажиллах боломжтой эсэх талаар асуулт асууж, хариулт авлаа.

Хүний хөгжлийн, нийгмийн бодлогын байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх Боловсрол шинжлэх ухааны дэд хорооны бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн Ц.Баатархүү, Д.Бум-Очир, Ж.Галбадрах, А.Ганбаатар, С.Зулпхар, С.Мөнхтуяа, Д.Рэгдэл, Г.Хосбаяр, Б.Хэрлэн нарыг Соёл, спорт, залуучуудын дэд хорооны бүрэлдэхүүнд Ш.Бямбасүрэн, Д.Ганмаа, М.Ганхүлэг, М.Нарантуяа-Нара, О.Саранчулуун, М.Сарнай, Д.Энхтуяа, М.Энхцэцэг, С.Эрдэнэбат нарыг оруулах саналыг дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Боловсрол, шинжлэх ухаан болон Соёл, спорт, залуучуудын дэд хорооны бүрэлдэхүүний тухай асуудлыг хэлэлцсэн талаарх Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**Х.Булгантуяа:** Одоо Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Чинбатын Номин танилцуулна. Индэрт урьж байна.

**Ч.Номин:** Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3.5 дахь заалт Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3 дахь хэсгийг заасныг үндэслэн Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай асуудлыг Төсвийн байнгын хорооны 2025 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн хуралдаанаар хэлэлцээд дараах санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулж байна.

Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн Жуковын Алдаржавхлан, Чинбатын Номин нарыг нэр нэмж оруулахаар санал гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцсэн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Баярлалаа.

**Х.Булгантуяа:** Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Хүрэлбаатарын Баасанжаргал танилцуулна. Баасанжаргал гишүүн хаачив? Дараагийнх нь танилцуулчихъя. За.

**Х.Баасанжаргал:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Хууль зүйн байнгын хороо 2025 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн хуралдаанаараа Улсын Их Хурлын хүний эрхийн дэд хорооны бүрэлдэхүүний тухай асуудлыг хэлэлцлээ.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.7 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3 дахь хэсэг, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлэг, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэг болон бусад Байнгын хорооны гишүүдийн саналыг үндэслэн Хүний эрхийн дэд хорооны бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн Хүрэлбаатарын Баасанжаргал, Мөнхтөрийн Нарантуяа-Нара, Одсүрэнгийн Номинчимэг, Пүрэвжавын Сайнзориг, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин, Гончигдоржийн Уянгахишиг, Сүхбаатарын Эрдэнэболд, Лхагвасүрэнгийн Соронзонболд, Баттөмөрийн Энхбаяр, Оюунсайханы Алтангэрэл, Баярмагнайн Баярбаатар, Жудгийн Баярмаа нарын гишүүдийг оруулах саналыг чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжлээ.



Улсын Их Хурлын эрхэм гишүүдээ,

Монгол Улсын Их Хурлын хүний эрхийн дэд хорооны бүрэлдэхүүний тухай асуудлыг хэлэлцсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Х.Булгантуяа:** Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Лхагвасүрэнгийн Соронзонболд танилцуулна. Индэрт урьж байна.

**Л.Соронзонболд:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 27 дугаар зүйл, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3, 22.5 дахь хэсгийг үндэслэн Эдийн засгийн байнгын хороо 2025 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн хуралдаанаараа Аялал жуулчлалын хөгжлийн дэд хороо, Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийн дэд хороо, Инновац, цахим бодлогын хөгжлийн дэд хороо, Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулах тухай асуудлыг хэлэлцлээ.

Байнгын хороодын гишүүдийн зүгээс аялал жуулчлалын хөгжлийн дэд хорооны бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн Ринчиндоржийн Батболд, Нацагдоржийн Батсүмбэрэл, Шинэбаярын Бямбасүрэн, Ганзоригийн Лувсанжамц, Эрдэнэбилэгийн Одбаяр, Буяагийн Тулга, Мөнхчулууны Энхцэцэг нарын гишүүдийг, Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийн дэд хорооны бүрэлдэхүүнд Жуковын Алдаржавхлан, Цэндийн Баатархүү, Мягмарсүрэнгийн Бадамсүрэн, Отгоншарын Батнайрамдал, Пүрэвийн Батчимэг, Жамбалын Ганбаатар, Ренчинбямбын Сэддорж нарын гишүүдийг, Инновац, цахим бодлогын хөгжлийн дэд хорооны бүрэлдэхүүнд Чинбаатарын Анар, Цэндийн Баатархүү, Ринчиндоржийн Батболд, Жадамбын Бат-Эрдэнэ, Хүрэлбаатарын Булгантуяа, Пүрэвжавын Ганзориг, Батбаярын Жаргалан, Лхагвасүрэнгийн Соронзонболд, Буяагийн Тулга нарын гишүүдийг, Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хорооны бүрэлдэхүүнд Батжаргалын Заяабал, Ганзоригийн Лувсанжамц, Мэндбаярын Мандхай, Бадрахын Найдалаа, Бадамдоржийн Пунсалмаа, Агваанлуvsангийн Ундраа, Болдын Уянга, Саруулсайханы Цэнгүүн нарын гишүүдийг оруулах санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүдээ,

Аялал жуулчлалын хөгжлийн дэд хороо, Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийн дэд хороо, Инновац, цахим бодлогын хөгжлийн дэд хороо, Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хороодын бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулах тухай асуудлыг хэлэлцсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Х.Булгантуяа:** Одоо “Монгол Улсын Их Хурлын зарим дэд хорооны бүрэлдэхүүний тухай” Улсын Их Хурлын тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай танилцуулгыг сая сонслоо. Санал хураалтыг дараагийн асуудлыг явуулсны дараагаар нэгдсэн байдлаар зохион байгуулъя.

14.13 цаг

9 дүгээр асуудалдаа оръё. **“Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл анхны хэлэлцүүлгийг явуулна.**

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Пүрэвжавын Сайнзориг танилцуулна. Индэрт урьж байна.

**П.Сайнзориг:** Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 7 дугаар сарын 7-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэхээс хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар явуулж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Төсвийн байнгын хороо 2025 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн хуралдаанаараа дээрх тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлд заасны дагуу явууллаа.

Тогтоолын төслийн анхны хэлэлцүүлэг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Р.Батболд, Даваагийн Цогтбаатар, Г.Ганбаатар, Б.Жаргалан нар Засгийн газрын өрийн баталгаа гаргаж хэрэгжүүлэх төслийн өртөг, зардлын тооцооны талаар болон төсөл хэрэгжиж эхлэх бэлтгэл ажил хангагдсан эсэхийг тодруулан асуулт асууж, хариулт авсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гараагүй тул Улсын Их Хурлын гишүүн Төсвийн байнгын хорооны дарга Х.Ганхуяг тогтоолын төслийг анхны хэлэлцүүлгээр батлуулах горимын санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүдээ,

“Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсан явдалд баярлалаа.

**Х.Булгантуяа:** Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Хишгээгийн Нямбаатар Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Солонгын Тулга Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, Луулайн Хосбаяр Нийслэлийн санхүү, эдийн засаг, хөгжлийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх төсөл, хөтөлбөрийн зохицуулагч, Маамбын Үнэнбат Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга, Эрдэнийн Түвшинжаргал Нэгдсэн төслийн удирдлагын газрын захирал, Лувсандоржийн Гантогтох Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга гэсэн ажлын хэсгийн бүрэлдэхүүнтэй байна.

Одоо Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна.

2 гишүүний нэр ирсэн байна. Улсын Их Хурлын гишүүн Гомбын Ганбаатар? Байхгүй байна Улсын Их Хурлын гишүүн Банзрагчийн Түвшин.

**Б.Түвшин:** Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Тэгээд энэ өрийн асуудал нэгдүгээрт их яаралтай орж ирж байгаа нь жоохон тиймэрхүү байгаад байгаа. Тэгэхлээр 1км замын өртгийг ер нь хэд гэж тооцов гэдэг тал дээр нэгдүгээрт асуулт асууя.

Хоёрдугаарт яагаад ийм яаралтай орж ирэх болов?

Гуравдугаарт ерөөсөө энэ манай өрийн дээд хязгаар хэд дөхөж байгаа билээ, өрийн дээд хязгаар валютаар хэд байна, төгрөгөөр хэд байна вэ гэсэн ийм 3 асуултад хариулт тавья.

**Х.Булгантуяа:** Ажлын хэсэг 4 номероос хариулъя. 4 номерын микрофоныг өгье.

**Х.Нямбаатар:** Сая Түвшин гишүүн энэ замын нийт өртгийг асуусан. 918 сая доллар гэж ЗЭЗҮ боловсруулсан зөвлөх үйлчилгээ үзүүлсэн компаниас гаргаж өгөөд уг гаргасан төсөв дээр Зам, тээврийн яамны дэргэдэх Зам, тээврийн хөгжлийн төв магадлал хийж Их Хуралд оруулж ирж байгаа.

Энэ өртөг дотор нийтдээ 3800 нэгж талбар газар чөлөөлөлтийн өртөг 214 сая доллароор тооцогдсон байгаа. Үүнээс гадна энэ байгууламж маань туннелийн байгууламжтай 6 эгнээ туннелдэж явах хэсэг байгаа. Мөн үүнээс гадна 14км орчим газар гүүрэн байгууламжаар явахаар байгаа. Эдгээрийн бүх нийлбэр төсөв дээр нь нэмэгдсэн өртгийн албан татвар, гаалийн татвар, бусад нэмэгдэл зардлууд, ажиллах хүчний зардал зэргийг бүгдийг нь багтаасан ийм төсөвт өртөг гэж бидэнд ЗЭЗҮ боловсруулсан ажлын хэсгээс танилцуулсан.

Өр, авлагын харьцаатай холбоотой асуудал дээр Сангийн яамны газрын дарга Тулга дарга хариулах байх. Зүгээр энэ нь бид шууд Засгийн газрын өр гэж үзэх нь буруу байх гэж бодож байна. Тулга дарга нэмж хариулах байх. Бид ТЭЗҮ-гээ үндэслээд ЕСР нөхцөлөөр тендерээ зарлаад тэгээд санхүүжилтээ дэд бүтцийн төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлдэг банкнуудаас энэ санхүүжилтийг босгоно. Бид нар ойролцоогоор 10 жилийн дотор энэ төслийнхөө гаргасан зардлыг тооллоороо

эргэн төлнө гэсэн нөхцөлтэй байгаа. Ингээд төлөгдөж чадаагүй тохиолдолд мэдээж хэрэг энэ асуудал Засгийн газрын баталгаа руугаа шилжих ийм л нөхцөлтэй.

Өөрөөр хэлбэл, шууд Засгийн газар энэ өр төлбөрийг төлнө гэсэн агуулга гэж ойлгогдохгүй. Энэ өөрөө эргээд тоолуураа төлөх ийм зарчимтай явж байгаа. Өчигдөр гэхэд Улаанбаатар хотын замын хөдөлгөөнд 508 мянган машин хөдөлгөөнд оролцсон байгаа. Тэгээд бид нар ТЭЗҮ-д авахдаа нийт жилийн дунджаар өдөрт дунджаар 580 мянган машин хөдөлгөөнд оролцож байгаа бол түүний 30 хувь нь энэ тойрог зам дээр гарахад өдөрт хязгааргүй удаа гарахад энэ ерөөсөө өдрийн 1 удаа л 5000 төгрөгөөр эргэн төлөлтийг тооцож үзэхэд бид нар 9 аравны хэдэн жилийн дотор эргэн төлөлтөө хийнэ гэсэн ийм агуулгатай байгаа.

Энэ дээр нэмэх нь Туулын зам гэдэг энэ 2 хоорондоо нийлж нөгөө кольца зам болж байгаа. Энэ 2-ын төлбөрийг нэгдсэн байдлаар нийслэл 1 төлбөрийн зарчмаар явна. Туул дээр явсан нь тусдаа, тойрог дээр явсан нь.../минут дуусав./

**Х.Булгантуяа:** Тулга дарга нэмж хариулъя.

**С.Тулга:** Сангийн яам Тулгаа, Санхүүгийн бодлогын газрын дарга. Гишүүний асуултад нэмж хариулъя. Өрийн хязгаар төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасны дагуу ДНБ-ий 60 хувьтай тэнцэх хэмжээгээр байгаа. Энийг номинал дүнгээр илрэх юм бол 54 их наяд төгрөг байгаа. 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр манай өрийн хэмжээ 34.6 их наяд төгрөг байгаа. Энэ баталгааг гаргаснаар бид нар 221.3 сая доллар дээр баталгаа гаргаад ойролцоогоор 770 тэрбум гэж тооцох юм бол өрийн харьцаа маань 39.5 хувиас 40.4 хувь буюу 0.9 хувиар өр маань нэмэгдэнэ гэсэн үг. Тэгэхлээр нөгөө хязгаартай бол байгаа л гэсэн үг.

**Х.Булгантуяа:** Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Одоо Байнгын хорооны гаргасан горимын саналаар санал хураалт явуулна. Гишүүд ирц ямар байна? Тэгье гишүүд санал хураалтад бэлтгэе. Гишүүд танхимдаа орж ирж санал хураалтад бэлтгэе.

Одоо хэлэлцэх асуудлын 4-өөс авхуулаад бүх санал хураалтуудыг нэг дор явуулаад хуулиуд эцэслэн батлахаар байгаад байгаа юм. Засгийн газрын сайд нар танхимдаа орж ирье. Одоо маш олон хуулиуд эцэслэн батлах гэж байна. Ирц өндөр байж байж батлагдахгүй бол болохгүй.

Гишүүд чуулганыхаа танхимд санал хураалт явуулах гэж байна. Ирц бүртгэлийн 1 санал хураалт явуулъя. Санал хураалтад гишүүд бүгдээрээ хуруугаа уншуулаад бэлдээрэй. Ирц бүртгэлийн санал хураалт.

Саяын хэлэлцэж байсан асуудлаарх санал хураалтыг нэгдсэн журмаар дараа нь явуулъя.

Өглөөнөөс хойш бид нар 4 дүгээр асуудлаас хойш санал хураалт явуулаагүй байгаа. Тэгэхээр нөхөөд санал хураалтуудыгаа явуулъя.

14.27 цаг

**Харьяатын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн гишүүд асуулт асууж үг хэлж дууссан байгаа.**

Одоо санал хураалтыг явуулна. Гишүүд санал хураалтад бэлтгэе. Санал хураалт.

1.Байнгын хорооноос Харьяатын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын санал гаргасныг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт.

58.7 хувиар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гаргасан горимын саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Харьяатын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Хууль зүйн байнгын хороонд шилжүүллээ.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл гишүүд асуулт асууж, үг хэлж дууссан байгаа. Санал хураалтад гишүүд бэлтгэе. Энэ чинь яалаа. Энийг холбогдох Байнгын хороонд нь Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн. Түрүүн хэлэлцээд саналгүй. Дараагийн асуудалд оръё.

14.29 цаг

**Хот байгуулалтын тухай хуулийн хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн санал хураалтыг явуулж эхэлье.**

Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, үг хэлж дууссан байгаа. Гишүүд санал хураалтад бэлтгэе. Гишүүд санал хураалтад бэлтгэе.

Байнгын хорооноос Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын саналыг гаргасныг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт.

Гишүүдийн 59.6 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Ингээд Байнгын хорооноос гаргасан горимын саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Эдийн засгийн байнгын хороонд шилжүүллээ. Дараагийн асуудалд оръё.

14.32 цаг

### **Зарим Байнгын хорооны даргыг сонгох тухай.**

Улсын Их Хурлын гишүүд танилцуулгыг сонсож, асуулт асууж дууссан байж байгаа. Санал хураалтад бэлтгэе. Санал хураалт.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны даргаар Ганзоригийн Тэмүүлэнг улируулан сонгохыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт.

Санал 64.4 хувиар дэмжигдлээ.

2.Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны даргаар Бадрахын Найдалааг сонгохыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт. Төхөөрөмж гацчихлаа. Саяын санал хураалтыг хүчингүйд тооцоод ахиж санал хураалт явуулъя. Саяын санал хураалтыг цуцалъя. Тоног төхөөрөмж сая гацчихлаа.

Бүгдээрээ дахиад санал хураалтад зориулаад бэлтгэл хангаад хурууныхаа хээг уншуулъя. Гишүүд бүгдээрээ бэлтгэл хангаарай санал хураалтын.

Алдаржавхлан, Амарсайхан, Амгаланбаатар, Баатархүү, Батбаатар, Батбаяр, Батлут, Батнайрамдал, Батчимэг, Баярмаа, Э.Болормаа, Бямбасүрэн, Ганбаатар, Ганбат, Даваасүрэн, Дамдинням, Дэлгэрсайхан, Жавхлан, Жаргалан, Жаргалсайхан, Заяабал, Идэрбат, Лодойсамбуу, Мандхай, Мөнхтулга, Мөнхтуяа, Наранбаатар, Наранбаяр, Нарантуяа-Нара, Номтойбаяр, Пунсалмаа, Пүрэвдаваа, Пүрэвдорж, Сарнай, Туваан, Ундраа, Ундром, Учрал, Хосбаяр, Цогтбаатар, 2 Цогтбаатар хоёулаа, Цогтгэрэл, Цэнгүүн, Чинбүрэн, Шижир, Энх-Амгалан, Энхтуяа, Эрдэнэболд нарын гишүүд танхимдаа орж ирье. Эс үгүй бол бэлтгэл хангаж хуруугаа уншуулъя.

Санал хураалтыг дахин явуулъя.

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны даргаар Бадрахын найдлыг сонгохыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт.

Гишүүдийн 57.7 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Өргөдлийн байнгын хорооны даргаар Одсүрэнгийн Номинчимэгийг сонгохыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт.

Гишүүдийн 60.6 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Мөн Байнгын хорооны даргаар сонгох саналуудыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Зарим Байнгын хорооны даргыг сонгох тухай”, “Байнгын хорооны даргыг улируулан сонгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталсанд тооцлоо.

Тогтоолын төслийг танилцуулъя. “Байнгын хорооны даргыг улируулан сонгох тухай”.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.6, 25.7 дахь хэсэг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1, 23.2 дахь хэсэг санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

1.Монгол Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Тэмүүлэнг Монгол Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны даргаар улируулан сонгосугай.

Энэ тогтоолыг 2025 оны 7 дугаар сарын 9-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй гэсэн байна.

“Зарим Байнгын хорооны даргыг сонгох тухай” тогтоолын төсөл Монгол Улсын Их Хурлын тухай тогтоол

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.6, 25.7 дахь хэсэг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1, 23.2 дахь хэсэг санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

Монгол Улсын Их Хурлын гишүүн Одсүрэнгийн Номинчимэгийг Монгол Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хорооны даргаар, Монгол Улсын Их Хурлын гишүүн Бадрахын Найдалааг Монгол Улсын Их Хурлын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны даргаар тус тус сонгосугай.

Энэ тогтоолыг 2025 оны 7 дугаар сарын 9-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй гэсэн байна.

Шинээр сонгогдсон, улиран сонгогдож байгаа Байнгын хорооны дарга нартаа ажлын амжилт хүсье.

“Зарим Байнгын хорооны даргыг сонгох тухай, “Байнгын хорооны даргыг улираан сонгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Дараагийн асуудлын санал хураалтыг явуулъя.

14.41 цаг

**“Монгол Улсын Их Хурлын зарим дэд хорооны бүрэлдэхүүний тухай” Улсын Их Хурлын тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Байнгын хорооны танилцуулгыг сонссон байгаа.**

Гишүүд асуулт асууж, үг хэлж дууссан. Одоо санал хураалтыг явуулъя. Гишүүд санал хураалтад бэлтгэе.



Одоо “Монгол Улсын Их Хурлын зарим дэд хорооны бүрэлдэхүүний тухай Улсын Их Хурлын тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалтыг явуулъя.

“Монгол Улсын Их Хурлын зарим дэд хорооны бүрэлдэхүүний тухай Улсын Их Хурлын тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт.

Гишүүдийн 67.3 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Тогтоолын төслийг баталлаа.

Тогтоолын төслийг та бүгдэд уншиж танилцуулъя.

“Монгол Улсын Их Хурлын зарим дэд хорооны бүрэлдэхүүний тухай Улсын Их Хурлын тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь заалт, 27 дугаар зүйлийн 27.3 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

1.“Монгол Улсын Их Хурлын зарим дэд хорооны бүрэлдэхүүний тухай” Монгол Улсын Их Хурлын 2024 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн 16 дугаар тогтоолын 1 дэх заалтад доор дурдсан агуулгатай дараах дэд заалт нэмсүгэй.

1.Агаар, орчны бохирдлын Наранцэцэгийн Алтаншагай, Бат-Өлзийн Бат-Эрдэнэ, Сонгобайгийн Замира, Жаргалсайханы Золжаргал, Нанзадын Наранбаатар, Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан, Салдангийн Одонтуяа, Ухнаагийн Отгонбаяр, Агваанлуvsангийн Ундраа, Жигжидсүрэнгийн Чинбүрэн.

Аялал жуулчлалын хөгжлийн Ринчиндоржийн Батболд, Нацагдоржийн Батсүмбэрэл, Шинэбаярын Бямбасүрэн, Ганзоригийн Лувсанжамц, Эрдэнэбилэгийн Одбаяр, Буяагийн Тулга, Мөнхчулууны Энхцэцэг.

Боловсрол, шинжлэх ухааны.

Цэндийн Баатархүү, Дуламын Бум-Очир, Амгаланбаатарын Ганбаатар, Жанчивын Галбадрах, Сархадын Зулпхар, Цэндсүрэнгийн Мөнхтуяа, Дүгэрийн Рэгдэл, Ганбатын Хосбаяр, Бадарчийн Хэрлэн.

Бүсчилсэн хөгжлийн.

Мягмарсүрэнгийн Бадамсүрэн, Жадамбын Бат-Эрдэнэ, Энхбатын Болормаа, Цагаанхүүгийн Идэрбат, Нямтайширын Номтойбаяр, Бөхчулууны Пүрэвдорж, Цэндийн Сандаг-Очир, Цэвэгдоржийн Туваан, Гончигдоржийн Уянгахишиг.

Ёс зүйн.



Оюунсайханы Алтангэрэл, Аюушийн Ариунзаяа, Баярмагнайн Баярбаатар, Чулуунбилэгийн Лодойсамбуу, Чинбатын Номин, Отгоны Саранчулуун, Бадарчийн Хэрлэн, Өлзийхүүгийн Шижир, Доржзовдын Энхтуяа.

Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийн.

Жуковын Алдаржавхлан, Цэндийн Баатархүү, Мягмарсүрэнгийн Бадамсүрэн, Отгоншарын Батнайрамдал, Пүрэвийн Батчимэг, Жамбалын Ганбаатар, Ренчинбямбын Сэддорж.

Инновац, цахим бодлогын хөгжлийн.

Чинбаатарын Анар, Цэндийн Баатархүү, Ринчиндоржийн Батболд, Жадамбын Бат-Эрдэнэ, Хүрэлбаатарын Булгантуяа, Пүрэвжавын Ганзориг, Батбаярын Жаргалан, Лхагвасүрэнгийн Соронзонболд, Буяагийн Тулга.

Соёл, спорт, залуучуудын.

Шинэбаярын Бямбасүрэн, Даваасамбуугийн Ганмаа, Мөнгөнцогийн Ганхүлэг, Мөнхтөрийн Нарантуяа-Нара, Мягмардашийн Сарнай, Отгоны Саранчулуун, Сүхбаатарын Батчулуун, Сүхбаатарын Эрдэнэбат, Мөнхчулууны Энхцэцэг, Доржзовдын Энхтуяа.

Хүнс, хөдөө аж ахуйн.

Жигжидийн Батжаргал, Пүрэвийн Батчимэг, Дамдинсүрэнгийн Жаргалсайхан, Цагаанхүүгийн Идэрбат, Пүрэвжавын Лүндэг, Мэндбаярын Мандхай, Тогтмолын Мөнхсайхан, Загджавын Мэндсайхан, Цагаахүүгийн Мөнхбат, Баатаржавын Мөнхсоёл, Цэвэгдоржийн Туваан.

2.Улсын Их Хурлын гишүүн Дамбын Батлут, Гонгорын Дамдинням нарыг Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны, Улсын Их Хурлын гишүүн Бат-Өлзийн Бат-Эрдэнэ, Цэндийн Сандаг-Очир, Даваагийн Цогтбаатар нарыг Хүний эрхийн дэд хорооны, Улсын Их Хурлын гишүүн Мягмарсүрэнгийн Бадамсүрэн, Отгоншарын Батнайрамдал, Пүрэвийн Батчимэг, Энхбаярын Батшугар, Батбаярын Жаргалан, Баатаржавын Мөнхсоёл, Лхагвасүрэнгийн Соронзонболд, Мөнхчулууны Энхцэцэг нарыг Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хорооны бүрэлдэхүүнээс тус тус чөлөөлсүгэй.

3.Улсын Их Хурлын гишүүн Жуковын Алдаржавхлан, Чинбатын Номин нарыг Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны, Улсын Их Хурлын гишүүн Оюунсайханы Алтангэрэл, Баярмагнайн Баярбаатар, Жудгийн Баярмаа, Лхагвасүрэнгийн Соронзонболд, Баттөмөрийн Энхбаяр нарыг Хүний эрхийн дэд хорооны, Улсын Их Хурлын гишүүн Батжаргалын Заяабал, Ганзоригийн Лувсанжамц, Бадрахын Найдалаа, Бадамдоржийн Пунсалмаа, Болдын Уянга, Саруулсайханы Цэнгүүн нарыг Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хорооны гишүүнээр баталсугай.

4.“Монгол Улсын Их Хурлын зарим дэд хорооны бүрэлдэхүүний тухай” Монгол Улсын Их Хурлын 2024 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн 16 дугаар

тогтоолын 1 дэх заалтын 1 дэх дэд заалтын дугаарыг 11 гэж 2 дахь дэд заалтын дугаарыг 10 гэж, 3 дахь дэд заалтын дугаарыг 12 гэж, 4 дэх дэд заалтын дугаарыг 9 гэж тус тус өөрчилсүгэй.

Энэ тогтоолыг баталсан өдрөөс өдрөөс эхэлж дагаж мөрдсүгэй гэсэн байна.

Тогтоолын төслийг та бүгдэд уншиж танилцууллаа.

Тогтоолын төслийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Дараагийн асуудлын санал хураалтыг явуулъя.

14.46 цаг

**“Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан Байнгын хорооны танилцуулгыг хийж, гишүүд асуулт асууж дууссан байгаа.**

Улсын Их Хурлын гишүүн Ардчилсан намын бүлгийн дарга Цогтгэрэл дарга горимын санал гаргана.

**О.Цогтгэрэл:** Хэдийгээр өнөөдөр чуулган хаах гэж байгаа цаг хугацаа бас нэлээн шахуу байгаа ч гэсэн энэ асуудал дээр бас үг хэлэхээс өөр аргагүй байна. Өчигдөр яаралтай горимоор орж ирээд өнөөдөр эцэслэн батлагдах гэж байгаа өрийн баталгаа гаргах гэж байгаа, зээл авах гэж байгаа л асуудал ингээд тоо баримтыг, яаралтай горимоор орж ирсэн тоо баримтыг ингээд харахлаар 900 сая доллар, 920 сая доллараар 24км-ийг тойрог зам шинэ тойргийн Туулын хурдны зам биш өөр шинэ тойрог замд 900 бараг 1 тэрбум шахам доллараар тавина гээд. Километр нь хуваахлаар 130, 40-өөд тэрбум төгрөгөөр үндсэндээ тойрог зам барина гэсэн ийм төсөл ингээд ороод ирчихсэн одоо ингээд үндсэндээ 1 тэрбум төгрөгийн, долларын өр нэмэгдэх тухайд бид нар алх цохих гэж байна л даа.

Тэгэхээр нэгдүгээрт нь энэ асуудал маань хэр зэрэг нэгтгэгдсэн, хаана зураг нь хийгдчихсэн, энэний магадлалыг хаана яг яаж хийсэн? Гишүүд ерөөсөө ингээд мэдээлэл байхгүй. Өчигдөр орж ирээд өнөөдөр яг нэгдүгээрт нь алх цохиод бэлэн болчихсон.

Хоёрдугаарт, энэ эдийн засгийн нөхцөл байдал, энэ төсвийн тодотгол бид нар батлах гээд сууж байна. Энэ төсөв өртэй холбоотой асуудал чинь үнэхээр ийм тэрбум тэрбумаар нь яг өнөөдөр бид нар энэ наадмын урд өдөр өр, зээл нэмэгдүүлэх тухай ийм халиг цалгисан шийдвэрүүд гараад байх нөхцөл байдал байгаа юм уу гэдэгт бас эргэлзэж байна.

Тэгэхдээ энэ асуудал дээр ингэж заавал саатуулж наана цаана болохдоо биш яг энэ асуудлыг бас Ардчилсан намын бүлгийн зүгээс 30 минутын завсарлага аваад энэ асуудлыг бид нар тодорхой хэмжээний мэдээлэл авч, гишүүдэд мэдээлэл өгөхгүй бол яг юун дээр кноп дарах гэж байгаагаа ч гишүүд мэдэхгүй. Өчигдөр орж ирээд одоо дарах гэж байна. 1 тэрбум долларын өр гэдэг дээр 20км-

ийг замыг 1км-ийг нь 130, 40, 40 тэрбум төгрөгийг нь ингээд зээл, өрийн асуудал дээр гарын үсэг, энэ кноп дарах гэж байна шүү.

Тэгэхээр Ардчилсан намын бүлэг энэ асуудал дээр маш бага 30 минутын завсарлага аваад, тодорхой нэмэлт мэдээлэл авч тодруулах шаардлагатай байна.

Ийм учраас завсарлага өгөөч гэж хүсэж байна.

**Х.Булгантуяа:** Ардчилсан намын бүлгийн дарга Цогтгэрэл дарга тухайн асуудал дээр 30 минутын завсарлага хүссэн байна. Тэгвэл тухайн асуудлын санал хураалтыг түр хойшлуулаад 30 минутын завсарлага олгоё. Тэгье.

14.49 цаг

**Тэгвэл дараагийн асуудал хуулийн төслүүдийг эцэслэн батлахаар санал хураалтуудыг явуулъя.**

Нийт 22 төсөл байгаа гишүүд тийм. Санал хураалтаа эхлээд явуулчихъя тэгэх үү гишүүд. Тэгье тэгж байж, харин тийм тэгж байж төсвөө батлах болох гээд байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ санал хураалтаа явуулахгүй бол болохгүй байна.

Хуулийн төслүүдийн эцэслэн баталъя батална. Нийтдээ 22 төсөл байгаа.

Дараагийн асуудал Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-27 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд, Харьяатын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батална.

Хуулийн төслүүдийн эцэслэн батлуулах хувилбарыг Байнгын хороодод, Байнгын хороод бэлтгэн гишүүдэд тараасан байгаа. Гишүүд санал хураалтад бэлтгэе.

Улсын Их Хурлын гишүүн Алдаржавхлан, Амарсайхан, Амгаланбаатар, Баатархүү, Батбаатар одоо шууд л зарлая. Батбаатар, Батбаяр, Батболд, Батлут, Батсуурь, Батчимэг ирцдээ ороогүй байна шүү. Хуруугаа уншихад бэлтгэл хангаагүй байна. Баярмаа, Болормаа, Х.Болормаа, Бямбасүрэн, Ганбат, Даваасүрэн, Дамдинням, Жавхлан, Жаргалсайхан, Лодойсамбуу, Мөнхбат, Мөнхтуяа, Наранбаатар, Наранбаяр, Нарантуяа-Нара, Номтойбаяр, Одбаяр, Одонтуяа, Очирбат, Пунсалмаа, Пүрэвдаваа, Пүрэвдорж, Туваан, Ундраа, Уянгахишиг, Цогтбаатар, Д.Цогтбаатар, Цэнгүүн, Чинбүрэн. Шижир. Энх-Амгалан, Энхнасан, Эрдэнэболд гишүүд хуруугаа уншуулж, бэлтгэлээ хангая. Зарим нь танхимд орж ирээгүй байна. Орж ирж санал хураалтад оръё. Энэ хууль эцэслэн батлах учраас маш өндөр ирцтэйгээр эцэслэн батлагдана.

Эхнийх нь бүртгэлийн санал хураалт явуулъя. Бүртгэлийн санал хураалт хураалтдаа оръё.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44.2-т нэгдсэн хуралдаанд хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулах бөгөөд Улсын Их Хурлын нийт гишүүний олонх дэмжсэн бол хууль эцэслэн баталсанд тооцно гэж заасан.

1. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-27 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Гишүүдийн 73 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Аж ахуйн нэгжийн орлогын албан албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт явуулъя.

29 гишүүн дэмжиж, санал дэмжигдсэнгүй.

2. Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Нийт 64 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

3. “Алт-3 аяныг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт.

Гишүүдийн 51 хувь нь дэмжсэн. Энэ тогтоол учраас ердийнхөөр байж болно. 51 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ. Тэгэхээр тогтоолын төслийг 51 хувь нь дэмжиж, тогтоолын төсөл батлагдсан гэсэн үг.

Түрүүний Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль санал хуульд дэмжигдээгүй. Үүнтэй холбоотойгоор хуулийн төсөл буцаах тухай тогтоолыг танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.4 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 6 дугаар сарын 25-ны өдөр Монгол Улсын Их Хуралд Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах саналыг Улсын Их Хурлын нийт гишүүний олонх дэмжээгүй тул хууль санаачлагчид нь буцаасугай гэсэн байна.

Харьяатын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

68 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

67 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт.

72 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт.

67 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт.

73 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

70 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт.

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт.

Баярбаатар гишүүн.

**Б.Баярбаатар:** Дарга санал хураалтаасаа хоцорчихлоо уучлал хүсье. Тэгээд горимын санал хураалтыг хүчингүй болгож өгнө үү гэсэн горимын санал гаргаж байна.

**Х.Булгантуяа:** Баярбаатар гишүүний горимын саналаар санал хураалт явуулъя. Саяын санал хураалтыг хүчингүй болгох горимын санал санал хураалт.

64.4 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Санал хураалтыг дахин явуулъя. Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт.

71 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн Банкны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

70 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

Агаарын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт.

69 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

Усны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт.

72 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт.

71 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

Автотээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт.

69 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт.

70 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

Жолоочийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт.

70 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт.

71 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт.

71 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт.

Дараагийн асуудалд орохоос өмнө, 71 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

Дараагийн асуудалд орохоос өмнө түрүүн Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга Цогтгэрэл даргын гаргасан горимын саналын дагуу 30 минутын завсарлага яваад дараагийн асуудал оръё тэгэх үү Цогтгэрэл дарга.

15:06 цаг

### ***Лхагва гараг 09 Долоодугаар сар 2025***

### ***Төрийн ордон “Их хуралдай” танхим 17 цаг 06 минут***

**Х.Булгантуяа:** Улсын Их Хурлын гишүүд чуулганыхаа танхимд цуглая.

Байнгын хороод хуралдсан Дэд хорооны дарга сонгох асуудлууд хэлэлцэгдэж дууссан байж байгаа.

**Мөн Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс “Засгийн газрын өрийн баталгаа гаргах, зөвшөөрөл олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл дээр завсарлага авсан байж байгаа.**

Энэ асуудлаар Цогтгэрэл Ардчилсан намын бүлгийн дарга Цогтгэрэл дарга. Цогтгэрэл даргын микрофоныг өгье.

**О.Цогтгэрэл:** Сая бид нар завсарлага аваад тодорхой мэдээллүүд авсан. Нямбаатар даргыг бас оруулж ирж асуулт, хариулт явагдсан. Ер нь энэ асуудлыг бас яагаад онцолж, онцгойлон ярих шаардлагатай болсон гэхээр ер нь яаралтай горимоор орж ирж байгаа асуудал гэдэг чинь онцгой нөхцөл байдал үүссэн онц шаардлагатай үед бас яаралтай горимоор орж ирэх ийм дэгтэй.

Тэгэхээр энэ асуудал маань үнэхээр энэ нийслэлийн хурдны замын асуудал, тойрог замын асуудал үнэхээр тийм цаг үеийн үед гэнэт үүссэн нөхцөл байдал юм уу гэдэг дээр бас гишүүдийн зүгээс бас яагаад яг энэ наадмын өмнөх өдөр ингэж орж ирж байгаа юм бэ гэдэг дээр тодорхой хэмжээний дургүйцэл болоод энэ ажил хэргийн энэ төлөвлөгөө хаана байгаа юм бэ гэдэг дээр бас асуудлууд яригдаж байсныг бас дурдъя.

Тэгээд ер нь энэ тойрог замын асуудал, ер нь аливаа төсөл дээр 2, 3 бас энэ 2, 3 үндсэн шалгуурууд бас байна шүү дээ. Ер нь ер нь энэ ажил хэрэгтэй ажил уу, зөв ажил уу гэдэг.



Хоёрдугаарт нь хэрвээ зөв ажил юм бол энэ ажилд эдийн засгийн үр ашиг, үр өгөөжтэй юү гэдэг асуултад бид нар бас хариулах ёстой.

Гуравдугаарт нь энэ ажлыг хийх яг цаг хугацаа нь өнөөдөр мөн үү гэдэгт бид нар бас энэ асуултад бас заавал хариулсан байх ёстой. Тэгэхлээр ер нь нийслэл Улаанбаатар хотын түгжрэлийг бууруулах, Монгол Улсын хүн амын тал нь энд байгаа, Улаанбаатар хотод байгаа энэ иргэдийн ахуй амьдрал, бизнес, стресс энэ олон зүйлийг харахад энэ түгжрэлийг бууруулах ажлыг зөв, шаардлагатайн хувьд бол шаардлагатай. Энийг бид нар аль нь ч үгүйсгэхгүй байгаа.

Хамгийн гол нь эдийн засгийн үр өгөөж гэдэг зүйлийг бид нар заавал үзэхгүй бол зөв ажлыг ямар ч өртгөөр хамаагүй, ямар ч өр үүсгэж ч хамаагүй хийе гэдэг үндэслэл логик бас байж болохгүй. Тэгэхээр энэ дээр бол нэлээд олон асуултууд гарч, тодруулах зүйлс гарч байсан.

Жишээ нь, төслийн танилцуулгад жилд 320 тэрбум төгрөгийн төлбөртэй зам байна. Төлбөрөөс иргэд өдөртөө тэрбум төгрөгийг нь жилд 320 орчим тэрбум төгрөгийн орлого олох өгөөжтэй төсөл гэж байгаа юм. Үнэхээр ийм өгөөжтэй төсөл юм бол энийг өр, зээл тавьж биш бараг үнэхээр тэр ашигтай бизнесүүд нь хийчихээр л харагдаж байгаа юм. Гэтэл энийг өр тавина гэдэг. Тэгээд танилцуулга нь үндсэндээ зөв юм уу, буруу юм уу, хүмүүст зөв мэдээлэл өгч байгаа танилцуулга уу, буруу мэдээлэл өгч байгаа зорилготой танилцуулга уу гээд олон олон зүйлүүдийг ярьж болно.

Дахиад дээрээс нь цаг хугацааны хувьд энэ төсөл яг явах шаардлагатай. Зөв төсөл байж болж, хэрэг хэрэгцээ шаардлага байгаа. Цаг хугацааны хувьд өнөөдөр төсвийн төсвийн тодотгол, тодотгол нь өөрөө хэмнэлтийн төсөв ярьж байхад энэ төсөл өнөөдөр цагаа олсон уу гэдэг. Тэр тусмаа хэмнэлт ярьж байгаа үедээ ч гэсэн Засгийн газраас тодорхой хэмжээний бас мөчлөг сөрсөн бодлого явуулж, ажлын байр бий болгох, иргэдийн орлогыг дэмжих бодлогууд бас байдаг. Яг энэ төсөл хэрэгжсэнээр өнөөдөр эдийн засагт ажлын байр бий бий болох юм уу? Дотоодын эдийн засагт энд хэчнээн энэ өр, зээлээр авч байгаа мөнгөнөөс хэчнээн хувь нь дотоодын иргэд, бизнесийг дэмжиж үлдэх юм гэхээр яг энэ бол үндсэндээ тендер зарлагдана, Монгол компани ажиллаж чадахгүй, Хятадын компани орж ирж төслийг авна. Яг энэ мөчлөг сөрсөн өнөөдрийн энэ хэмнэлтийн горимд байгаа үед зөв үү, үгүй юу гэдэг дээр бас энэ дээр нягталж бас бид нар хариулах ийм шаардлагатай.

Тэгэхээр гэх зэрэг олон олон ийм нөхцөл байдлууд бас байна. Тэгэхдээ Ардчилсан намын бүлгийн зүгээс гишүүд бас хангалттай мэдээлэл бас байхгүй байгаа учраас гишүүд бид нар энэ дээр нэгдсэн байр суурь бас гаргаагүй. Гишүүд өөр өөрсдийн итгэл үнэмшлээр, өөр өөрсдийн байр суурь, өөр өөрсдийн тооцоо, судалгаан дээрээс асуудалд асуудалд хандъя.

Ер нь нөхцөл байдал бол өөрөө хэт яаралтай горимоор орж ирсэн, бас ингээд дутуу дулимаг мэдээлэлтэй ийм төсөл байна. Хэрэгтэй, шаардлагатай гэдгийн тухайд бол бид нар энэ дээр энийг хэрэгт маргалдаж байгаа хэн нэгэн гишүүн байхгүй байгаа гэдгийг хэлье. Тэгээд Ардчилсан намын бүлэг завсарлагаа дахин ингээд үргэлжлүүлэхгүй. Гишүүд өөр өөрсдийнх нь итгэл үнэмшил байр сууриас асуудалд хандаж оролцоно.



**Х.Булгантуяа:** Ардчилсан намаас завсарлага авсан байсан. Завсарлагын хугацаа дууссан. Сая Цогтгэрэл дарга сая танилцууллаа. Дараагийн асуудалд ороод шууд нэгдсэн санал хураалтыг явуулъя.

17.11 цаг

Хуулийн эцэслэн батлах асуудлууд бүгдээрээ санал хураалтууд явагдаад 22-ын асуудал дээр дууссан байж байгаа. Засгийн газрын сайд нар орж ирье. Засгийн газрын сайд нар.

**Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд дөрөв дэх хэлэлцүүлгийг явуулъя.**

Төсвийн байнгын хороо төсвийн төслүүдийг дөрөв дэх хэлэлцүүлэгт бэлтгэн гишүүдэд тараасан байгаа. Гишүүд санал хураалтад бэлтгэе. Гишүүд санал хураалт. Энэ ямар гишүүд санал хураалтад бэлтгэе. Одоогоор 63 гишүүн санал хураалтад бэлэн байна. Улсын Их Хурлын гишүүн Алдаржавхлан, Алтаншагай, Амгаланбаатар, Бадамсүрэн, Батбаатар, Батнайрамдал Батчимэг, Бат-Эрдэнэ, А.Ганбаатар, Г.Ганбаатар, Гантөмөр, Даваасүрэн, Дамдинням, Дэлгэрсайхан, Жавхлан, Заяабал, Золжаргал, Лодойсамбуу, Мандхай, Мөнхбат, Мөнхсайхан, Мөнхтуяа, Наранбаатар, Номин, Номтойбаяр, Одбаяр, Отгонбаяр, Пунсалмаа, Пүрэвдаваа, Сайнзориг, Саранчулуун, Сарнай, Тулга, Ундраа, Ундрэм, Уянгахишиг, Цогтбаатар, Цэнгүүн, Чинбүрэн, Энх-Амгалан, Эрдэнэбат, Эрдэнэболд нарын гишүүд чуулганы танхимдаа яаралтай ирж санал хураалтдаа бэлтгэнэ үү. Санал хураалт явагдах гэж байна.

Хамгийн эхлээд хэдүүлээ ирцийн санал хураалт явуулъя. Ирцийн санал хураалт.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зүйл, заалт бүрийг уншин сонсгож, зүйл тус бүрээр санал хураалт явуулна.

Та бүгдэд уншиж танилцуулъя.

### **Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай**

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн дараах зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**1/3 дугаар зүйл:**

**“3 дугаар зүйл.** Монгол Улсын төсөвт 2025 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа болон бусад байгууллага доор дурдсан хэмжээтэй орлогыг төвлөрүүлнэ:

**Төсвийн Ерөнхийлөн захирагч.**

**Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга**, Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого 185 тэрбум.

**Монгол Улсын Их Хурлын дарга**, Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого 100 тэрбум.

**Монгол Улсын Ерөнхий сайд**, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар,

**Монгол Улсын Ерөнхий сайд** 105 тэрбум 149 сая, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар 101 тэрбум 600 сая, Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого 3 тэрбум 549 сая.

**Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга** 510 тэрбум, Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого 510 тэрбум.

**Монгол Улсын Ерөнхий аудитор** 831.3 тэрбум, Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого 831.3 тэрбум.

**Төрийн албаны зөвлөлийн дарга** 200 тэрбум, Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого 200 тэрбум,

**Санхүүгийн зохицуулах хорооны дарга** 4 их наяд. Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого 4 их наяд.

**Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд** 2 их наяд 388.3 тэрбум, Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого 2 их наяд 388.3 тэрбум.

**Монгол Улсын Шадар сайд** 21-н, 2 их наяд 388.3 тэрбум, Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого 2 их наяд 388.3 тэрбум.

Тийм байна. Би дүнг нь бүүр арай дэндүү ихээр уншихсан байна шүү.

**Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга** 185 сая юм байна. Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого 185 сая.

**Монгол Улсын Их Хурлын дарга** 100 сая, Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого 100 сая.

**Монгол Улсын Ерөнхий сайд** 105 тэрбум 149 сая, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар 101 тэрбум 600 сая, Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого 3 тэрбум 549 сая.

**Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга** 510 сая, Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого 510 сая.

**Монгол Улсын Ерөнхий аудитор** 531.3 сая, Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого 831.3 сая.

**Төрийн албаны зөвлөлийн дарга** 200 сая, Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого 200 сая.

**Санхүүгийн зохицуулах хорооны дарга** 4 тэрбум, Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого 4 тэрбум.

**Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд** 2 тэрбум 388.3 сая, Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого 2 тэрбум 388.3 сая.

**Монгол Улсын Шадар сайд** 21 тэрбум 289.1 сая, Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого 21 тэрбум 289.1 сая.

**Монгол Улсын Шадар сайд** 115.9 сая, Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого 115.9 сая.

**Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга** 300 сая, Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого 300 сая.

**Гадаад харилцааны сайд** 9 тэрбум 100 сая, Дипломат төлөөлөгчийн газрууд 6 тэрбум, Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого 3 тэрбум 100 сая.

**Сангийн сайд** 18 их наяд 370 тэрбум 131.2 сая, Татварын ерөнхий газар 9 их наяд 918 тэрбум 444.7 сая. Үүнээс Тогтворжуулалтын санд 429 тэрбум 107.7 сая.

**Гаалийн ерөнхий газар** 7 их наяд 777 тэрбум 815.8 сая, Сангийн яам 247 тэрбум 508.1 сая, Гадаад тусламжийн орлогоос санхүүжих 417 тэрбум, Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого 9 тэрбум 362.6 сая.

**Хууль зүй, дотоод хэргийн сайд** 81 тэрбум 138.8 сая, Улсын бүртгэлийн ерөнхий газар 45 тэрбум 730 сая, Цагдаагийн ерөнхий газар 2 тэрбум 370 сая. Шүүх шинжилгээний ерөнхий газар 300 сая, Эрүүл мэндийн даатгалын сангаас улсын эмнэлэгт олгох санхүүжилтийн орлого 1 их наяд 52 аравны. 1 тэрбум 52.5 тэрбум, Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого 31 тэрбум 686.4 сая.

**Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд** 314 тэрбум 636.5 сая, Ашигт малтмал, газрын тосны газар 309 тэрбум 89 сая 600, Үндэсний геологийн алба 120 сая, Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого 5 тэрбум 427 сая.

**Батлан хамгааллын сайд** 43 тэрбум 187.2 сая, Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого 43 тэрбум 187.2 сая.

**Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд** Харьяа төсөвт байгууллагын өөрийн, **Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд** 2 тэрбум 162.8 сая, Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого 2 тэрбум 162.8 сая.

**Боловсролын сайд** 6 тэрбум 534.8 сая Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого 6 тэрбум 534.8 сая.

**Соёл, спорт, аялал жуулчлал, спортын сайд** 304 тэрбум, Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого 304 тэрбум.

**Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд** 68 тэрбум 277.7 сая, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар 1 тэрбум 500 сая, Эрүүл мэндийн даатгалын сангаас улсын эмнэлэгт олгох санхүүжилтийн орлого 3 тэрбум 35.1 сая, Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого 63 тэрбум 742.6 сая.

**Зам, тээврийн сайд** 110 тэрбум 656 сая, Иргэний нисэхийн ерөнхий газар 80 тэрбум, Зам, тээврийн яам 300 сая, Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого 30 тэрбум 356 сая.

**Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд** 48 тэрбум 857.6 сая, Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого 48 тэрбум 857.6 сая.

**Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд** 8 тэрбум 663.3 сая, Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого 8 тэрбум 663.3 сая.

**Эрүүл мэндийн сайд** 7 тэрбум 894.6 сая, Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого 7 тэрбум 894.6 сая.

2 штрих 6 дугаар зүйл.

**6 дугаар зүйл.**Монгол Улсын төсвөөс 2025 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч доор дурдсан хэмжээтэй төсвийг зарцуулна:

6.1.1.Монгол Улсын төсвөөс 2025 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчийн зарцуулах зардал доор дурдсан хэмжээтэй байна:

**Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга** 33 тэрбум 997.2 сая, Урсгал зардал 33 тэрбум 303.1 сая, Хөрөнгийн зардал 694.1 сая.

**Монгол Улсын Их Хурлын дарга** 192 тэрбум 20 сая 500, Урсгал зардал 153 тэрбум 460.5 сая, Хөрөнгийн зардал 8 тэрбум 560 сая.

**Монгол Улсын Ерөнхий сайд** 380 тэрбум 915.6 сая, Урсгал зардал 335 тэрбум 421.5 сая, Хөрөнгийн зардал 45 тэрбум 494.1 сая.

**Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дарга** 5 тэрбум 54.6 сая, Урсгал зардал 5 тэрбум 54.6 сая.

**Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч** 29 тэрбум 808.7 сая, Урсгал зардал 25 тэрбум 719 сая, Хөрөнгийн зардал 4 тэрбум 89.7 сая.

**Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга** 276 тэрбум 306.5 сая, Урсгал зардал 223 тэрбум 557.9 сая, Хөрөнгийн зардал 52 тэрбум 748.6 сая,

**Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга** 13 тэрбум 118.4 сая, Урсгал зардал 10 тэрбум 916.8 сая, Хөрөнгийн зардал 2 тэрбум 271.6 сая.

**Улсын ерөнхий прокурор** 145 тэрбум 718.4 сая, Урсгал зардал 115 тэрбум 880.1 сая, Хөрөнгийн зардал 29 тэрбум 838.3 сая.

**Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга** 21 тэрбум 821.6 сая, Урсгал зардал 21 тэрбум 821.6 сая.

**Монгол Улсын Ерөнхий аудитор** 48 тэрбум 415.9 сая, Урсгал зардал 48 тэрбум 415.9 сая.

**Авлигатай тэмцэх газрын дарга** 54 тэрбум 995.8 сая, Урсгал зардал 52 тэрбум 710.7 сая, Хөрөнгийн зардал 2 тэрбум 285.1 сая.

**Санхүүгийн зохицуулах хорооны дарга** 20 тэрбум 920.5 сая, Урсгал зардал 20 тэрбум 677.1 сая, Хөрөнгийн зардал 243.4 сая.

**Төрийн албаны зөвлөлийн дарга** 15 тэрбум 125.1 сая, Урсгал зардал 15 тэрбум 125.1 сая.

**Үндэсний статистикийн хорооны дарга** 29 тэрбум 907.1 сая, Урсгал зардал 28 тэрбум 102.9 сая, Хөрөнгийн зардал 1 тэрбум 804.2 сая.

**Сонгуулийн ерөнхий хорооны дарга** 14 тэрбум 808.2 сая, Урсгал зардал 14 тэрбум 808.2 сая.

**Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын дарга** 1 тэрбум 225.8 сая, Урсгал зардал 1 тэрбум 225.8 сая.

**Шүүхийн сахилгын хорооны дарга** 5 тэрбум 749.8 сая, Урсгал зардал 5 тэрбум 449.8 сая, Хөрөнгийн зардал 300 сая.

**Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд** 259 тэрбум 487.2 сая, Урсгал зардал 112 тэрбум 972.1 сая, Хөрөнгийн зардал 146 тэрбум 515.1 сая.

**Монгол Улсын Шадар сайд** 356 тэрбум 59.1 сая, Урсгал зардал 297 тэрбум 789.5 сая, Хөрөнгийн зардал 58 тэрбум 269.6 сая.

**Монгол Улсын Шадар сайд** 6 тэрбум 267.4 сая, Урсгал зардал 6 тэрбум 267.4 сая.

**Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга** 96 тэрбум 274.6, Урсгал зардал 73 тэрбум 107.6 сая, Хөрөнгийн зардал 23 тэрбум 167 сая.

**Гадаад харилцааны сайд** 261 тэрбум 179.4 сая, Урсгал зардал 251 тэрбум 609.8 сая, Хөрөнгийн зардал 9 тэрбум 569.6 сая.

**Сангийн сайд** 4 их наяд 521 тэрбум 557 сая, Урсгал зардал үүнээс урсгал зардал 2 их наяд 434 тэрбум 408.5 сая, Үүнээс зээлийн хүүгийн төлбөрт 1 их наяд 262 тэрбум 936.5 сая, Хөрөнгийн зардал 127 тэрбум 720.2 сая, Гадаад зээл, тусламжаас санхүүжүүлэх зардал 1 их наяд 959 тэрбум 428.4 сая.

**Хууль зүй, дотоод хэргийн сайд** 1 их наяд 624 тэрбум 375.3 сая, Урсгал зардал 1 их наяд 519 тэрбум 654.6 сая, Хөрөнгийн зардал 104 тэрбум 720.7 сая.

**Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд** 46 тэрбум 858.5 сая, Урсгал зардал 26 тэрбум 79 сая, Хөрөнгийн зардал 20 тэрбум 779.5 сая.

**Батлан хамгаалахын сайд** 784 тэрбум 565.5 сая, Урсгал зардал 718 тэрбум 761.6 сая, Хөрөнгийн зардал 65 тэрбум 803.9 сая.

**Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд** 260 тэрбум 905 сая, Урсгал зардал 191 тэрбум 402.5 сая, Хөрөнгийн зардал 69 тэрбум 502.5 сая.

**Боловсролын сайд** 4 их наяд 265 тэрбум 566.3 сая, Урсгал зардал 3 их наяд 819 тэрбум 213.4 сая, Хөрөнгийн зардал 446 тэрбум 352.9 сая.

**Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд** 4 их наяд 453 тэрбум 662.9 сая, Урсгал зардал 4 их наяд 404 тэрбум 934.8 сая, Хөрөнгийн зардал 48 тэрбум 728.1 сая.

**Зам, тээврийн сайд** 1 их наяд 13 тэрбум 502 сая, Урсгал зардал 22 тэрбум 630.8 сая, Хөрөнгийн зардал 990 тэрбум 871.2 сая.

**Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд** 440 тэрбум 866.4 сая, Урсгал зардал 315 тэрбум 301.9 сая, Хөрөнгийн зардал 125 тэрбум 564.5 сая.

**Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд** 406 тэрбум 461.4 сая, Урсгал зардал 71 тэрбум 689 сая, Хөрөнгийн зардал 334 тэрбум 772.4 сая,

**Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд** 675 тэрбум 114.7 сая, Урсгал зардал 618 тэрбум 830.5 сая, Хөрөнгийн зардал 56 тэрбум 284.2 сая.

**Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд** 81 тэрбум 974.2 сая, Урсгал зардал 58 тэрбум 611.4 сая, Хөрөнгийн зардал 23 тэрбум 362.8 сая.

**Эрчим хүчний сайд** 365 тэрбум 420.7 сая, Урсгал зардал 135 тэрбум 998.8 сая, Хөрөнгийн зардал 229 тэрбум 421.9 сая.

**Эрүүл мэндийн сайд** 1 их наяд 719 тэрбум 834.7 сая, Урсгал зардал 1 их наяд 573 тэрбум 927.5 сая, Хөрөнгийн зардал 145 тэрбум 907.2 сая.

6.2.Монгол Улсын төсвөөс 2025 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчид эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр доор дурдсан хэмжээтэй санхүүжилтийг олгоно:

**Сангийн сайд** 41 тэрбум 165.2 сая.

**Боловсролын сайд** 27 тэрбум 932.7 сая.

**Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд** 49 тэрбум 831.9 сая.

**Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд** 4 тэрбум 500 сая.

**Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд** 40 тэрбум 985.7 сая.

3 штрих 15.17 дугаар зүйл. 15-аас 17 дугаар зүйл.

**15 дугаар зүйл.** 2025 оны төсвийн жилд орон нутгийн төсөвт доор дурдсан хэмжээтэй санхүүгийн дэмжлэгийг олгоно:

Архангай аймаг 33 тэрбум 894.6 сая.

Баян-Өлгий 19 тэрбум 361.5 сая.

Баянхонгор 28 тэрбум 978.9 сая.

Говь-Алтай 19 тэрбум 659.6 сая.

Завхан 35 тэрбум 900.6 сая.

Өвөрхангай 21 тэрбум 883.1 сая.

Сүхбаатар 9 тэрбум 349.9 сая.

Увс 28 тэрбум 342.1 сая.

Ховд аймаг 4 тэрбум 875.8 сая.

Хөвсгөл 38 тэрбум 599.9 сая.

Хэнтий 27 тэрбум 307.8 сая.

Говьсүмбэр 5 тэрбум 119.7 сая.

**Нийт** 273 тэрбум 270.7 сая.

**16 дугаар зүйл.** 2025 оны төсвийн жилд орон нутгийн төсвөөс улсын төсөвт доор дурдсан хэмжээтэй орлогыг төвлөрүүлнэ:

Булган аймаг 473.4 сая.

Дорноговь 10 тэрбум 754.9 сая.

Дорнод 3 тэрбум 42.3 сая.

Дундговь 1 тэрбум 278.7 сая.



Өмнөговь 1 их наяд 530 тэрбум 918.5 сая.

Сэлэнгэ 8 тэрбум 665.2 сая.

Төв аймаг 2 тэрбум 370 сая.

Дархан-Уул 6 тэрбум 780.2 сая.

Улаанбаатар 130 тэрбум 762.8 сая.

Орхон 108 тэрбум 420.3 сая.

**Нийт дүн** 1 их наяд 803 тэрбум 467.2 сая.

**17 дугаар зүйл.** 2025 оны төсвийн жилд Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон улсын төсвөөс Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг доор дурдсан хэмжээтэй байна:

Архангай 9 тэрбум 698.4 сая.

Баян-Өлгий 9 тэрбум 395.6 сая.

Баянхонгор 18 тэрбум 124.8 сая.

Булган 11 тэрбум 79.8 сая.

Говь-Алтай 18 тэрбум 303.7 сая.

Дорноговь 33 тэрбум 362.2 сая.

Дорнод 22 тэрбум 933.7 сая.

Дундговь 13 тэрбум 39.8 сая.

Завхан 12 тэрбум 419.4 сая.

Өвөрхангай 12 тэрбум 182.2 сая.

Өмнөговь 43 тэрбум 789.7 сая.

Сүхбаатар 19 тэрбум 709.5 сая.

Сэлэнгэ 23 тэрбум 59.6 сая.

Төв аймаг 24 тэрбум 987.5 сая.

Увс 10 тэрбум 770.9 сая.

Ховд 18 тэрбум 10.8 сая,.



Хөвсгөл 14 тэрбум 457.7 сая.

Хэнтий 16 тэрбум 234.2 сая.

Дархан-Уул 13 тэрбум 203.6 сая.

Улаанбаатар 39 тэрбум 536.7 сая.

Орхон 26 тэрбум 251.7 сая.

Говьсүмбэр 5 тэрбум 829.7 сая.

**Нийт дүн** 416 тэрбум 377.6

Сая ганц, хоёр тоог залруулан уншъя.

**Монгол Улсын Ерөнхий аудитор** 800, төвлөрүүлэх орлого дээр Монгол Улсын Ерөнхий аудитор 831.3 сая, Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого 831.3 сая.

**Соёл, спорт, аялал жуулчлалын сайд** 304 тэрбум, Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого 304 тэрбум.

**Соёл, спорт, аялал жуулчлалын сайд** 304 сая, Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого 304 сая.

**Хүний эрхийн Үндэсний Комисс** 13 тэрбум 188.4 сая.

**Сангийн сайд** Урсгал зардал үүнээс зээлийн хүүгийн төлбөрт 1 их наяд 292 тэрбум 936.5 сая.

**16 дугаар зүйл.** 25 оны төсвийн жилд орон нутгийн төсвөөс улсын төсөвт орж дурдсан хэмжээтэй орлогыг төвлөрүүлнэ:

Дархан-Уул аймаг 6 тэрбум 781.2 сая.

Ингээд болсон тээ? Гишүүд санал хураалт. Эхлээд 1 бүртгэлийн санал явуулаадахъя. Гишүүд бүгд байраа эзлээрэй. Санал хураалтад бэлтгэе. Эхлээд бүртгэлийн санал хураалт явуулаад тэгээд санал хураалтыг дахиж явуулъя. Гишүүд бүртгэлийн санал хураалт.

**Д.Амарбаясгалан:** Санал хураалт.

81 гишүүн буюу 77.1 хувиар санал дэмжигдлээ.

**2 дугаар зүйл.** Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний

үзүүлэлт”-ийг энэ хуулийн 1 дүгээр хавсралтаар өөрчлөн найруулсугай. Санал хураалт.

84 гишүүн буюу 80 хувиар санал дэмжигдлээ.

**3 дугаар зүйл.**Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар баталсан “Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2025 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт”-ыг энэ хуулийн 2 дугаар хавсралтаар өөрчлөн найруулсугай. Санал хураалт.

85 гишүүн буюу 81 хувиар санал дэмжигдлээ.

**4 дүгээр зүйл.**Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн “22,837,920.9” гэснийг “19,794,972.6” гэж, 7 дугаар зүйлийн “24,209,847.5” гэснийг “22,564,282.9” гэж, 8 дугаар зүйлийн “3,124,066.0” гэснийг “2,914,938.2” гэж, 10 дугаар зүйлийн “608,888.9” гэснийг “429,107.7” гэж, 12 дугаар зүйлийн “1,669,739.8” гэснийг “1,701,789.2” гэж тус тус өөрчилсүгэй. Санал хураалт.

85 гишүүн буюу 81 хувиар санал дэмжигдлээ.

**5 дугаар зүйл.**Энэ хуулийг баталсан эхлэн дагаж мөрдөнө. Санал хураалт.

83 гишүүн буюу 79 хувиар санал дэмжигдлээ.

Хуулиа, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зүйл, заалт бүрийг уншиж сонсгож, зүйл тус бүрээр нь санал хураалт явуулсан.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг бүхэлд нь эцэслэн батлах санал хураалт явуулна. Санал хураалт.

86 гишүүн буюу 81.9 хувиар санал дэмжигдлээ.

Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зүйл, заалт бүрийг уншиж сонсгож, зүйл тус бүрээр нь санал хураалт явуулна.

### **Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай**

**1 дүгээр зүйл.**Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**“3 дугаар зүйл.**Үндэсний баялгийн санд 2025 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч доор дурдсан хэмжээтэй орлогыг төвлөрүүлнэ:

**Төсвийн ерөнхийлөн захирагч,**

**Монгол Улсын Ерөнхий сайд** 507 тэрбум 114.8 сая, Үүн дотроо Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар 507 тэрбум 114.8 сая, Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 11.1.2-т заасан уул уурхайн олборлолт, ашигт малтмалын боловсруулах салбарын төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд дэх төрийн эзэмших хувьцааны ноогдол ашиг 507 тэрбум 114.8 сая. Үүнээс Хуримтлалын санд 507 тэрбум 114.8 сая.

**Сангийн сайд** 1 их наяд 394 тэрбум 66.4 сая, Татварын ерөнхий газар 1 их наяд 255 тэрбум 963.6 сая. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 11.1.1.а-д заасан ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс Төсвийн тогтворжуулалтын сан болон Орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд хуваарилаад үлдэх хэсгээс 40 хувь, 1 их наяд 255 тэрбум 963.6 сая. Үүнээс Ирээдүй өв санд 1 их наяд 255 тэрбум 963.6 сая, Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 11.1.1.б-д заасан Ирээдүй өв сангийн хөрөнгө оруулалтын орлого 138 тэрбум 102.8 сая. Үүнээс ирээдүй өв санд 138 тэрбум 102.8 сая.

**Нийт орлого** 1 их наяд 901 тэрбум 181.2 сая.

Санал хураалт.

82 гишүүн буюу 78.1 хувиар санал дэмжигдлээ.

**2 дугаар зүйл.** Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн “1,849,712.5” гэснийг “1,394,066.4” гэж өөрчилсүгэй. Санал хураалт.

84 гишүүн буюу 80 хувиар санал дэмжигдлээ.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө. Санал хураалт.

77 гишүүн буюу 73.3 хувиар санал дэмжигдлээ.

Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг бүхэлд нь эцэслэн батлах санал хураалт явуулна. Санал хураалт.

83 гишүүн буюу 79 хувиар санал дэмжигдлээ.

Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зүйл, заалт бүрийг уншиж сонсгож, зүйл тус бүрээр нь санал хураалт явуулна.

### **Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай**

**1 дүгээр зүйл.** Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн дараах зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**1/3 дугаар зүйл:**

**“3 дугаар зүйл.**Нийгмийн даатгалын санд 2025 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч доор дурдсан хэмжээтэй орлогыг төвлөрүүлнэ:

**Орлогын төрөл.**

**Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд** 6 их наяд 908 тэрбум 73.9 сая.

1.1.Ажил олгогчийн төлөх шимтгэл 2 их наяд 823 тэрбум 802 сая. Ажиллагчдаас төлөх шимтгэл 2 их наяд 277 тэрбум 507.1 сая.

1.3.Эхийн хүүхэд асрах чөлөөтэй хугацааны шимтгэл 14 тэрбум 543.1 сая.

Цаатан иргэдийн нийгмийн даатгалын шимтгэл 146.6 сая.

Сайн дурын даатгуулагчаас төлөх шимтгэл 294 тэрбум 322 сая.

Гадаадад хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа иргэдийн төлөх шимтгэл 6 тэрбум 158.8 сая.

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон даатгуулагчийн төлөх шимтгэл 2 тэрбум 353.8 сая.

Бусад орлого 36 тэрбум 740.6 сая.

Төр хариуцах иргэдийн тэтгэвэр болон шимтгэлийн хөнгөлөлтийн татаас 1 их наяд 452 тэрбум 499.9 сая.

**Нийт орлого** 6 их наяд 908 тэрбум 73.9 сая.

**2/5 дугаар зүйл:**

**5 дугаар зүйл.**2025 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч доор дурдсан хэмжээтэй төсвийг зарцуулна:

**Зарлагын төрөл.**

**Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд** 5 их наяд 869 тэрбум 455.9 сая.

1.1.Тэтгэврийн даатгалын сан 5 их наяд 360 тэрбум 537.4 сая.

1.2.Тэтгэмжийн даатгалын сан 280 тэрбум 490.8 сая.

1.3.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сан 66 тэрбум 550.9 сая.

Ажилгүйдлийн даатгалын сан 161 тэрбум 876.8 сая.

**Нийт зарлага 5 их наяд 869 тэрбум 455.9 сая.**

Санал хураалт.

84 гишүүн буюу 80 хувиар санал дэмжигдлээ.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг баталсан өдрөөс дагаж мөрдөнө. Санал хураалт.

Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг бүхэлд нь эцэслэн батлах санал хураалт явуулна. Санал хураалт.

79 гишүүн буюу 75.2 хувиар санал дэмжигдлээ.

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зүйл, заалт бүрийг уншиж сонсгож, зүйл тус бүрээр санал хураалт явуулна.

**Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай**

**1 дүгээр зүйл.** Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн дараах зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**1/3 дугаар зүйл:**

**“3 дугаар зүйл.** Эрүүл мэндийн даатгалын санд 2025 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч доор дурдсан хэмжээтэй орлогыг төвлөрүүлнэ:

**Орлогын төрөл.**

**Эрүүл мэндийн сайд 2 их наяд 464 тэрбум 319.6 сая. Үүнээс**

1.1. Ажил олгогч, даатгуулагчаас төлөх шимтгэл 1 их наяд 140 тэрбум 709 сая.

1.2. Төрөөс эрүүл мэндийн даатгалыг нь хариуцах иргэдийн улсын төсвөөс төлөх шимтгэл 352 тэрбум 203.1 сая.

1.3. Төр хариуцах тусламж, үйлчилгээний санхүүжилт 921 тэрбум 575.9 сая.

1.4. Бусад даатгуулагчаас төлөх шимтгэл 49 тэрбум 831.5 сая.

**Нийт орлого 2 их наяд 464 тэрбум 319.6 сая.**

**2/5 дугаар зүйл:**

**“5 дугаар зүйл.** 2025 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч доор дурдсан хэмжээтэй төсвийг зарцуулна:

**Эрүүл мэндийн сайд 2 их наяд 242 тэрбум 447.3 сая.**

1.1.Эрүүл мэндийн даатгалын сангаас хариуцах тусламж, үйлчилгээний санхүүжилт 963 тэрбум 729.3 сая.

1.2.Төрөөс хариуцах тусламж, үйлчилгээний санхүүжилт 1 их наяд 93 тэрбум 641.5 сая.

1.3.Эмийн санд олгох 171 тэрбум 86.6 сая.

1.4.Үйл ажиллагааны урсгал зардал 13 тэрбум 989.9 сая.

**Нийт зарлага 2 их наяд 242 тэрбум 447.3 сая.**

Санал хураалт.

78 гишүүн буюу 74.3 хувиар санал дэмжигдлээ.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.  
Санал хураалт.

80 гишүүн буюу 76.2 хувиар санал дэмжигдлээ.

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг бүхэлд нь эцэслэн батлах санал хураалт явуулъя.  
Санал хураалт.

80 гишүүн буюу 76.2 хувиар санал дэмжигдлээ.

Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг бүхэлд нь эцэслэн батлах санал хураалтын дүн 79 гишүүн дэмжсэн байна.

Хуулийн төслүүд батлагдлаа. Улсын Их Хурлын гишүүд, ажлын хэсэгт талархал дэвшүүлье.

Дараагийн асуудалд оръё. Дараагийн асуудалд оръё. Түрүүнд хэлэлцэж байгаад санал хураалт үлдсэн байна. Байнгын хорооны гаргасан горимын саналаар санал хураалт явуулах юм байна тийм ээ. Гишүүд санал хураалтад бэлдье.

86 гишүүн санал хураалтад бэлтгэгдсэн байна.

17.53 цаг

**Одоо Байнгын хорооны саналаар гаргасан горимын саналаар санал хураалт явуулна. Томьёолол танилцуулъя. Санал хураалт.**

**Байнгын хорооноос “Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын санал гаргасныг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.**

78 гишүүн буюу 74.3 хувиар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гаргасан горимын саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Тогтоолын төслийн батлуулах хувилбарыг Төсвийн байнгын хороо бэлтгэн гишүүдэд тараасан байна.

Энэ дахиж санал хураалтад бэлтгэх шаардлагагүй биз дээ? 1 асуудал явж байгаа. Шаардлагагүй эхэлчихсэн явж байгаа. Тийм учраас саналын томьёоллыг танилцуулъя.

Байнгын хорооны саналаар “Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

74 гишүүн буюу 70.5 хувиар санал дэмжигдлээ.

Тогтоолын төслийг баталлаа.

Улсын Их Хурлын гишүүд, ажлын хэсэгт талархал дэвшүүлье. Дараагийн асуудалд орёе.

17.56 цаг

**“Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.**

Төслийн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Төсвийн байнгын хорооны дарга Хассуурийн Ганхуяг танилцуулна.

**Х.Ганхуяг:** Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.4 дэх хэсгийг үндэслэн боловсруулсан “Монгол Улсын 2025 онд төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн Төсвийн байнгын хороо 2025 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсэгт заасны дагуу хэлэлцэн дэмжиж, нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхээр та бүхэнд танилцуулж байна.

Тогтоолын төсөл үйлдвэрийн салбарт гарсан ослоос үүдсэн зарим техник, тоног төхөөрөмж, өргөтгөлийн ажилд зориулсан хөрөнгө оруулалт болон төрийн

үйл ажиллагаа, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангахад чиглэсэн зарим салбарын санхүүжилтийг шийдвэрлэсэнтэй холбогдуулан төрийн худалдан авах үйл ажиллагаа шуурхай зохион байгуулах, төрийн байгууллагад албан хаагчдаас салбарын онцлог, хэрэгцээ шаардлагад нийцүүлж, сургалтын байгууллагадаа байгууллагаас сонгодог байх, уян хатан өрсөлдөөнд суурилсан зарчмыг нэвтрүүлэх, төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх сургалтын зардалд зориулж Удирдлагын академид төсвөөс олгодог санхүүжилтийг тэглэх. Төрийн албан хаагчийн үндсэн цалин, нэмэгдэл урамшуулал, буцалтгүй тусламж, тэтгэмжийг бүх салбарт тэгш шударгаар хэрэгжих байдлаар шинэчлэн зохицуулах арга хэмжээ авч ажиллахыг Монгол Улсын Засгийн газарт даалгах асуудлыг тусгалаа.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх “Монгол Улсын 2025 онд төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулах нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүдээ,

“Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн тогтоолын төслийг баталж өгнө үү.

**Д.Амарбаясгалан:** Баярлалаа. Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье.

Алга байна. Алх цохисон хойно нэр өгчихлөө. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууссан байна.

Одоо Байнгын хорооны саналаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлдье. Гишүүд санал хураалтдаа бэлдье хурууныхаа хээг уншуулъя. Санал хураалт.

Байнгын хорооны саналаар “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.

64 гишүүн буюу 60.4 хувиар санал дэмжигдлээ.

Тогтоолын төслийг баталлаа. Улсын Их Хурлын гишүүдэд талархал дэвшүүлье.

18.01 цаг

**Дараагийн асуудалд оръё. Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай асуудал байна.**



Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22.1.3-д Улсын Их Хурлын дарга энэ хуулийн 22.1.1, 22.1.2-т заасны дагуу ирүүлсэн саналыг нэгтгэн нам, эвслийн бүлэгтэй зөвшилцөж, Байнгын хорооны бүрэлдэхүүний талаарх саналаа нэгдсэн хуралдаанд танилцуулах гэж заасны дагуу “Зарим Байнгын байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг та бүхэнд уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын тогтоол “Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай”

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь заалт, 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

1.Монгол Улсын Их Хурлын гишүүн Болдын Уянгыг Улсын Их Хурлын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлсүгэй.

2.Монгол Улсын Их Хурлын гишүүн Болдын Уянгыг Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн Байнгын хорооны, Дамбын Батлутыг Улсын Их Хурлын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны, Доржсүрэнгийн Үүрийнтуяаг Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны гишүүнээр тус тус баталсугай.

Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Одоо “Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлдье. Гишүүд бүртгэгдсэн байна.

“Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.

73 гишүүн буюу 68.9 хувиар санал дэмжигдлээ.

Тогтоолын төслийг баталлаа.

Тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүд байна уу?

Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Дараагийн асуудалд оръё.

18.04 цаг

**“Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.**

Төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Баярмагнайн Баярбаатар танилцуулна. Индэрт урьж байна.

**Б.Баярбаатар:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу Байнгын хороодоос ирүүлсэн саналыг тусган Төрийн байгуулалтын байнгын хороо “Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж, 2025 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцлээ.

Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы хугацаанд хууль тогтоомжийн биелэлтийг хянан шалгах, хууль тогтоомжийн биелэлтийн үр дагаварт үнэлгээ хийх, тайлан, илтгэл, мэдээлэл хэлэлцэх, төсвийн биелэлтийг хянан шалгах, хяналт шалгалтын бусад асуудал зэрэг нийт 26 асуудлыг төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглаварт тусгасан байна.

“Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулах нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүдээ,

“Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцсэн тогтоолыг баталж өгөхийг та бүхнээсээ хүсье.

**Д.Амарбаясгалан:** Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асууж, үг хэлэх гишүүд нэрээ өгье.

2 гишүүн, Аюушийн Ариунзаяа гишүүн асуулт асууж, үг хэлье.

**А.Ариунзаяа:** Хурлын даргаа сая өмнөх тогтоол дээр тогтоолын төслийг танилцуулахгүйгээр, үг, асуулт явахгүйгээр төрийн албан хаагчийн цалин хөлс, урамшуулал, буцалтгүй тусламж, тэтгэмжийг бүх салбарт тэгш шударгаар тогтоох байдлаар шинэчлэн зохицуулах заалтыг оруулчихжээ. Үүнийг бид нар харин ч эсэргүүцэж Туваан гишүүн ажлын хэсэг ахалж, тогтоолыг буцаасан шүү дээ. Яагаад дахиад оруулаад ирчхэв? Төрийн албаны тухай хуулийг өөрчлөх тэр нөгөө хуулийн төслийг нь бид нар бас буцаалгасан шүү дээ. Улсын Их Хурлын тогтоолд нь ч гэсэн дагачихсан байсныг Туваан гишүүний ажлын хэсэг ажиллаад бид нар буцаасан.

Тэгээд сая дахиад ийм тогтоол ороод ирэх юм. Энэ ямар учир байна? Энэ ердөөсөө бид нар дэмжмээргүй байна. Энэ яагаад ер нь ийм хулгайн аргаар төрийн албан хаагчдынхаа цалин хөлстэй холбоотой асуудлыг байнга ингэж ярьж

байдаг юм бэ? Үхрийн сүүлэн дээр хутга гэдэг шиг болохгүй шүү дээ. Төрийн албаны тухай хуулийг шинэчлэх гэж байгаа бол, төрийн албан хаагчдынхаа энэ асуудлыг ярих гэж байгаа бол тусгайлсан Хууль тогтоомжийн тухай хуулиараа л яв л даа. Яагаад заавал ч үгүй ингээд ийм асуудлуудыг оруулаад байгаа юм бэ? Энэ асуудлыг засахыг хүсэж байна.

**Д.Амарбаясгалан:** Цэндийн Сандаг-Очир гишүүн асуулт асууя.

**Ц.Сандаг-Очир:** Ариунзаяа гишүүний саналтай, үгтэй санал нэг байна. Дагалдуулж орж ирсэн Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг нь буцааж татаж байхад “Авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолыг дагалдуулж орж ирээд ингээд хуулийг нь татсан асуудлыг яг тогтоол дотор оруулж ирээд ингээд цаашдаа төрийн албан хаагчдын цалин, тэтгэвэр, нэмэгдэл хөлс, урамшууллыг адилтгах байдлаар Засгийн газарт үүрэг, чиглэл өгүүлэх ийм тогтоол болсон байна. Энийг бас Их Хурлын дарга анхаараарай.

Хоёр дахь хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар гээд байгаа. Энэ дээр Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо, Инновац, цахим бодлогын байнгын хороо 2 маань сая бидний баталсан хуулиар Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулаад энэ 2 Байнгын хороогоо бид нар өөрчлөөд өөр Байнгын хороонуудад нийлүүлчихсэн байгаа.

Тийм учраас энэ 2 Байнгын хорооны нэр дээр байгаа 10 орчим хяналт шалгалт хийх асуудлуудыг редакцын засвартайгаар эрхлэх Байнгын хороонд нь хариулуулж өгөөрэй гэдгийг бас протоколоор тэмдэглүүлье.

**Д.Амарбаясгалан:** Санал хэллээ. Тэр өмнөх Төсвийн байнгын хорооны тогтоолыг мэдээж сая батлах санал хураалт явуулчихсан. Гэхдээ эцсийн найруулгыг сонсоогүй байгаа. Тэгэхээр гишүүд энэ дээр бас саналтай байгаа учраас дахиж Төсвийн байнгын хороо энэ дээрээ асуудлаа хэлэлцсэний дараа эцсийн найруулгыг Улсын Их Хуралд сонсгох, цааш нь албажуулах ажлыг хийгээд явах нь зүйтэй байх гэж бодож байна. Энд бас эвгүй үг орчихсон байна. Бас тэгшитгэж гэдэг үг орчихоор энэ бас эрсдэл дагуулах зүйл байж болзошгүй байна.

Ингээд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан гишүүд үг хэллээ. Асуулт асууж, үг хэлж дууслаа.

Одоо Байнгын хорооны саналаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлдье. Санал хураалт.

Байнгын хорооны саналаар “Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Улсын Их Хурлын гишүүдэд талархал дэвшүүлье. Дараагийн асуудал.

**“Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.**

Төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Баярмагнайн Баярбаатар танилцуулна. Индэрт урьж байна.

**Б.Баярбаатар:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4 дэх хэсэг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5, 45 дугаар зүйлд заасны дагуу “Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Төрийн байгуулалтын байнгын хорооноос боловсруулж, 2025 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцлээ.

“Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулахдаа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад батлах хугацааг нь хуульд тусгайлан заасан болон Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг оруулна гэж заасны дагуу хэлэлцэх асуудлын жагсаалтад 39 хууль, тогтоолын төслийг тусгасан болно.

Тогтоолын төсөлд Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүд Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн тогтоолын 1 дэх заалтад зааснаас бусад хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслүүдийг Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудлыг тухай бүрд нь Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу шийдвэрлэж байхаар зохицуулсан.

Мөн Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын бэлтгэл хангахыг Улсын Их Хурлын Байнгын хороод, Улсын Их Хурал дахь намын бүлгүүд, Засгийн газар, Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргад тус тус үүрэг болгосон.

“Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулах нь зүйтэй гэсэн саналыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн тогтоолын төслийг батлахыг та бүхнээсээ хүсье.

**Д.Амарбаясгалан:** Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүд нэрээ өгье.

Алга байна.

Одоо Байнгын хорооны саналаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлдье. Санал хураалт.

Байнгын хорооны саналаар “Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

74 гишүүн буюу 69.8 хувиар санал дэмжигдлээ.

Тогтоол батлагдлаа. Улсын Их Хурлын гишүүдэд талархал дэвшүүлье.

18.14 цаг

**Дараагийн асуудал. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.3-д Улсын Их Хурал энэ хуулийн 46.1.2-т заасан хууль тогтоолын эцсийн найруулгатай танилцаж, ёсчлохыг зөвшөөрөх гэж заасны дагуу хууль, тогтоолын эцсийн найруулгыг Байнгын хороод бэлтгэж, Улсын Их Хуралд танилцуулахад бэлэн болсон байна.**

1.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026 оноос 27 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу.

Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

1.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Дагалдан гарсан.

2.Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

2.“Алт-3 аяныг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Аюушийн Ариунзаяа гишүүн.

**А.Ариунзаяа:** Алт-3 энэ хөтөлбөртэй холбоотой авах арга хэмжээний тухай тухайн үед хэлэлцэж байхад та Үндсэн хууль зөрчсөн байж магадгүй зүйл, заалтууд байна гэж хэлж байсныг санаж байна. Энэ дээр ямар нэгэн дүгнэлт гарсан болов уу, үгүй болов уу гэдэг ийм асуулт байна. Мөнхбаясгалан гишүүн ч гэсэн бас их ноцтой зүйл, заалтуудыг хэлж байсан. Тэгэхээр яг энэ дээр Улсын Их Хурлын Тамгын газраас хууль зөрчиж байгаа юу, үгүй юү гэдэг лавлагааг хийсэн бол үүнтэй танилцаж эцсийн найруулгыг сонсох саналтай байна.

**Д.Амарбаясгалан:** Ариунхур дарга тайлбар өгөх үү. 1 дүгээр микрофон.

**Ч.Ариунхур:** Тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийн явцад уг заалтыг Байнгын хороодын гишүүдийн гуравны хоёрын саналаар дахин хураалгахад уг санал дэмжигдээгүй тул анхны хэлэлцүүлэгт орсон, анхны хэлэлцүүлгээр дэмжигдсэн санал төсөлд тусгаж орж ирсэн байгаа. Байнгын хороо дахиж хэлэлцээд энийг эргэж ярих шаардлагагүй гэж үзсэн гэсэн үг.

**А.Ариунзаяа:** Ариунзаяа гишүүн би Улсын Их Хурлын гишүүдийн юу гэж үзэж байгаа вэ гэдэг нь бол тухайн хүмүүс хуулийн мэдлэггүй байх магадлалтай учраас яг Улсын Их Хурлын Тамгын газар яг энэ зүйл, заалтуудтай холбоотой Үндсэн хуулийн зөрчил үүсэх үү, үгүй юү гэдэг энэ лавлагааг мэргэжлийн хүмүүсийн хувьд өгөөсэй гэж хүсэж байна. Тухайн Байнгын хорооны гишүүдийн хувьд яг Үндсэн хуулийн зөрчил мөн үү, үгүй юү гэдгийг яг хууль, эрх зүйн мэдлэг дутмаг байхыг бол үгүйсгэхгүй учраас үүн дээр бас мэргэжлийн хүмүүс нь тодорхой зөвлөмж өгөхгүй бол энэ өөрөө маш их эрсдэлтэй. Байгалийн баялаг бол мэдээж иргэдийн өмч гэдэг юм уу иргэдэд хамааралтай. Тухайн гэхдээ олборлолт хийж байгаа сумд өгөөжийн дийлэнх нь очих ёстой гэдэг ийм агуулга өөрөө зөрчил үүсгэж байгаа юу, үгүй юү гэдэг 1 асуулт байгаад байна.

Хоёр дахь нь болохлоор ер нь Улсын Их Хурлаар координатыг өөрчлөх.

**Д.Амарбаясгалан:** Бид тогтоолын эцсийн найруулгыг сонсож байгаа нэгдүгээрт. Хоёрдугаарт Үндсэн хууль зөрчиж байгаа эсэхээр Тамгын газар шууд тайлбар хийх боломжгүй. Цэц өөрөө тайлбар, зөрчсөн бол Цэц дээр дүгнэлт нь гарна. Мэдээж эцсийн найруулгатай холбоотой асуудал дээр санал хэлсэн учраас Тамгын газар бас Ариунзаяа гишүүний хэлсэн асуудал дээр анхаарч ажиллах нь зөв байх гэж бодож байна. Тэгээд эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

1.Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Харьяатын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Дагалдан гарсан

Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Хот байгуулалтын тухай хуулийн хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Дагалдан гарсан

Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Дагалдан гарсан



Банкны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Агаарын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

4.Усны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

5.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Автотээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Жолоочийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.



Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

“Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэл, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

“Төрийн үйлчилгээнд процессын дахин инженерчлэл хийх ажлыг эрчимжүүлэх талаар чиглэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

“Зээлийн хүүг бууруулах хүрээнд авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Энэ үү? Энийг хойшлуулна. Төсвийн байнгын хороо дахиж хуралдаж тогтоолоо эцэслэсний үндсэн дээр эцсийн найруулгыг уншина.

“Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Алга байна.

“Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

“Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Дараагийн асуудал ингээд дуусаж байна тээ? Санал хураалт дууссан.

18.23 цаг

## Чуулганы хаалт.

Эхэлье.

Эрхэм хүндэт ард иргэд, эрхэм хүндэт Улсын Их Хурлын гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүд тангараг өргөж ажилдаа орсноос хойш даруй 1 жил өнгөрлөө. Амжиж бүтээсэн, алдаж оносноо эргэн харах, цаашдын ажлаа бодитой, оновчтой эрэмбэлэх мөч тохиож байна. 126 гишүүнтэй шинэ парламентын 9 дэх бүрэн эрхийн хэрэгжиж эхэлсэн 1 жилийн хугацаанд нийтдээ 144 хууль, 146 тогтоолыг бид хэлэлцэн баталсан байна.

Үүнээс 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд 66 хууль, 59 тогтоол хэлэлцэн баталлаа.

Эрхэм хүндэт иргэд ээ,

Ард түмний төлөөлөл болсон Улсын Их Хурал олон түмнээ байнга сонсож байх ёстой төрийн эрх барих дээд байгууллагын шийдвэр өргөн олонд хүлээн зөвшөөрөгдөхийн үндэс нь ард түмнийхээ итгэл сэтгэл, хүсэл эрмэлзлийг мэдэрч, ойлгох явдал байдаг. Тиймээс Улсын Их Хурлын даргын хувьд парламентыг олон ургалч үзэлд тулгуурлах, ил тод нээлттэй байх, хүн төвтэй ойлголцол, зөвшилцлийг баримтлахад нэн тэргүүнд анхаарч ажиллалаа.

Энэ удаагийн 5 нам эвслээс бүрдсэн Улсын Их Хурал нь парламентын ардчиллын үндэс суурийг гүнзгийрүүлэн бэхжүүлж, ард түмний төлөөллийн дуу хоолой болсон Улсын Их Хурлын институтын хараат бус байдал, шийдвэр гаргах чадамж, хариуцлагын тогтолцоог улам төгөлдөржүүлснээр бид Монгол Улсын парламентын засаглалыг бодит утгаар нь баталгаажуулж чадаж байна.

Энэ бол зөвхөн сонгуулийн мөчлөгийн үр дүн бус ардчиллын замыг тууштай баримтлагч Монголын төр, нийгмийн олон институтүүдийн хамтын хүчин чармайлтын үр дүн юм.

Улсын Их Хурал намрын чуулганаар баталсан 2024-28 оны стратеги төлөвлөгөөндөө ил тод, нээлттэй, хүртээмжтэй байх, иргэдийн оролцоог хангах үнэт зүйлийг онцлон тусгасан билээ.

Түүнчлэн хүн төвтэй хууль буюу хүний эрхийг дээдэлсэн хүн төвтэй үзэл санаа бүхий байх, цаг үеийн шаардлагад нийцсэн хууль буюу нийгмийн хурдацтай хөгжлийн шаардлагад нийцүүлэн эрх зүйн зохицуулалт хийх цаг алдалгүй гаргадаг байх, иж бүрэн зохицуулалттай ойлгомжтой хууль буюу хуулийг тодорхой, ойлгомжтой болгож, хууль болон журмаар зохицуулах харилцааны заагийг тодорхойлох гэсэн эрх зүйн 3 орчны 3 төгөлдөршил-ийн бодлогыг хэрэгжүүлэх үндэс суурь болсон төр төвтэй хуулиас хүн төвтэй хууль руу шилжих, хуулиас давсан журмыг цэгцлэх, хууль ба журмын зохист харилцааг хангах эрх зүйн үндсийг Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар бий болгож чадлаа.

Тодруулбал, журам батлах нэрээр хуулиар тогтоосон иргэний эрх зүйн байдлыг дордуулдаг явдал цаашид үгүй болно. Журам зөвхөн хуулийг хэрэгжүүлэх, зохион байгуулалтын арга хэмжээ авах зорилгоор батлагддаг болно. Мөн өөрийн чиг үүрэгт нь хамааралгүй байхад журам баталдаг явдал үүгээр таслан зогсоогдоно.

Түүнчлэн хүний эрхийн ноцтой зөрчил, хүнд суртал, авлига албан тушаалын хэрэг бий болох боломжийг үгүй хийж, Засгийн газарт чиглэл болгож, 350 орчим хууль, дагасан журмуудыг цэгцлэх Улсын Их Хурлын тогтоолыг баталсан.

Намрын ээлжит чуулган эхлэх хугацааг наашлуулж, 9 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлүүлж, төсөв хэлэлцэх хэлэлцүүлгийн үе шатыг шинээр нэмж, 4 байсныг 5 үе шаттай болгож өөрчилсөн.

Ингэснээр Улсын Их Хурлын гишүүд тойрогтоо төсвийн төслийг мэргэжлийн байгууллага, ард иргэдийн дунд олон талын оролцоог хангаж илүү нухацтай хэлэлцэх эрх зүйн орчин бүрдэж чадсан.

Парламентыг илүү нээлттэй, иргэддээ ойр байлгах зорилгоор Нээлттэй парламент 2025 хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн. Энэ хөтөлбөрөөрөө оюутан залуус болон ахмад үеийн төлөөллийг парламентын үйл ажиллагаанд хамруулан мэдлэг, туршлага солилцож, шинэ сэтгэлгээний гүүрийг бүтээх ахмадын арвин туршлагыг хослуулахыг зорин ажиллаж ирлээ.

Эдгээр хөтөлбөрүүдэд залуу, ахмад үеийг идэвхтэй хамруулахын зэрэгцээ хууль тогтоох ажиллагааны бэлтгэл хангагдаж ажилласан Улсын Их Хурлын Тамгын газрын хамт олонд мөн талархал илэрхийлье.

Эрхэм хууль тогтоогчид оо,

Та бид төрийнхөө сүлдэнд тангараг өргөж байсан мөч саяхан. Бидэнд хийх ажил их, ард түмний хүлээлт өндөр байгаа тул үлдэж буй 3 жилийн хугацаанд илүү үр бүтээлтэй ажиллах хэрэгтэй.

Шинээр бүрдсэн парламентад гишүүд эзэмшсэн мэргэжил, хуримтлуулсан туршлагаар онцгойрон ялгарч, хэлэлцэж буй мэргэжлийн нарийн ээдрээ, төвөгтэй асуудалд жинхэнэ мэргэжлийн байр сууриас хандах арга барил, уур амьсгал маш чухал байлаа.

Түүнчлэн Улсын Их Хурлын өмнөх бүрэн эрхийн хугацаанд хэлэлцэж батлаагүй хууль, тогтоолын төслүүдийг хууль санаачлагчид нь буцаасанд тооцдог зохицуулалттай тул гишүүд ажлын гүн рүү даруй орох чиг үүргээ шуурхай хэрэгжүүлж эхлэх хэрэгцээ шаардлага байсныг энд дурдах нь зүйтэй.

Тиймээс Улсын Их Хурлын даргын хувьд хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд гишүүдийн санал, бодлыг харгалзан мөн зарим гишүүдэд тухайлан итгэл хүлээлгэн ачаа үүрүүлж, ажлын хэсгүүдэд хуваарилан ажиллуулсан.

Эдгээр ажлын хэсгүүд нь хууль, бодлогын баримт бичиг боловсруулах, тухайн салбарын ажлын гүнд орж нарийвчлан танилцах зэрэг чиг үүргийг

хэрэгжүүлж

ажиллажээ.

Асуудлыг судалж, дүгнэх Засгийн газар болон холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах замаар хуулийн төслүүдийг боловсруулж батлуулах, санал, дүгнэлт танилцуулах зэргээр бодит үр дүнд хүрсэн ажлын хэсгүүдийг ахалсан болон түүнд орж ажилласан нийт гишүүддээ талархал дэвшүүлж байна.

Улсын Их Хурлын гишүүдийн ахалсан ажлын хэсгүүд Хууль тогтоомжийн тухай, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон хөдөө аж ахуйн анхдагч хууль, хуулийн төсөл зэрэг олон хууль, тогтоолуудыг өргөн мэдүүлж хэлэлцүүлэн батлуулаад байна.

Түүнчлэн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль тогтоомжийг шинэчлэх, хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хангах талаар хууль тогтоомжийг боловсронгуй болгох, Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийг боловсронгуй болгох, стандартын эрх зүйн орчныг шинэчлэх асуудлаар холбогдох яам, байгууллагуудтай хамтран ажилласны дүнд эдгээр хуулийн төслүүдийг хэлэлцүүлэхээр Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлээд байна.

Үүний зэрэгцээ өнөөгийн аж ахуй, арилжаа, бизнесийн эрх зүйн харилцааг зохицуулж байгаа 23 жилийн өмнө батлагдсан Иргэний хуулийн хэрэгжилтийг судалж танилцах, санал, дүгнэлт боловсруулах ажлын хэсэг идэвх санаачилгатай ажиллаж энэ хуулийн хэрэгжилтийн өнөөгийн нөхцөл байдлын талаар 40 гаруй судлаач, хуульчдын багаар томоохон хэмжээний судалгаа хийлгэж, үр дүнтэй ажиллаж чаджээ.

Энэхүү судалгааны үр дүнд хэлэлцүүлгийн шатад байгаа Арилжааны тухай хуулийг хэлэлцэхэд үнэтэй хувь нэмэр болно гэдэгт эргэлзэхгүй байна. Одоо мөрдөгдөж байгаа эрүүл мэндийн үйлчилгээний санхүүжилтийн арга нь тоо хэмжээнд тулгуурласан тэр хэрээр эмнэлгүүдэд эдийн засгийн сонирхол төрүүлж байгааг эрс өөрчлөх ёстой. Мөн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарт үндэслэн санхүүжилт олгох загварыг бий болгох шаардлагатай байна.

Тиймээс эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, эрүүл мэндийн даатгалын тогтолцоог оновчтой болгох, хүнс, эмийн хяналт, зохицуулалтын тогтолцоог боловсронгуй болгох 3 ажлын хэсэг байгуулан ажиллаж, эрүүл мэндийн асуудлаарх эдгээр ажлын хэсгүүд салбарын мэргэжилтнүүдийн санал бодлыг сонсох ажил хийж, үүсээд байгаа асуудлын учир шалтгааныг олох чиглэлээр олон ажил хийж, олон эрдэмтэд, судлаачдыг оролцуулан санал, дүгнэлтээ боловсруулан танилцуулаад байна.

Тухайлбал, хаврын чуулганы хугацаанд эдгээр ажлын хэсэг нийт 178 удаа хуралдаж, олон нийт, мэргэжилтнүүдийн дунд 46 хэлэлцүүлгийг зохион байгуулсан үр дүнтэйгээр ажиллажээ. Тодруулбал, төрийн албаны эрх зүйн орчныг боловсронгуй болгох, татварын хууль тогтоомжийг шинэчлэх, төр, хувийн хэвшилтэй өрсөлдөхгүй байх зарчмын хүрээнд холбогдох эрх зүйн орчныг боловсронгуй болгох, Монгол хүний амьдралын чанарыг дээшлүүлэх, хүн амын өсөлтийг дэмжих асуудлаар холбогдох хууль, тогтоомжийн хэрэгжилтийг

эрчимжүүлэх Холбоо сангийн тухай хуулийн төслийг боловсруулах, Гэр бүлийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох, шүгэл үлээх журмын талаарх эрх зүйн орчныг бий болгох ажлын хэсгүүдийг онцлон дурдъя.

Өндөр бүтээмжтэй төрийн албыг хөгжүүлэхэд талуудын идэвх чармайлт, харилцан ойлголцол нэн чухал байдаг. Үүнийг хурдасгах, түлхэц өгөх зорилгоор Улсын Их Хурлын даргын захирамжаар төрийн үйлчилгээний процессын дахин инженерчлэлийн талаар санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан ажиллаж, процессын дахин инженерчлэлийн ажлын үр дүнтэй зохион байгуулах, нэгдсэн ойлголт, арга зүйн удирдлагаар хангах зорилгоор тогтоолыг хэлэлцэн баталсан.

Төрийн албаны эрх зүйн орчныг боловсронгуй болгоход Улсын Их Хурал дээр байгуулагдсан ажлын хэсэгтээ шийдэл, хувилбар, санаа оноогоо хуваалцсан нээлттэй солилцон хамтран ажиллаж намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан Засгийн газраас хуулийн төслийг өргөн мэдүүлэх нь зүйтэй байна.

Аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа төрийн тодотголтой хуулийн этгээдүүдийн удирдлага, зохион байгуулалтыг шинэчлэн сайжруулж, үр ашиг ил тод байдлыг нэмэгдүүлж, зардал бууруулах, компаниудыг хувьчлах, татан буулгах ажлыг эрчимжүүлэх шаардлагатайг энд онцлон тэмдэглэн хэлье.

Эдгээр ажлын хэсгийн ахлагч нар үр дүн гаргахын төлөө асуудалдаа төвлөрч, гишүүдийнхээ оролцоог идэвхжүүлж шаардлагатайг тухайлан сануулан хэлье. Мөн ажлын хэсгүүдэд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх ажлыг эрчимжүүлэхийг Улсын Их Хурлын Тамгын газарт даалган хэлье.

Эрхэм гишүүд ээ,

Хүртээмжтэй байх, иргэдийн оролцоог хангах, хариуцан тайлагнадаг байх нь Улсын Их Хурлын үнэт зүйлийн билээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд та бүхэн чуулганы завсарлагааны хугацаанд баталсан хууль тогтоомжоо сонгогч түмэндээ ойлгуулан таниулах ажлыг идэвхтэй хийж, хэлэлцүүлгийн шатад байгаа болон боловсруулж буй хуулийн төслүүдийн талаар иргэд, олон нийттэй нээлттэй санал солилцож, тэдний дуу хоолой, төлөөлөл байх эрхэм үүргээ нэр төртэй биелүүлэхийг хүсье.

Эх нутаг болон дэлхийн өнцөг булан бүрд аж төрөн суугаа эрхэм хүндэт Монголчууд аа,

Та бүхэндээ Тулгар төрийн 2234 жил, Их Монгол Улсын 819 жил, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 114 жил, Ардын хувьсгалын 104 жил, Ардчилсан хувьсгалын 35 жилийн ой, Үндэсний их баяр наадмын мэндийг өргөн дэвшүүлье.

Монгол түмний минь хийморь, сүлд өөдөө байж, эх орон маань энх амгалан орших болтугай.

Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулган хаасныг мэдэгдье.

18.34 цаг

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ  
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

*Д.ОТГОНДЭЛГЭР*

